

МОНГОЛ УЛС ДАХ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Судалгааны тайлан



Улаанбаатар хот, 2025

Тайланг хүлээлцсэн:

Эхний хувилбарыг илгээсэн (#1)	17/03/2025
Захиалагч талаас санал ирсэн (#1)	21/03/2025-24/03/2025
Сайжруулсан хувилбарыг илгээсэн (#2)	25/03/2025
Эцэслэгдсэн хувилбарыг илгээсэн (#3)	20/04/2025
Хаанаас: IRIM судалгааны баг	Хаана: ЖАЙКА Монгол дах төлөөлөгчийн газар

Товчилсон үгийн жагсаалт

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БЗД	Баянзүрх дүүрэг
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХНХЯ	Гэр бүл, Хөдөлмөр, Нийгэм хамгааллын яам
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ДЗМОУБ	Дэлхийн зөн Монгол ОУБ
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ЖҮХ	Жендэрийн Үндэсний Хороо
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЛГБТК+	Лесби, гей, бисекс, трансжендер, куи болон бусад
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
НЦУГ	Нийслэлийн цагдаагийн удирдах газар
НҮБХАС	НҮБ-ын Хүн амын сан
ОНОТХҮ	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
ОУБ	Олон улсын байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (IOM)
ОУЭЗХБ	Олон улсын эрх зүйн хөгжлийн туслалцааны байгууллага (IDLO)
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ТХБ	Түр хамгаалах байр
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХГБХХЕГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХТЭТ	Хүйсийн тэгш эрхийн төв
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШҮХ	Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	2
Дүрс, хүснэгтийн жагсаалт.....	4
Хураангуй	6
Удиртгал	11
Судалгааны арга зүй.....	12
Гол үр дүнгүүд.....	15
Бүлэг 1. Монгол Улс дахь жендэрийн тэгш байдал.....	15
Бүлэг 2. Монгол Улс дахь ЖСХ-ийн нөхцөл байдал.....	19
Бүлэг 3. ЖСХ-тэй тэмцэх хариу арга хэмжээ	25
3.1. ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа.....	25
3.2 Хохирогч хамгааллын үйлчилгээ.....	33
3.3 Нөхөн сэргээх үйлчилгээ	51
3.4 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	60
Бүлэг 4. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж	76
Дүгнэлт.....	87
Ашигласан материалууд.....	89
Хавсралт	93
Хавсралт 1. ЖСХ-ийн даван туулагчдад үйлчилгээ үзүүлж буй ТББ-ын мэдээлэл	93
Хавсралт 2. ТХБ, НЦҮТ-ийн жагсаалт	97
Хавсралт 3. ГБХ, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө	98

Дүрс, хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Мэдээлэл цуглуулалтын арга ба түүврийн бүтэц.....	12
Хүснэгт 2. Жендэрийн Зөрүүтэй Байдлын Индекс, Монгол Улс, 2024	15
Хүснэгт 3. Жендэрийн үндэсний хорооны олон талт хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд	17
Хүснэгт 4. ЖСХ-тэй холбоотой нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, оноор	19
Хүснэгт 5. Дархан-Уул болон Хэнтий аймгууд дахь ЖСХ-тэй холбоотой нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, оноор.....	20
Хүснэгт 6. Хохирогч, даван туулагчдын хүчирхийллийн шалтгааныг нэрлэсэн байдал (n=50).....	21
Хүснэгт 7. ЖСХ-тэй тэмцэх салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг эрчимжүүлэх ажлын хамрах хүрээ.....	28
Хүснэгт 8. ЖСХ-ээс сэргийлэх ажлын сул тал, сорилтууд, цаашид сайжруулах арга замын талаарх оролцогчдын санал бодол.....	30
Хүснэгт 9. ЖСХ-ийн хохирогчид үзүүлж буй хамгааллын үйлчилгээний төрөл.....	34
Хүснэгт 10. ТХБ, НЦҮТ төвийн тоо, оноор.....	36
Хүснэгт 11. Сүүлийн 5 жилийн хугацаанд ТХБ/НЦҮТ-ийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	36
Хүснэгт 12. Үйлчилгээ авсан насанд хүрсэн үйлчлүүлэгчийн тоо, 2022-2024	36
Хүснэгт 13. 2024 онд НЦҮТ, ТХБ-аас үйлчилгээ авсан насанд хүрэгчдийн тоо, төрлөөр, давхардсан тоогоор	36
Хүснэгт 14. ТХБ, НЦҮТ-ийн үйлчилгээний багтаамж, түүний хүрэлцээтэй байдлыг тооцохтой холбоотой тоон мэдээллүүд.....	37
Хүснэгт 15. Судалгаанд хамруулсан ТХБ-уудын мэдээлэл.....	42
Хүснэгт 16. Судалгаанд хамруулсан ТХБ-уудын үйлчилгээ үзүүлсэн хүний тоо, 2023-2024	42
Хүснэгт 17. Түр хамгаалах байрны санхүүжилтийг зохицуулж буй журмууд.....	43
Хүснэгт 18. НЦҮТ, ТХБ-ны ялгаа.....	45
Хүснэгт 19. Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээ үзүүлэх үндсэн 6 зарчим	47
Хүснэгт 20. Нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх талуудын чиг үүрэг	51
Хүснэгт 21. ЖСХ-ийн хохирогчид үзүүлж буй нөхөн сэргээх үйлчилгээний төрөл.....	52
Хүснэгт 22. Нийгмийн халамжийн тухай хуульд заасан Монгол Улсад үйлчилж буй халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнүүд.....	56
Хүснэгт 23. ЖСХ-ийн хохирогчдод үзүүлэх нийгмийн халамжийн ОНОТХ-ийн үйлчилгээний жагсаалт	57
Хүснэгт 24. ЖСХ-тэй холбоотой гэмт хэрэг, зөрчлүүд.....	60
Хүснэгт 25. ЖСХ-тэй холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэх талуудын үүрэг	61
Хүснэгт 26. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогч голлох талуудын үүрэг	61
Хүснэгт 27. “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтууд	62
Хүснэгт 28. “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаа” нэр томъёоны хуулийн тодорхойлолт	65
Хүснэгт 29. ХТЭТ-ийн хохирогчид үзүүлж буй үйлчилгээ.....	94
Хүснэгт 30. ХТЭТ-ийн түр хамгаалах байрны мэдээлэл.....	94
Хүснэгт 31. ХТЭТ-ийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн үйл ажиллагаа	95
Хүснэгт 32. Талита Ази ТББ-ын хамгаалах байрнуудын мэдээлэл.....	96

Дүрс 1. Тоон судалгааны түүврийн задаргаа, n=50	13
Дүрс 2. Тоон судалгаанд оролцогчдын насны тархалт, n=50	13
Дүрс 3. Тоог судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, n=50	
Дүрс 4. Хөдөлмөр эрхлэлтийн байдал	14
Дүрс 5. ГБХ-д өртсөн хохирогчдын өртсөн хүчирхийллийн төрөл	
Дүрс 6. Хүчирхийллийн давтамж	14
Дүрс 7. Жендэрийн үндэсний хорооны бүтэц	17
Дүрс 8. Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт	26
Дүрс 9. ЖСХ-ийн хохирогчид хамгааллын үйлчилгээг үзүүлж буй механизм	33
Дүрс 10. Хамтарсан багийн бүтэц, чиг үүрэг	34
Дүрс 11. Хохирогч хамгааллын үйлчилгээний эрх зүйн орчин, түүний хэрэгжилтийг үнэлсэн байдал, 1-5 хүртэлх шкалаар үнэлүүлэв (1 маш муу, 5 маш сайн)	35
Дүрс 12. Даван туулагч төвтэй арга зүйг үйлчилгээнд баримталж буй байдал, n=50	48
Дүрс 13. ЖСХ-ийн хохирогчид үзүүлж буй хохирогч хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээний ерөнхий зураглал	51
Дүрс 14. Судалгаанд оролцогчдын авсан нөхөн сэргээх үйлчилгээ, давхардсан тоогоор (n=50)	52
Дүрс 15. Үйлчлүүлэгчид гарсан өөрчлөлт: Үйлчилгээний өмнөх, дараах байдал, (n=50)	53
Дүрс 16. Нөхөн сэргээх үйлчилгээний эрх зүйн орчин, түүний хэрэгжилтийг үнэлсэн байдал, 1-5 хүртэлх шкалаар үнэлүүлэв (1 маш муу, 5 маш сайн)	53
Дүрс 17. ЖСХ-ийн хохирогчдод эрүүл мэндийн тусламж үзүүлсэн байдал, эмнэлгийн шатлалаар (n=104)	54
Дүрс 18. 2023 онд Улсын хэмжээнд ОНОТХҮ-г үзүүлсэн нийт хүний тоо	57
Дүрс 19. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны процесс	63
Дүрс 20. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат	64

Хураангуй

Монгол Улс дахь жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)-ийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээний хэрэгжилтийг тодорхойлж, цаашид Олон улсын байгууллагуудын (ОУБ) зүгээс анхаарах чиглэлүүдийг санал болгох зорилгоор энэхүү судалгааг IRIM судалгааны хүрээлэнгийн баг 2024 оны 12 сараас 2025 оны 4 сарын хооронд гүйцэтгэлээ.

Судалгаа нь ЖАЙКА ОУБ-ын бүсийн стратегийн баримт бичигт тусгасан 4Р хүрээ буюу урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, хэрэг хянан шийдвэрлэх үндсэн чиглэлүүдийн дагуу хийгдсэн. Судалгааны бүх үе шатанд хохирогч/даван туулагч төвтэй хандлагыг баримталж, ёс зүйн зарчмуудыг чанд мөрдөхийг эрхэмлэв.

Мэдээлэл цуглуулалтад тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан ашиглаж, 100 орчим оролцогчоос анхдагч мэдээллийг цуглуулсан. Үүнд:

- Хохирогч хамгааллын үйлчилгээнд хамрагдсан 10 даван туулагчтай гүнзгийрүүлсэн кейс ярилцлага;
- Төрийн, төрийн бус байгууллага (ТББ), ОУБ-ын 33 төлөөлөлтэй хагас бүтэцлэгдсэн ярилцлага;
- Түр хамгаалах байр (ТХБ), Нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ)-өөр үйлчлүүлсэн 50 оролцогчоос асуумжийн аргаар тоон мэдээллийг цуглуулав. Хот, хөдөөгийн нөхцөл байдлыг харьцуулан тодорхойлох үүднээс судалгааны анхдагч мэдээлэл цуглуулалтыг Улаанбаатар хот, Дархан-Уул, Хэнтий аймгуудад зохион байгуулав.

Баримт бичгийн судалгааны хүрээнд сүүлийн таван жилийн хугацааны холбогдох төрийн байгууллагуудын статистик мэдээлэл, тоон өгөгдөл, эрдэм шинжилгээний судалгаа, хууль эрх зүйн баримт бичиг, байгууллагуудын тайлангуудыг нэгтгэн шинжилгээ хийв. Баримт бичгийн судалгааны үр дүнг анхдагч мэдээлэлтэй тулган баталгаажуулсан үр дүнгүүдийг энэхүү судалгааны тайланд тусгалаа.

Судалгааны гол үр дүнгүүдийг тоймловол:

Монгол Улс 1924 оны анхны Үндсэн хуульдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгш, шударга хандах зарчмыг тунхаглаж, адил тэгш хандах талаар баталгаажуулж байснаас үзэхэд Монгол Улс жендэрийн тэгш байдлыг хууль эрх зүйн орчиндоо эхэн үеэс тусгасан улс орнуудын нэг аж. Ялангуяа, боловсрол, эрүүл мэндийн салбарт хүний суурь эрх, тэгш оролцоог хангах байдал бусад улс орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр түвшинд хүрсэн. Тухайлбал, Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр тооцож гаргадаг жендэрийн ялгаатай байдлын үзүүлэлтээр (Gender Gap Index) 2024 онд Монгол Улс боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлтээр 146 улсаас 1-р байранд, харин эдийн засгийн оролцооны хувьд 43-т, эмэгтэйчүүдийн улс төрийн эрх мэдлийн хувьд 120-р байр эзэлж буй нь зарим салбарт жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагаас үүдэлтэй зөрүү байгааг харуулж байна. Эдгээр зөрүүг арилгахын тулд эмэгтэйчүүдийн эдийн засаг, улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, дундаж наслалтыг сайжруулах чиглэлээр үндэсний хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

Хэдийгээр эрх зүйн орчинд ЖСХ-ийн хэлбэр, үйлдлийг тодорхой тусгасан хэдий ч уг тодорхойлолт, түүнд хамаарах зарчмын дагуу мэдээлэл цуглуулах, ангилах байдал Монголд төдийлөн сайн төлөвшөөгүй байна. ЖСХ-ийн бүртгэгдсэн тохиолдол сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж, 2024 онд нийт 12,932 хэрэг бүртгэгдсэн нь сүүлийн таван жилийн хугацаанд 20%-иар өссөн үзүүлэлт юм. Энэ өсөлт улсын хэмжээнд ажиглагдаж байгаа ч хөдөө орон нутагт бүртгэгдсэн тохиолдлын өсөлт илүү өндөр хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Гэвч гэмт этгээд болон хохирогчдын талаарх нарийвчилсан мэдээлэл цагдаа, шүүх зэрэг холбогдох байгууллагуудын түвшинд бүрэн бүртгэгддэггүй тул холбоотой үзүүлэлтүүдийг нарийвчлан ангилж задалж, шинжилгээ хийх боломж хязгаарлагдмал байна.

Мөн ЖСХ-ийн эдийн засгийн нөлөөг тооцох нь чухал бөгөөд дотны хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллээс үүдэн өрхөд учрах санхүүгийн хохирол нь төрөөс хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний зардлаас 24 дахин их байна (НҮБХАС, 2020). Өөрөөр хэлбэл, ЖСХ-ээс үүдэлтэй айл өрхөд учирч буй санхүүгийн алдагдал нь улс орны эдийн засагт нөлөөлөхүйц байгаа нь харагдаж байна.

Хэдийгээр Монгол Улсад ЖСХ-тэй тэмцэх үүрэг бүхий олон хороо, зөвлөлүүд байгаа боловч бүтэц зохион байгуулалтын үр ашиггүй, уялдаа холбоо сул, төсөл, хөтөлбөрөөс хараат санхүүжилттэй байгаа нь оролцогч талуудын үйл ажиллагааны үр нөлөөг бууруулж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны тайланд дурдсанаар, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын 94.1% нь эмэгтэйчүүд болон охид бөгөөд тэдний ихэнх нь хамтрагч эсвэл эхнэр/нөхрийн зүгээс бие махбодын хүчирхийлэлд (73.6%) өртөж, жилд хамгийн багадаа 1-2 удаа (80.3%) хүчирхийлэлд өртдөг байна. ЖСХ-ийн шалтгааныг өмнөх судалгаанууд архины хэрэглээ өндөр, санхүүгийн тогтворгүй байдал, жендэрийн хэвшмэл ойлголт, хандлага зэрэг хүчин зүйлүүдтэй холбон тайлбарлаж байсан бол сүүлийн үеийн судалгаагаар хүүхэд насандаа хүчирхийлэлд өртсөн байдал, гэр бүлийн боловсрол, мөн бага насанд олгох жендэрийн тэгш байдлын мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа зэргийг онцолж байна.

ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх байдал: Хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахад урт хугацааны, системтэй арга хандлагаар хүүхдийн зан төлөв төлөвшиж эхлэх бага наснаас нь боловсрол, хөгжлийн үйл ажиллагаагаар дамжуулан нөлөөлөх нь чухал. Гэвч Монгол Улсад урьдчилан сэргийлэх арга хэмжээний зохион байгуулалт нь **цар хүрээний хувьд хязгаарлагдмал, хэрэгжилт тогтворгүй бөгөөд насны онцлогийг харгалзсан** арга барил ихээхэн дутагдалтай. Мөн гэрлэлтийн өмнөх боловсрол, ажлын байран дахь зан төлвийн өөрчлөлтийн хөтөлбөрүүд, зорилтот бүлгүүдийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлууд дутмаг байгаа нь хүчирхийлэлгүй нийгмийг бий болгох чадавхыг сулруулсаар байна.

Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд урьдчилан сэргийлэх боловсролыг үндэсний бодлогын баримт бичгүүдэд тусгах, агуулгыг нийгмийн олон ялгаатай бүлгүүдэд нийцүүлэн боловсруулж, тогтвортой механизмыг бэхжүүлэх шаардлагатай байна. ОУБ-даас хэрэгжүүлсэн 'Community-Based Behavior Change Communication', 'SASA Together', 'Respect Framework' зэрэг олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх кампанит ажлууд, стратегиуд, туршилтын хөтөлбөрүүд нь тодорхой эерэг үр дүнд хүрсэн байх боловч, тэдгээрийн цар хүрээ төслийн хүрээгээр хязгаарлагдаж, тогтвортой үргэлжлүүлэх байдал нь төрийн оролцоо, эзэмшил, нөөцөөс хамааралтай байна. Эдгээр санаачилгуудыг өргөжүүлэх, сайн туршлагуудыг албажуулж, институцчилэх байдал хангалттай биш байна. Одоогийн нөлөөллийн ажлууд ихэвчлэн насанд хүрэгчдэд чиглэсэн бөгөөд хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэхэд эрт үеийн боловсролын ач холбогдлыг чухалчилсан ажлууд дутагдалтай байна. Мөн гэмт этгээдүүдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх системтэй хөтөлбөрүүд хангалтгүй байгааг онцлох нь зүйтэй.

Хохирогч хамгааллын нөхцөл байдал: ТХБ, НЦҮТ-ийн тоог нэмэгдүүлэх, мэргэжилтэн албан хаагчдыг чадавхжуулахад чиглэсэн ОУБ-ын (АХБ, НҮБХАС зэрэг) техник туслалцааны төслүүдийн үр дүнд сүүлийн 5 жилийн хугацаанд хамгаалах байрны хүртээмж 30%-аар нэмэгдэж, өнөөдрийн байдлаар ЖСХ-ийн хохирогч/даван туулагчдад хамгааллын үйлчилгээ үзүүлэх 40 ТХБ, НЦҮТ улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр төвүүд нь жилд дунджаар 5000 орчим хүчирхийлэлд өртсөн хүүхэд, насанд хүрэгчдэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг.

Хохирогч хамгааллын үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчинд ахиц дэвшил гарсан хэдий ч ТХБ-уудын үйлчилгээ, үйл ажиллагаанд томоохон хүндрэл учруулж буй хэд хэдэн шийдвэрлэх шаардлагатай асуудлууд судалгааны үр дүнд тодорхойлогдсон. Үүнд:

- **Харьяаллаас хамаарсан санхүүжилтийн ялгаатай байдал:** ТХБ, НЦҮТ-үүд нь харьяаллын хувьд 5 өөр байгууллагад хамаардаг. Аль байгууллагын харьяанд байгаагаас хамааран санхүүжилтийн эх үүсвэр ялгаатай байгаа нь үйл ажиллагааны тогтвортой байдал, үйлчилгээний чанарт нөлөөлж байна. Хэдийгээр ТХБ, НЦҮТ-ийн санхүүжилт, норм нормативыг тодорхойлсон журам байгаа ч энэ нь зөвхөн Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ)-ны харьяа ТХБ-уудад хамаарч, бусад байгууллагуудын хамгааллын үйлчилгээнд нэг мөр хэрэгжихгүй байна.
- **Насанд хүрсэн ЖСХ-ийн хохирогчид үзүүлж буй үйлчилгээний зардлын эх үүсвэрийн асуудал:** Практик дээр насанд хүрсэн ЖСХ-ийн хохирогчдод зориулсан санхүүжилт дутагдалтайгаас хүүхэд хамгааллын зардлаас хоол, хүнсний хэрэгцээг нөхөх тохиолдол гарч

- байна. Энэ нь насанд хүрэгчдэд үзүүлэх хамгааллын үйлчилгээний хүртээмжийг хязгаарлаж, тэднийг хүлээн авах хандлагад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.
- **Хамгааллын үйлчилгээний стандартыг нарийвчлах хэрэгцээ.** Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нийтлэг шаардлага мөрдөгдөж байгаа ч хохирогчдын тусгай хэрэгцээ, онцлогт нийцүүлэн үйлчилгээний стандартыг нарийвчлах, үйлчилгээ үзүүлэгчдэд мөрдөх арга зүйг тодорхой болгох, стандарт шаардлагыг шинэчлэх, дараагийн шатанд гаргах шаардлага тулгарч байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ЛГБТК+ бүлгийн хохирогчдод зориулсан хамгааллын үйлчилгээний хүртээмж хангалтгүй, үйлчилгээнд тавигдах стандарт, удирдамж үйлчилгээ үзүүлэгчдэд шаардлагатай байна.
 - **Хохирогч хамгааллын үйлчилгээний талаар олон нийтийн ойлголт сул хэвээр байна.** ТХБ-аар үйлчлүүлсэн хүмүүсийн дийлэнх нь цагдаагийн албан хаагчаас мэдээлэл авч ТХБ-нд ирсэн байх бөгөөд үйлчлүүлэгчдийн хамгаалах байр, НЦҮТ-өөс ямар үйлчилгээ, тусламж авах боломжтой талаар ойлголт сул байна.
 - **ЖСХ-ийн хохирогчдод үзүүлэх хамгааллын үйлчилгээ нь аюулгүй байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй боловч хамгаалах байрны орчин нөхцөл, тохижилт хангалтгүй байна.** ТХБ-уудын дэд бүтэц, ариун цэврийн нөхцөл, тав тухын байдал муу, урсгал засвар хийгдээгүйгээс орчин нөхцөл тааруу байгааг сайжруулах санал үйлчлүүлэгчдээс хамгийн олон давтамжтай гарч байв.
 - **Хамгаалах байранд боловсрол, хөгжлийн үйлчилгээ нэн дутагдалтай байна:** Хамгаалах байраар үйлчлүүлж буй иргэдийн дундаж байрлах хугацаа 1-2 долоо хоног ба нэг сар, түүнээс дээш хугацаагаар байрлах тохиолдол ч түгээмэл байна. Гэвч энэ хугацаанд хохирогчдод цагийг үр дүнтэй өнгөрүүлэх сургалт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөр, хөдөлмөрийн дадал эзэмшүүлэх, хөгжлийн үйл ажиллагаанд хамруулах байдал ихээхэн дутмаг байна.
 - **Хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлж буй ИНБ-ын тоо цөөн, иргэд олон нийт, даван туулагчид хоорондоо нэгдэх, олон нийтийн дэмжих бүлэг бага байна.** Хохирогчийн аюулгүй байдлыг хангах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг ТББ-уудын жагсаалтад ердөө 10 хүрэхгүй байгууллага нэрлэгдсэн. Эдгээр байгууллагууд нь олон жилийн туршлагатай, тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа ч энэ чиглэлд шинээр байгуулагдаж буй ТББ маш цөөн байна. Ялангуяа орон нутагт хохирогч хамгааллын чиглэлээр ажилладаг ИНБ цөөн бөгөөд судалгааны талбар болох Хэнтий аймагт энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг нэг ч байгууллага байхгүй байв.

Хохирогчийг нөхөн сэргээх үйлчилгээний нөхцөл байдал: Монгол Улсад ЖСХ-ийн хохирогчдод үзүүлж буй нөхөн сэргээх үйлчилгээ нь эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн халамжийн үйлчилгээ гэсэн үндсэн чиглэлүүдээр хүрч байгаа боловч судалгааны үр дүнгээс харахад эдгээр **үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүн харилцан адилгүй** байна. Одоогийн нөхөн сэргээх үйлчилгээ голчлон **богино хугацаанд, анхан шатны тусламж, дэмжлэг үзүүлэхэд төвлөрч байгаа бөгөөд урт хугацааны нөхөн сэргээх, хамгаалах байрнаас гарсны дараа нийгмийн амьдралд эргэн нэгтгэхэд чиглэсэн дэмжлэг хангалтгүй** байна. Нөхөн сэргээх үйлчилгээний нөхцөл байдлыг авч үзвэл:

- **Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай хүргэх байдал сул:** ТХБ, НЦҮТ-үүд нь орон тооны эмчтэй байх нь харилцан адилгүй бөгөөд ихэнх НЦҮТ, ТХБ-ууд харьяа Өрхийн Эрүүл мэндийн төв (ӨЭМТ)-ийн эмч нартай гэрээ байгуулж, эмч нар тогтсон өдрүүдэд ирж үзлэг хийх байдлаар ажилладаг. Хамгаалах байрнуудад мэргэжлийн эмчийн орон тоо хангалтгүйгээс гэрээт эмчийн зохион байгуулалт нь эмнэлгийн үйлчилгээг цаг тухайд нь шуурхай авах боломжийг бууруулдаг байна.
- **Сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг дэх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж сайн:** ЖСХ-ийн хохирогчдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг бий болгоход, аюулгүй мэдрэмж төрүүлэх, өөрийгөө буруутгах хандлагыг бууруулахад сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэг ихээхэн үр дүнтэй байсныг үйлчилгээ авсан иргэд онцолж, үйлчилгээний сэтгэл ханамж өндөр байгаагаа илэрхийлсэн. Гэсэн хэдий ч сэтгэл зүйчдийн ажлын ачаалал, орон тооны хүрэлцээнээс хамаарч нэг хохирогчид зарцуулах хугацаа харилцан адилгүй байх, орон нутгийн сэтгэл зүйч нар хөдөө орон нутаг, суманд ажиллаж байгаа үед аймгийн төв дээрх үйлчилгээ тасалдах зэрэг хүндрэлүүдтэй тулгардаг байна.

- **Халамжийн үйлчилгээг ЖСХ-ийн хохирогчдод үзүүлэх байдал хязгаарлагдмал:** Халамжийн тухай хуулийн 18.2-т хүчирхийлэлд өртсөн иргэдэд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн 5 төрлийн үйлчилгээг үзүүлэх зохицуулалттай боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Нэг жилийн хугацаанд ТХБ, НЦҮТ-өөр үйлчлүүлсэн нийт иргэдийн 17-20 хувь нь л хөдөлмөр, халамжийн үйлчилгээнд холбон зуучлуулсан байх ба тэдгээр иргэдийн дийлэнх нь хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүнс тэжээлийн дэмжлэг болон асаргааны тэтгэмжинд хамрагдсан байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдсан тохиолдол 2024 онд улсын хэмжээнд ердөө 30 кейс бүртгэгджээ. Эдгээр тоо баримт нь хөдөлмөр, халамжийн үйлчилгээ нь үндсэндээ тэтгэмжийн хэлбэрээр хязгаарлагдаж, хүчирхийллийн хохирогчдыг бие даан амьдрах ур чадвар олгох, чадавхжуулах, урт хугацааны нөхөн сэргээх үйл ажиллагаа дутмаг байгааг харуулж байв.
- **ЖСХ-ийн даван туулагчдад урт хугацаанд тулгарч буй томоохон сорилт нь ТХБ-аас гарсны дараах орон байрны асуудал.** Хохирогч хамгаалах байрнаас гарсны дараа амьдрах байргүй бол богино хугацаанд (1) Хамаатан садан, найз нөхдийндээ байрлах, (2) зээл тавьж түр хугацааны түрээсийн байр олох зэрэг сонголтуудыг хийж байгаа ч эдгээр нь тогтвортой шийдэл болж чадахгүй буцаад хүчирхийлэлтэй орчиндоо очих нь түгээмэл байна. Даван туулагчдын дийлэнх нь "ТХБ-аас гарсны дараах шилжилтийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь уг асуудлыг даван туулах үр дүнтэй арга болохыг илэрхийлсэн. Өнөөгийн байдлаар ТХБ-аас гарсны дараа хохирогчдод байрлах байртай холбоотой үзүүлж буй ямар нэг хувилбарт үйлчилгээ, дэмжлэг байхгүй тул уг асуудлыг системийн түвшинд шийдвэрлэх, судлах, турших хэрэгцээ шаардлага зайлшгүй байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл байдал: Прокурорын байгууллага нь хэрэг үйлдсэн байж болзошгүй этгээдүүдийг хуулийн хариуцлагад татах, хохирогчдын эрх ашгийг хамгаалж, шударга ёсыг хангуулах үүргийг гүйцэтгэдэг. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад ЖСХ-тэй холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэх хууль, эрх зүй болон институцийн түвшинд тодорхой ахицууд гарсан. Тухайлбал, ЖСХ-тэй холбоотой хэд хэдэн хууль, журмыг баталж, гэр бүл, хүүхдийн эрхийн чиглэлээр дагнасан шүүх байгуулахаар шийдвэрүүд гарсан. Гэсэн хэдий ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шийдвэрлэх шаардлагатай хэд хэдэн асуудал тулгамдаж байна.

- **Хууль эрх зүйн орчин дахь зөрүү, хуулийг нэр мөр ойлгох байдалд тулгарч буй асуудал:** Монгол Улсын Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийн бүх хэлбэрийг тодорхой заагаагүй бөгөөд "байнга" гэх нэр томъёог хууль тогтоомжийн хүрээнд харилцан адилгүй тайлбарладаг. Мөн хүн худалдаалахтай холбоотой гэмт хэргүүд, тухайлбал, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргүүдийг тусад нь зүйлчилдэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны уялдаа, тодорхой байдлыг алдагдуулж байна.
- **Гэр бүлийн хүчирхийллийн зөрчилд оноох шийтгэлүүд үр дүн багатай:** Одоогийн мөрдөгдөж буй шийтгэлийн хэлбэрүүд (7-30 хоног баривчлах, албадан сургалтад хамруулах) нь ихэнхдээ хүчирхийллийн үндсэн шалтгааныг шийдвэрлэхгүй, гэмт этгээдийн зан үйлд урт хугацааны эерэг өөрчлөлт авчрахгүй байна. Богино хугацаанд хууль эрх зүйн мэдлэг олгох, зөвхөн түр хугацааны арга хэмжээ авах нь хүчирхийллийн давтамжийг бууруулахад үр дүн багатай юм. Түүнчлэн, торгууль болон хорих ялын санхүүгийн дарамтыг ихэвчлэн хохирогч эсвэл гэр бүлийн хэн нэг гишүүн үүрч байгаа нь хохирогчийн сэтгэл санаа, эдийн засгийн хохиролыг улам нэмэгдүүлж байна.
- **Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч/даван туулагч төвтэй хандлагыг хэрэгжүүлэх байдал дутмаг байна:** Цагдаа болон хууль сахиулах байгууллагын албан хаагчид ЖСХ-ийн хэргийг шалгах явцад хохирогчид дэмжлэг үзүүлэх хандлагаар бус уламжлалт мөрдөн шалгах арга барилаар ажиллах нь түгээмэл хэвээр байна. Тухайлбал, хохирогчдоос олон удаа давтан мэдүүлэг авах нь тэдний сэтгэл зүйн хямралыг нэмэгдүүлж, мөрдөн байцаалтын явцыг удаашруулахад нөлөөлдөг. Уг асуудал зарим албан хаагчдын дунд хэвээр, мөрдөн шалгах практикт давтан тохиолдсоор байна.
- **Шүүх шинжилгээний үйлчилгээний хүртээмжинд тулгарч буй бэрхшээл:** ДНХ-ийн шинжилгээ хийх бүсийн лаборатори байхгүйгээс Улаанбаатар хотын төв лабораторийн ачаалал хэт өндөр байна. Үүний улмаас нотлох баримт цуглуулах, шинжлэх ажил удааширч,

шинжилгээний найдвартай байдалд сөргөөр нөлөөлж, хэргийг шийдвэрлэх үйл явцыг хүндрүүлж байна.

- **Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо сул:** Гэрч, хохирогчийн нууцыг хамгаалах хууль эрх зүйн зохицуулалт байгаа ч хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, эмнэлгийн ажилтан, нийгмийн ажилтан, ТХБ-ны ажилтнууд зэрэг үйлчилгээ үзүүлэгчид шүүх хуралдааны явцад ил гардаг нь тэдний хувийн мэдээлэл задрах эрсдэлийг дагуулж байдаг. Энэ нь тэднийг гэмт этгээдүүдийн заналхийлэл, өшөө авалтад өртөх нөхцөлд оруулах эрсдэлтэй юм.
- **Хохирогчийг таньж илрүүлэх, дэмжлэг үзүүлэхэд тулгардаг бэрхшээлүүд:** Хөдөө орон нутагт хууль сахиулах байгууллагын албан хаагчид ЖСХ-ийн, тэр дундаа хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг таньж илрүүлэх мэдлэг, чадавх хангалтгүй байна. Хохирогчийг эрт илрүүлэх стандартчилагдсан аргачлал, нөөц бололцоо дутмаг байгаагаас хохирогчийг анзаарахгүй өнгөрөөх, эсвэл зүй бус хандлагаар хандах тохиолдлууд гарсаар байна.
- **Шүүгч, хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хүртээмж хангалтгүй:** ЖСХ-тэй холбоотой хэргүүдийг хэрэг хянан шийдвэрлэх чадавхыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлууд хийгдэж байгаа ч шүүгч, прокурор, цагдаагийн албан хаагчдын чадавхыг сайжруулах, тогтвортой, мэргэшсэн сургалтаар хангах хэрэгцээ өндөр байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй болгохын тулд хууль сахиулах байгууллагын албан хаагчдад тасралтгүй, үе шаттай сургалтын тогтолцоог нэвтрүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

Удиртгал

Энэхүү судалгааг IRIM судалгааны хүрээлэнгийн баг 2024 оны 12-р сараас 2025 оны 4-р сарын хооронд Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-ын захиалгаар гүйцэтгэв.

Судалгааны зорилго нь Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийллийн (ЖСХ) өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээний хэрэгжилтийг судлах, цаашид олон улсын байгууллагуудын анхаарах шаардлагатай чиглэлүүдийг санал болгоход оршино.

Үүний тулд судалгаа нь бүхэлдээ холимог судалгааны арга зүйд суурилсан бөгөөд тоон болон чанарын судалгааны аргуудыг ашиглаж, анхдагч мэдээллийг цуглуулж, хоёрдогч эх сурвалжийн өгөгдөлтэй нэгтгэн шинжилгээ хийсэн. Мэдээлэл цуглуулах үйл явцад **даван туулагч төвтэй** (survivor-centered) хандлагыг баримталж, ялангуяа даван туулагчдад сөрөг үр дагавар үүсэхээс сэргийлэх зорилгоор ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж ажиллав.

Судалгааны үр дүн нь Монгол Улсад ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах механизмыг бэхжүүлэхэд олон улсын байгууллагууд, тэр дундаа ЖАЙКА-ийн техникийн туслалцааны чиглэлийг тодорхойлоход суурь мэдээлэл болох юм.

"Жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх" нь ЖАЙКА ОУБ-ын стратегийн тэргүүлэх чиглэлийн нэг бөгөөд энэ чиглэлд даван туулагчдад үзүүлэх тусламж, дэмжлэгийг өргөжүүлэх, үйлчилгээний байгууллагуудын чадавхыг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах замаар даван туулагчдыг нийгэмд эргэн нэгтгэх боломжийг нэмэгдүүлэхийг зорьдог. Түүнчлэн, ЖСХ-ээс урьдчилан сэргийлэхийн тулд олон нийтийн хандлага, зан үйлийн өөрчлөлтөд эергээр нөлөөлөхөд чиглэсэн ажлуудыг хэрэгжүүлэхийг зорьдог.

Судалгааны арга зүй

Судалгааны зорилго, зорилт: Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улс дахь ЖСХ-ийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, төр, төрийн бус, олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний үр нөлөөг судалсны үндсэн дээр цаашид олон улсын байгууллагууд, тэр дундаа ЖАЙКА-ийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн суурь чиглэлийг тодорхойлох явдал байв. Энэ хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэв:

- ЖСХ-ийн тархалт, хэлбэр, суурь шалтгааныг тодорхойлох;
- ЖСХ-тэй тэмцэхэд чиглэсэн хууль эрх зүйн орчин дахь зөрүүтэй байдлыг тодруулах;
- ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр төр, төрийн бус, олон улсын байгууллагуудын оролцоо, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон тэдгээрийн үр нөлөөг үнэлэх;
- Хохирогч хамгааллын үйлчилгээний хүртээмж, тулгамдаж буй бэрхшээл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;
- ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг сайжруулахад чиглэсэн нотолгоонд суурилсан бодлогын зөвлөмж боловсруулах.

Судалгааны дизайн: Мэдээллийг цуглуулахдаа тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулсан холимог арга зүйг ашигласан. Судалгааны хүрээг тодорхойлох, арга зүйг боловсруулах, дүн шинжилгээ хийх бүх үе шатанд ЖАЙКА-ийн бүс нутгийн стратегид тусгагдсан “4P” буюу Урьдчилан сэргийлэх, Хамгаалах, Нөхөн сэргээх, Хэрэг хянан шийдвэрлэх хандлагыг суурь болгон баримталсан.

Мөн мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх явцад даван туулагч төвтэй хандлагыг мөрдөж, мэдээллийн нууцлалыг хангах, оролцогчдыг сайн дурын үндсэн дээр судалгаанд хамруулах, судалгааны явцад үүсэж болзошгүй сэтгэл зүйн сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг ёс зүйн зарчмуудыг чанд мөрдөж судалгааг гүйцэтгэсэн болно.

Судалгааны хүрээ: Судалгааны явцад ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр үүрэг хүлээсэн төрийн, төрийн бус, олон улсын байгууллагын холбогдох төлөөлөл болон үйлчилгээ авсан иргэдийн хувьд 18 ба түүнээс дээш насны иргэдээс тус тус анхдагч мэдээллийг цуглуулсан. Үүнээс гадна:

- **Цаг хугацааны хувьд:** Сүүлийн таван жилийн хугацаанд бүртгэгдсэн ЖСХ-ийн зөрчил, гэмт хэрэг, хууль эрх зүйн шинэчлэл, хариу арга хэмжээнд төвлөрөв.
- **Газар зүйн хамрах хүрээ:** ЖСХ-ийн тохиолдлын түвшин харьцангуй өндөр, мөн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа идэвхтэй явагддаг байдлыг харгалзан мэдээлэл цуглуулалтыг Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүд, Дархан-Уул, Хэнтий аймгуудад зохион байгуулав.
- **Зорилтот бүлэг:** Хохирогч хамгааллын үйлчилгээ авсан иргэдээс гадна бодлого боловсруулагчид, үйлчилгээ үзүүлэгчид, хууль сахиулах байгууллагуудын төлөөлөл болон бусад холбогдох талуудыг хамруулав.

Мэдээлэл цуглуулалтын арга ба түүвэр: Судалгаанд анхдагч болон хоёрдогч мэдээллүүдийг хослуулан ашигласан. Анхдагч мэдээлэл цуглуулах үйл явцад нийтдээ 100 орчим талууд оролцсон бөгөөд дараах хүснэгтэд дэлгэрэнгүйг харуулав.

Хүснэгт 1. Мэдээлэл цуглуулалтын арга ба түүврийн бүтэц


Анхдагч мэдээлэл цуглуулалт	Хоёрдогч мэдээлэл цуглуулалт
Судалгаанд дараах тоон болон чанарын аргуудыг хослуулан анхдагч мэдээллийг цуглуулсан: 1. Кейс судалгаа – ЖСХ-ийн хохирогч 10 даван туулагчтай гүнзгийрүүлсэн ярилцлага хийж, хамгаалах байраар үйлчлүүлсэн туршлагыг нь тодруулсан. Тухайн даван туулагчид судалгаанаас үүдэлтэй сэтгэлзүйн нөлөөлөл учруулахаас зайлсхийхийн тулд хүчирхийлэлд өртсөн түүхээс илүү үйлчилгээний хүртээмж, үр нөлөөнд төвлөрч ярилцлагыг зохион байгуулав.	Судалгаанд дараах хоёрдогч эх сурвалжийн мэдээллүүдийг цуглуулж, анхдагч мэдээллүүдтэй нэгтгэн шинжилгээнд ашиглав. • Сүүлийн 5 жилийн хугацаанд хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны тайлангууд • Төр болон ТББ-аас ажиллуулдаг хамгаалах байр, НЦҮТ-ийн тайлан, статистик мэдээлэл

2. Хагас бүтэцлэгдсэн ярилцлага – ЖСХ-ийн хариу арга хэмжээнд оролцдог төрийн байгууллага, ТББ, хууль сахиулах байгууллага, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч болон олон улсын байгууллагуудын төлөөлөл бүхий нийт 33 ярилцлага хийв. 3. Тоон судалгаа – Сүүлийн таван жилийн хугацаанд түр хамгаалах байраар үйлчлүүлсэн 50 иргэнээс үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой судалгаа авсан.	- ЖСХ-тэй холбоотой хууль, тогтоомж, бодлогын баримт бичиг - ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр хэрэгжиж буй үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, мэдээ
--	--

Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн шинж: ТХБ-аар үйлчлүүлсэн нийт 50 эмэгтэйдээс тоон асуумжийн аргаар үйлчилгээний чанартай холбоотой судалгаа авсан. Тоон мэдээлэл цуглуулалтыг БЗД, СХД, Дархан, Хэнтий болон ЦЕГ-ын харьяа ТХБ-аар сүүлийн 5 жилийн хугацаанд үйлчилгээ авсан, иргэдийн дунд зохион байгуулсан бөгөөд татгалзлын хувь өндөр байх, утасны дугаар нь өөрчлөгдсөн, холбогдох боломжгүй байх хүндрэл нийт эх олонлогт түгээмэл тохиолдож байв. Судалгааны түүврийн төлөөллийг Дүрс 1-д харуулав.

Дүрс 1. Тоон судалгааны түүврийн задаргаа, n=50

■ Улаанбаатар хот ■ Дархан-Уул ■ Хэнтий



Судалгаанд хамрагдсан 50 оролцогчид нь бүгд сайн дураар судалгаанд хамрагдахыг зөвшөөрч мэдээлэл өгсөн бөгөөд мэдээлэл цуглуулалтыг биечлэн болон утсаар, тухайн оролцогчийн илүүд үзсэн арга хэлбэрээр зохион байгуулсан.

Судалгаанд харьцангуй нас насны төлөөлөл жигд хамрагдсан. Боловсролын түвшний хувьд дийлэнх нь бүрэн дунд боловсролтой, 20% гэрлэлтээ цуцлуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн хувьд 30% нь ямар нэг шалтгаанаар ажил эрхэлдэггүй. Боловсролын түвшнээс гадна гэр бүлийн орчин дахь хардалт, хяналтаас үүдэн

ажил хийдэггүй, ажлаас гарсан гэсэн шалтгаанууд ярилцлагын явцад цөөнгүй дурдагдаж байв. Мөн ажил эрхлэхгүй байхад нөлөөлж буй удаах шалтгаан нь олон хүүхэдтэй, нялх хүүхэдтэй, хүүхдүүдийн асаргаанаас болж ажил эрхэлдэггүй гэсэн шалтгаан нийтлэг байв.

Оролцогчдын хамгаалах байранд байрласан дундаж хоног нь 17. Тэдгээрийн 52% нь нэг долоо хоног байрласан бол, 30% нь урт хугацаагаар буюу 1 сараас дээш хугацаагаар байрласан байна.


Дүрс 2. Тоон судалгаанд оролцогчдын насны тархалт, n=50

■ 18-20 ■ 20-29 ■ 30-39 ■ 40-49 ■ 50-59




Дүрс 3. Тоог судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, n=50

■ Бичиг үсэг тайлагдаагүй ■ Бага
■ Дунд ■ Бүрэн дунд
■ Мэргэжлийн боловсрол ■ Дээд



Дүрс 4. Хөдөлмөр эрхлэлтийн байдал


■ Ажил эрхэлдэг ■ Оюутан/Сурдаг
■ Тэтгэвэрт ■ Ажилгүй
■ Ажиллах боломжгүй




Судалгаанд оролцогчдын 92% (n=46) нь гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ)-д, үлдсэн нь бэлгийн хүчирхийллийн хохирогчид байсан. Хүчирхийллийн хэлбэрүүдийг авч үзвэл бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд 80-100% нь өртөж, 20-30% нь гэр бүлийн орчинд эдийн засаг болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид байв.

Хүчирхийлэл нэг удаа тохиолдсон гэж хариулсан хүн зөвхөн 10% нь л байсан бол үлдсэн 90% нь хүчирхийлэл давтамжтай үйлдэгдсэн, ингэхдээ нэг жилээс урт хугацаанд үргэлжилсэн нь нийт оролцогчдын 60%-ийг эзэлж байна.

Дүрс 5. ГБХ-д өртсөн хохирогчдын өртсөн хүчирхийллийн төрөл



Дүрс 6. Хүчирхийллийн давтамж



Гол үр дүнгүүд

Бүлэг 1. Монгол Улс дахь жендэрийн тэгш байдал

1924 оны БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуульд эмэгтэй, эрэгтэй хүмүүст тэгш шударга хандах талаар 'Тус улсын харьяат ард түмэнд угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино' хэмээн тусгасан нь 1992 оны Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөний агуулгаар илүү өргөн хүрээгээр хадгалагдан үлдсэн байдаг. Үүний дагуу 2011 онд 'Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай' хуулийг баталж уг хуулийн 4.1.1-т "'жендэр" гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлага' хэмээн тодорхойлсон байна. 'Жендэр' хэмээх энэхүү нэр томъёо нь Монгол Улсад шинээр хэрэглэгдэж эхэлсэн тул уг хуулийг хэрэгжүүлж эхлэх үед талуудын дунд энэхүү ойлголтыг зөвхөн эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах хэмээн хязгаарлагдмал байдлаар ойлгож ирсэн ч, хуулийн хүрээнд авч хэрэгжүүлсэн 10 гаруй жилийн ажлын үр дүнд ойлголт харьцангуй сайжирсаар байна.

Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны мэдээлснээр Монгол Улс 2023 оны байдлаар нийт 3,504,741 хүн амтай бөгөөд, хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 96.2 болжээ. Хүн амын хүйсийн харьцааг насны бүлгээр авч үзвэл 0-31 хүртэлх насны бүлэгт 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүд 100-аас илүү байгаа бол 32 ба түүнээс дээш насны бүлэг 100-аас багассан зүй тогтолтой байна.¹ Хүн амын дундаж наслалтыг хүйсээр авч үзвэл эрэгтэй (67.6 жил), эмэгтэй (75.7) хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 2000 онд 5.7 жил байсан бол 2023 онд 9.3 жил болж өсчээ. Энэхүү дундаж наслалтын зөрүүнд гарч буй өсөлт нь нийгмийн, биологийн болон тогтолцооны хувьд жендэрээс хамаарсан тэгш бус байдал байгааг илтгэх нэг чухал үзүүлэлт юм.

Дэлхийн Эдийн Засгийн Форумгаас жил болгон гаргадаг 'Дэлхийн жендэрийн зөрүүтэй байдлын индекс' ('Gender Gap Index') нь эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, улс төрийн оролцоо гэсэн 4 бүлэгт хамаарах шалгуур үзүүлэлтүүдээр жендэрийн ялгаатай байдлыг үнэлдэг. 2024 оны 'Gender Gap Index'-д дурдсанаар Монгол Улс нийт үзүүлэлтээр 146 улсаас 85-р байранд эрэмбэлэгдэж байна.

Хүснэгт 2. Жендэрийн Зөрүүтэй Байдлын Индекс, Монгол Улс, 2024

Эрүүл мэнд ба наслалт		1	Боловсрол эзэмшилт		1
Төрөлт дэх хүйсийн харьцаа**%		1	Бичиг үсэг тайлагдалтын хувь%		1
Эрүүл дундаж наслалт**жилээр		1	Бага боловсролд хамрагдалт%		1
			Бүрэн дунд боловсролд хамрагдалт%		1
			Дээд боловсролд хамрагдалт%		1
Эдийн засгийн оролцоо боломж		43	Улс төрийн эрх мэдэл		120
Ажиллах хүчний оролцооны хувь %		71	УИХ дахь эмэгтэйчүүд %		108
Ижил төрлийн ажилд ижил цалин хөлс олгож буй байдал		41	Сайдын албан тушаалд буй эмэгтэйчүүд %		112
Олсон орлогын тооцоолсон дүн (олон улсын харьцуулалтаар) \$ 1,000		88	Эмэгтэй/Эрэгтэй төрийн тэргүүнтэй байсан он жилүүд (сүүлийн 50)		76
Хууль тогтоогчид, ахлах албан тушаалтнууд болон менежерүүд %		31			
Мэргэжлийн болон техникийн ажилтнууд %		1			

Дөрвөн бүлэг асуудал нь Монгол Улсад харилцан адилгүй байгаа бөгөөд боловсрол болон эрүүл мэндийн хувьд 1-рт эрэмбэлэгдэж жендэрийн хувьд зөрүүтэй байдал маш бага гэж үнэлэгдсэн бол эдийн засгийн оролцоо болон боломжийг харуулах үзүүлэлтүүдийн хувьд 43-рт, улс төрийн эрх мэдлийн хувьд 120-д тус тус эрэмбэлэгдэж, зөрүүтэй байдал их байгааг илтгэж байна.² Энэхүү индексийн дагуу гаргасан эрэмбэ нь Монгол Улсад боловсрол, эрүүл мэнд зэрэг суурь эрхүүд нь

¹ Үндэсний Статистикийн Хороо. (2023). *Монгол Улсын хүн ам* [Mongolian population]. https://downloads.1212.mn/B_91aCJc5yyt0pCQW69Yw-F1FeSA3SF-

² World Economic Forum. (2024). *Global gender gap report 2024* (Insight report). https://www3.weforum.org/docs/WEF_GGGR_2024.pdf

жендэрийн хувьд эрх тэгш хангагдаж чадаж байгаа ч, улс төр, эдийн засгийн орчинд эрх мэдлийн тэнцвэрт бус байдал, нийгэмд эзлэх байр суурийг бий болгох жендэрийн хэвшмэл үзэл хүчтэй хэвээр байгааг харуулж байна.

Жендэрийн Үндэсний Хороо (ЖҮХ)-оос 2024 онд хийсэн 'Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөллийн судалгаа'-ны тайланд дурдсанаар хэдийгээр шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хандлага нэмэгдэж байгаа ч, гэр бүлийн түвшин дэх хөдөлмөрийн жендэрийн хуваарьт хэвшмэл үзэл өөрчлөгдөхгүй байгааг онцлон дурджээ. Тухайлбал, удирдах ажлыг эмэгтэй хүн эрхэлж чадна гэдэгт үл итгэх хандлага 2021 оны түвшнээс (16.7%) 2.5 хувиар буурч 2024 онд 4.2 хувьд нь болсон бөгөөд үүнтэй адилаар манлайллын хувь эрэгтэйчүүдэд итгэх бүрэн итгэлтэй байдал (43.5%) нь эмэгтэйчүүдтэй харьцуулахад (27.7%) мэдэгдэхүйц өндөр байна. Мөн иргэдийн 40 гаруй хувь нь гэрийн ажлын үүргийг эмэгтэйд, тэжээх үүргийг эрэгтэйд оноох тогтсон хандлагатай ба 2021 оноос хойш мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна гэжээ. Энэ мэт судалгааны үр дүн нь эрх мэдлийн хуваарилалтын талаар хэвшмэл үзэл байсаар байгааг харуулж байна.

Эдийн засаг, улс төрийн хувьд эрх мэдлийн тэнцвэрт бус байдал үүсэх нь олон хэлбэрийн хүчирхийлэл үүсэх үндсэн шалтгааны нэг болж байдаг учраас жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлд эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд хараат бус байх, улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд нэн тэргүүнд анхаарах нь чухал. Нэн ялангуяа, хөдөлмөр эрхлэлтийн түвшин болон сарын дундаж цалингийн зөрүүг багасгах, төрийн шийдвэр гаргалтад болон улс төрийн албан тушаалд хүйсийн тэнцвэрт оролцоог хангах шаардлага харагдаж байна. Үүнээс гадна жендэрийн тэгш бус байдлыг харуулах индексийг тооцоход шаардлагатай цалингийн зөрүү, компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь, анхны хүүхдээ гаргаж буй эмэгтэйчүүдийн дундаж нас, асрахуйн ажилд зарцуулж буй цаг зэрэг зарим суурь мэдээлэл хангалтгүй байгаа нь 'Gender Gap Index'-ийн тайлангаас харагдаж байна. Мэдээлэл дутмаг байдал нь жендэрийн эрх тэгш байдлыг илрүүлэх, зөв тодорхойлоход саад болох юм.

Дундаж наслалтын зөрүүтэй байдлыг арилгах чиглэлд Монгол Улсын Ерөнхий сайдын 71 дүгээр захирамжаар 'Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)'-г баталсан. Уг төлөвлөгөөний хүрээнд хөвгүүд, эрэгтэйчүүдийн дунд эрүүл зан үйл, амьдралын дадал хэвшлийг сайжруулах, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх, осол гэмтлээс шалтгаалсан зуурдын нас баралтыг бууруулах, хүйсээр ангилсан мэдээллийг сайжруулах 4 гол зорилтын хүрээнд үндэсний хэмжээнд арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Харин эдийн засгийн боломж, улс төрийн оролцооны хувьд гарч буй тэгш бус байдлыг арилгах чиглэлд буй гол хөтөлбөр нь ЖҮХ-оос 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 2 дугаар тогтоолоор баталсан 'Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)' юм. Уг стратеги төлөвлөгөө нь салбар хороо болон салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг чиглүүлэх гол баримт бичиг бөгөөд эдгээр салбар хороо болон салбар зөвлөлүүд нь өөрсдийн эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, шаардагдах зардлыг шийдвэрлэн хэрэгжүүлж ажиллах үүрэг хүлээж байна. Энэхүү салбар дундын стратеги төлөвлөгөө нь дараах үндсэн 5 зорилгоос бүрдэж байна.

1. Охид, хөвгүүд, эмэгтэй, эрэгтэй хүмүүст эрүүл, аюулгүй амьдрах, сурч боловсрох тэгш боломж бүрдүүлнэ.
2. Эдийн засгийн хүрээнд жендэрийн тэгш боломж, тэгш оролцоог дэмжинэ
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог хөгжүүлнэ.
4. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлнэ
5. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход жендэрийн тэгш оролцоог хангана.

2031 он хүртэл хэрэгжүүлэх энэхүү стратегийн төлөвлөгөөнд Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлын тулгамдсан асуудал болох эдийн засгийн болон шийдвэр гаргах хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог хангаж, тэгш боломжийг бүрдүүлэх ажлууд тусгагдсан байгаа нь харагдаж байна.

ЖҮХ-оос салбар дундын, салбар, орон нутаг, улс төрийн нам, аж ахуй нэгжүүдэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хүйсээр ангилсан мэдээлэл гаргах ажлуудыг аймгийн салбар хороод, яамдын салбар зөвлөлүүдээр дамжуулан хэрэгжүүлж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлд бүрдсэн үндэсний тогтолцоог авч үзвэл, жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 17.2-т заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд ЖҮХ-г тэргүүлж, үйл ажиллагааг удирдлагаар хангана. Хорооны дүрэмд заасны дагуу ЖҮХ нь аймаг, нийслэлд салбар хороо, төрийн захиргааны төв байгууллагад салбар зөвлөлтэй байхаар заасан бөгөөд 2025 оны байдлаар дараах бүтцийн дагуу ажиллаж байна.

Дүрс 7. Жендэрийн үндэсний хорооны бүтэц



ЖҮХ-ны ажлын алба нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үндэсний чадавхыг бэхжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хувийн хэвшлийн оролцоог уриалах, урамшуулан дэмжих чиглэлд гол үүрэгтэй байхаар заажээ. Үүний дагуу, ЖҮХ нь дээр дурдсан 7 оролцогч талуудын төлөөллийг багтаасан нийт 38 гишүүнтэйгээр 2025 онд ажиллаж байна³.

Үүний дагуу, ЖҮХ-оос 2020 онд гаргасан 'Жендэрийн тэгш байдлын өнөөгийн түвшин' тайланд эдгээр олон талтай ажиллаж буй ажлын гол тэргүүлэх чиглэлийг дурдсан бөгөөд түүнийг 2020 оноос хойш гаргасан ЖҮХ-ны жил тутмын тайлангууд дээр үндэслэн нэмж баяжуулан дараах хүснэгтэд тоймлон харуулав.

Хүснэгт 3. Жендэрийн үндэсний хорооны олон талт хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд

Төрийн байгууллага	Олон улсын хөгжлийн байгууллагууд	Төрийн бус байгууллагууд	Хувийн хэвшил
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль,	Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлт	Төрийн албан дэх жендэрийн эрх тэгш	Хувийн хэвшлийн үйл ажиллагаанд жендэрийн

³ Эх сурвалж : Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралт

хөгжлийн зорилтот хөтөлбөр, жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих • Мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, жендэрийн асуудал хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах • Уур амьсгалын өөрчлөлт ба эдийн засгийн шинэ нөхцөл байдал дахь жендэрийн асуудлууд	• ЖСХ-тэй тэмцэх • ИНБ-ын оролцоотойгоор тэгш байдлыг хангах	байдлын асуудлаарх судалгаа, үнэлгээ • Бодлого, хөтөлбөрийн хяналт, шинжилгээ үнэлгээ • Эрх зүй, бодлогын орчныг сайжруулах хэлэлцүүлэг • Хувийн салбарт ЖСХ болон ажлын байран дэх бэлгийн дарамттай тэмцэх • Төрийн албанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх Сургалт нөлөөлөл	тэгш байдлын үзэл баримтлал нэвтрүүлэх, • Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гомдол хүлээн авч шийдвэрлэх • 'Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээр' ⁴ -ийн хүрээнд хөдөлмөрийн харилцааг сайжруулах бодлого, санаачилга эхлүүлэх, практикт нэвтрүүлэх
--	---	---	---

Тухайлбал, жендэрийн статистик мэдээг төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-ын түвшинд цуглуулан авч төрийн шийдвэр гаргалт дахь хүйсийн тэнцвэрт байдлыг бүртгэн, хянаж байна. Эдгээр салбар хороо болон салбар зөвлөлүүд нь жил бүр Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай салбар дундын стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, түүний хэрэгжилтийг ЖҮХ-нд илгээж байна. ЖҮХ болон түүний салбар хороо болон зөвлөлүүдэд нь олон талт хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжиж салбар болон түвшин бүрт өөрсдийн нэгжийг олон талын оролцоотойгоор байгуулаад байна. Монгол Улсын Засгийн газраас 2023 онд боловсруулсан 'Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн тайлан'-д дурдсанаар салбар зөвлөл болон хорооны төлөвлөлтийг шийдвэрлэх хуралдааныг улсын төсвийн мөчлөгтэй уялдуулан төлөвлөлт, төсөвлөлт хийхдээ эдгээр олон талын оролцоог хангаж буй байдал дутмаг, одоогийн салбар хороо, зөвлөлүүдийг хариуцсан жендэрийн мэргэжилтэн нь өөрсдийн ажлын үндсэн чиг үүргээс гадна хавсран гүйцэтгэж байгаа нь гүйцэтгэлийг бууруулж байгаа зэрэг сорилтуудыг дурджээ.

ЖҮХ-оос 2020 онд гаргасан 'Жендэрийн тэгш байдлын өнөөгийн түвшин' тайланд дурдсанаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсанаас хойш 2011-2019 онд жендэрийн асуудлаар 12,469,841 ам.долларын хөрөнгө зарцуулсан бөгөөд 3.6 хувийг улсын төсвөөс, үлдсэн 96.4 хувийг хөгжлийн албан ёсны туслалцааны хүрээний түншлэгчид санхүүжүүлжээ. Энэ нь **жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн санаачилгууд богино болон дунд хугацааны төслүүдээс хамааралтай** байгааг харуулж байгаа бөгөөд тодорхой зорилтот бүлэг, зорилтот байршлуудад л үр шим хүрч байгааг харуулж байгаа юм. 2020 оноос хойш зарцуулагдсан төсвийн талаар нэгдсэн тайлан мэдээлэл байхгүй байгаа боловч Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан 'Жендэрийн Үндэсний хорооны дүрэм'-д зааснаар ЖҮХ-ны Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс, Салбар хороо, зөвлөл нь тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг зохих шатны төсөвт тусгуулах заалт орсон байгаа нь, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлд улсын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд түлхэц болсон байх талтай.

Засгийн газраас 2023 онд гаргасан 'Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн' тайланд 2021 оноос авч хэрэгжүүлсэн ажлуудын биелэлтийг 50% буюу 'хэрэгжих шатанд' байна хэмээн дүгнэжээ. Үүнээс гадна, шинээр байгуулсан хороо, салбар хороо, салбар зөвлөл гэх мэт бүтэц өргөжих тусам хийгдэх ажлын цар хүрээ, ажлын ачаалал, сургалтын хэрэгцээ нэмэгдэж байгаа тул түүнд нийцсэн хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах, мэдлэгийн бүтээгдэхүүн гаргах хэрэгцээ өндөр байна гэжээ. Мөн салбар хороо, зөвлөлүүд тогтсон хугацаанд төлөвлөлтөө хийдэггүйгээс шалтгаалан салбарын болон орон нутгийн хөгжлийн жилийн төсөв, төлөвлөгөөнд жендэрийн асуудлуудыг тусгадаггүй асуудал нийтлэг байна. Төлөвлөлт, төсөвлөлтийн алдаанаас үүдэн хөтөлбөрүүдийг

хэрэгжүүлэх нөөц бүрдээгүй улмаас тавьсан зорилтуудын ахиц удаашрах, бусад санаачилгуудыг хойш татах сорилтууд тулгарч байна.

Тоймлон дүгнэвэл, жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал болон өнөөгийн ажиллаж буй бүтэц, авч хэрэгжүүлж буй санаачилгын хүрээнд, асуудлаа тодорхойлсон байдал болон түүнд чиглэсэн хууль, эрх зүйн зохицуулалт, тогтолцоо, бүтэц бүрэлдэхүүнийг харьцангуй сайн бүрдүүлсэн нь харагдаж байна. Гэхдээ цаашид энэхүү механизмыг үр дүнтэйгээр, үр ашигтайгаар ажиллуулахын тулд шаардлагатай санхүүжилтийг төсөвт тусгах, салбар зөвлөл, хороод дахь хүний нөөцийг, ялангуяа жендэрийн мэргэжилтнүүд, шинжээчдийг бэлтгэх замаар хэрэгжүүлэх ажлын чанар, үр дүнг сайжруулах хэрэгцээ байгаа нь харагдаж байна. Мөн одоогийн батлагдсан бүрэлдэхүүн болон төлөвлөгдсөн ажлуудад хувийн хэвшил болон хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэн, татан оруулах замаар үндэсний хэмжээнд санаачилгыг жигд сурталчлах, нэвтрүүлэх шаардлага харагдаж байна. Эдгээр салбар зөвлөл, хороодын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт болон үр нөлөөг сайжруулахад оруулж буй хувь нэмрийг тооцож, тогтмол нэмэгдүүлэхийн тулд үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт үр дүнг тогтмол хянаж, сайжруулах, үйл ажиллагааг урт хугацаанд системтэйгээр төлөвлөж, хэрэгжүүлэх, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх хэрэгцээ байна.

Бүлэг 2. Монгол Улс дахь ЖСХ-ийн нөхцөл байдал

‘Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль’-д тодорхойлсноор “жендэрт суурилсан хүчирхийлэл” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхгүйг хэлэхээр заасан. ЖСХ-ийн нөхцөл байдал болон түүнд гарч буй өөрчлөлтийг харахын тулд тоон мэдээлэл шаардлагатай боловч Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ)-аас гаргаж буй зөрчил, гэмт хэргийн тоон мэдээлэлд ‘жендэрт суурилсан хүчирхийлэл’ гэсэн хүчирхийллийн бие даасан, ангилсан мэдээлэл гардаггүй. Харин ЖСХ-ийг илтгэх хүчирхийллийн хэлбэрээр буюу гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-ийг тодорхойлох замаар хэв журмын зөрчил эсвэл гэмт хэрэг эсэхийг тодорхойлж байна.

Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 6.26 дугаар зүйлд Бэлгийн дарамт учруулах үйлдлийг зөрчилд тооцож, хариуцлага хүлээлгэхээр заасан. Харин гэмт хэргийн шинжтэй үйлдэл тогтоогдвол, Эрүүгийн хуулиар зохицуулах бөгөөд ЖСХ-тэй холбоотой асуудлууд нь дараах 5 бүлэг гэмт хэргийн хүрээнд тодорхойлогдож байна. Тухайлбал:

- i) Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг;
- ii) Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- iii) Хүний эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- iv) Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг;
- v) Хүүхдийн эсрэг гэмт хэрэг зэрэг 5 төрлийн гэмт хэргүүдийн хүрээнд тодорхойлон, хянан шийдвэрлэж байна.

ЦЕГ-ын статистик мэдээлэлд дурдсанаар, 2020 оноос хойш 5 жилийн хугацаанд Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөнтэй холбоотой зүйл заалтад хамаарах нийт 52,367 зөрчил бүртгэгджээ. 2020 онд жилдээ 10,306 зөрчил бүртгэгдэж түүний дараа 2021 онд 9,526 болж буурсан боловч түүнээс хойш жил ирэх тутам өссөөр 2024 онд 12,392 зөрчил бүртгэгджээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн зөрчил нь 2020 оны тоон мэдээлэлтэй харьцуулахад 2024 онд 20 гаруй пунктээр өссөн байна.

ЖСХ-тэй холбоотой сүүлийн 5 жилд бүртгэгдсэн гэмт хэргийн статистикийг тоймлон харвал энэ төрлийн гэмт хэргийн тоо олонх үзүүлэлт дээр өсжээ.

Хүснэгт 4. ЖСХ-тэй холбоотой нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, оноор

Гэмт хэргийн зүйл заалтууд	Улаанбаатар					Улсын дүн				
	2020	2021	2022	2023	2024	2020	2021	2022	2023	2024
10.1.2 Гэр бүлийн хүчирхийлэл үлдэж хүнийг алах	11	8	13	13	19	21	18	30	22	37
11.1 Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	13	16	11	13	14	22	30	29	24	34

IRIM судалгааны хүрээлэн

11.4 Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	23	40	44	22	39	38	63	91	55	97
11.6 Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	444	668	702	549	487	871	1162	1331	1047	1081
11.7. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	65	49	40	59	34	111	118	98	126	123
12.1 Хүчиндэх	203	225	285	287	365	401	439	550	564	658
12.2 Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	16	10	14	15	31	18	16	19	20	44
12.3 Бэлгийн мөлжлөг	2	1	2	3	-	3	3	2	3	8
13.1 Хүн худалдаалах	10	6	10	8	12	10	10	12	11	13
16.8 Хүүхэд садар самууныг сурталчлах, уруу татах	6	15	39	24	27	8	16	40	40	32
16.9 Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах	-	2	3	7	6	-	2	6	8	6
НИЙТ	793	1040	1163	1000	1034	1503	1877	2208	1920	2133

Сүүлийн 5 жилийн хугацаанд гарсан нийт гэмт хэргийн хувьд байршлаар харьцуулан харвал 40 болон түүнээс дээш хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн. Үндэсний хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тооны өсөлт, бууралт нь жигд бус байгаа ч, ерөнхий хандлага өсөлттэй буюу нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо нь үндэсний хэмжээнд 2020 онтой харьцуулахад 42 пунктээр, Улаанбаатар хотод 30 пунктээр, хөдөө орон нутагт (21 аймгийн нэгдсэн дүнгээр) 55 пунктээр тус тус өсжээ. Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн ангиллаар нь 2020 онтой харьцуулан гаргасан өсөлтийг харвал хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах; хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах; бэлгийн мөлжлөг; бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэсэн хэргүүдийн бүртгэгдсэн тохиолдол мэдэгдэхүйц өсжээ. 2020 онтой харьцуулахад Эрүүгийн хуулийн зүйл, заалтаар бүртгэгдсэн гэмт хэргийн тоо нэмэгдсэн нь дараах төрлийн гэмт хэрэгт илүүтэй илэрч байна. Үүнд: хүүхэд оролцуулсан порнографийг сурталчлах, түүнд уруу татах; хүний эрүүл мэндэд санаатайгаар хүнд хохирол учруулах; бэлгийн мөлжлөг; болон бэлгийн ёс суртахууны эсрэг гэмт хэргүүд багтана. Эдгээр гэмт хэргийн өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийн дотор цар тахлын дараах эдийн засгийн хүндрэл, хотжилтын эрчимжилт, ялангуяа хөдөө орон нутагт гэмт хэргийн мэдээллийн тогтолцоо сайжирч буй зэрэг үзүүлэлтүүд нөлөөтэй байна. Үүний зэрэгцээ үндэсний болон олон улсын байгууллагууд, иргэний нийгмийн оролцоотойгоор хэрэгжүүлж буй олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санаачилгууд нь иргэдийг илүү идэвхтэй мэдээлэгч болоход түлхэц өгч, бүртгэгдэж буй хэргүүдийн тоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан байж болзошгүй юм. Нийгмийн ухамсар нэмэгдэж, хууль сахиулах механизм бэхжиж байгаатай зэрэгцэн гэмт хэргийн бүртгэл өссөн нь ажиглагдаж байна. Хууль зүйн судалгааны төвөөс жил бүр "Гэмт хэргийн цагаан ном"-ыг эмхэтгэдэг боловч энэхүү ном нь зөвхөн тоон мэдээллийг агуулдаг бөгөөд гэмт хэргийн чиг хандлагын өөрчлөлтийн шалтгаан, хүчин зүйлсийн талаарх дүн шинжилгээ, тайлбар тусгагддаггүй.

Тоон мэдээллийг судалгаанд сонгогдсон 2 аймгаар харьцуулан харахад Улаанбаатар хоттой харьцуулахад сонгогдсон аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн төрөл болон бүртгэгдсэн тохиолдлын хувьд мэдэгдэхүйц бага байгаа нь доорх хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 5. Дархан-Уул болон Хэнтий аймгууд дахь ЖСХ-тэй холбоотой нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, оноор

Гэмт хэргийн зүйл заалтууд	Дархан					Хэнтий				
	2020	2021	2022	2023	2024	2020	2021	2022	2023	2024
10.1.2 Гэр бүлийн хүчирхийлэл үлдэж хүнийг алах	-	1	1	1	-	1	1	2	1	3
11.1 Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	1	1	4	1	1	-	-	-	1	1
11.4 Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	4	5	4	4	4	1	1	3	-	4
11.6 Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	45	49	62	31	38	16	30	27	17	27
11.7. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	3	7	5	3	9	1	1	5	4	2
12.1 Хүчиндэх	8	12	7	10	12	16	14	18	12	20

12.2 Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	-	-	-	-	1	-	-	-	-	-
12.3 Бэлгийн мөлжлөг	-	-	-	-	-	-	-	-	-	-
13.1 Хүн худалдаалах	-	-	-	-	-	-	-	-	-	-
16.8 Хүүхэд садар самууныг сурталчлах, уруу татах	-	-	-	1	-	-	-	-	-	-
16.9 Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах	-	-	-	-	-	-	-	-	-	-
	61	75	83	51	65	35	47	55	35	57

2024 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад, Хэнтий аймагт ЖСХ-тэй холбоотой гэмт хэргийн тоо мэдэгдэхүйц өссөн байна. Хөдөө орон нутгийн аймгуудын хэмжээнд ЖСХ-ийн тохиолдол харьцангуй бага боловч 2020 онтой харьцуулахад гарсан өсөлт нь Улаанбаатар хотод ажиглагдсан өсөлтөөс хавьгүй өндөр байна. Хэнтий, Дархан-Уул зэрэг аймгууд нь тухайн бүс нутагтаа хамгийн их хүн амтай, хотжилт өндөртэй аймгуудад тооцогддог бөгөөд Улаанбаатар хоттой ижил төстэй хэд хэдэн онцлог шинжтэй. Тухайлбал, хүн амын нягтаршил, хот суурин газрын тэлэлт, нийгэм-эдийн засгийн дарамт нэмэгдэж буй байдал зэрэг нь тодорхой төрлийн гэмт хэргүүд, түүн дотроо ЖСХ үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй нөхцөлийг бүрдүүлж байна. Нөгөө талаас, эдгээр аймгууд нь олон улсын байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудаас хэрэгжүүлж буй төслүүдийн хамрах хүрээнд харьцангуй хамрагдаж ирсэн. Улаанбаатар хотын адил, олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа нэмэгдэж, хууль сахиулах үйл ажиллагаа сайжирч, мэдээлэх механизм бэхжиж байгаа нь эдгээр бүс нутагт бүртгэгдсэн хэргийн тоо нэмэгдэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байж болзошгүй юм.

ЦЕГ-ийн тоон мэдээлэлд, 'бүртгэгдсэн гэмт хэргийн тоо'-ны үзүүлэлт нь дээр дурдагдсан гэмт хэргийн зүйл заалтаас өөрөөр буюу хүчирхийллийн төрлөөр, холбогдогч талуудын нас, хүйс, байршил зэрэг хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн байдлыг харуулахуйц нарийвчилсан байдлаар олон нийтэд нээлттэй байдлаар тайлагнахгүй байна. Харин Монгол Улсын Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс 2024 оны 4 дүгээр сард нийтэлсэн 'Монгол Улсын шүүхийн 2023 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ'-нд бүртгэгдсэн зөрчил, гэмт хэргүүдээс зөвхөн зөвхөн шүүхээр орж шийдвэрлэсэн хэргүүдийн дундаас ЖСХ-тэй холбоотойгоор ГБХ-д өртсөн хохирогчдын хувьд хүйс, хүчирхийллийн хэлбэр, хүчирхийлэл үргэлжилсэн хугацаа, давтамж, гэр бүлийн хамаарал зэрэг үзүүлэлтүүдийг нарийвчлан тайлагнажээ. Энэхүү тайланд дурдсанаар, ГБХ-д өртсөн хохирогчдын 94.1% нь охид, эмэгтэйчүүд байгаа бөгөөд бүгд гол төлөв бие махбодын хүчирхийлэлд 1 жил хүртэлх хугацаанд (86.9%) хамтран амьдрагч эсхүл нөхрөөсөө (73.6%) жилдээ нэгээс хоёр удаа (80.3%) нь хүчирхийлэлд өртөж байгаа иргэд байна. 'ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ'-д хүчирхийллийн талаарх тоон мэдээлэл, мэдээллийн сан бүрдүүлэх, байгууллага хооронд мэдээлэл солилцох асуудал дутмаг байгааг онцолсон байдаг (ГХУСАЗЗ, 2023). Үүнийг гол оролцогч талуудтай хийсэн ярилцлага мөн баталж байгаа бөгөөд ЖСХ-ийг бууруулахын тулд нэгдсэн бөгөөд нарийвчилсан мэдээллийн сан, тоо бүртгэл дутмаг, гарч буй тоон мэдээллүүд байгууллага хооронд зөрүүтэй байгааг дурдаж байлаа.

Энэхүү судалгааны хүрээнд НЦҮТ болон ТХБ-нд байрлаж байсан 10 даван туулагчийн дунд кейс ярилцлага хийсэн бөгөөд түүний хүрээнд ЖСХ-ийн учир шалтгааныг тодруулахад нэн тэргүүнд гэр бүлийн хүмүүжил, боловсрол, гэр бүл дэх эрх мэдэл, үүргийн хуваарилалт, хүүхдүүдээ бодож хүчирхийллийг тэвчин хүлцэх хандлага, санхүүгийн хараат байдал зэрэг хүчин зүйлсийг нийтлэг дурдаж байлаа. Мөн ТХБ, НЦҮТ-өөс үйлчилгээ авч байсан 50 эмэгтэйдээс авсан тоон судалгааны үр дүнгээр гэр бүлийн болон сэтгэл зүйн боловсрол, хуулийн мэдлэг, эдийн засгийн асуудлуудаас хамаарсан дараах шалтгаанууд дурдагдаж байв.

Хүснэгт 6. Хохирогч, даван туулагчдын хүчирхийллийн шалтгааныг нэрлэсэн байдал (n=50)

Хүчирхийлэл үйлдэгчээс хамаарсан	Хохирогчоос өөрөөс нь хамаарсан
1. Ажилгүйдэл болон эдийн засгийн хүндрэлүүд – орлого тасрах, өр төлбөр нэмэгдэх, мөрийтэй	1. Хүүхдүүдээ өсгөдөг учраас эдийн засгийн хувьд хараат байх; 2. Ажилгүй, орлогогүй байх

тоглоомоос үүдэлтэй санхүүгийн хохирол болон стресс нэмэгдэх; 2. Архи хэтрүүлэн хэрэглэх; 3. Гэр бүлийн боловсрол дутмаг байдлаас шалтгаалсан зөрчил, маргаан шийдвэрлэх чадваргүй байдал болон үүрэг, хариуцлагаа ойлгохгүй бах; 4. Жендэрийн тэгш бус байдал – гэр бүлийн хүрээнд эрх мэдлийн тэнцвэргүй байдал, эдийн засгийн хамааралтай байх 5. Сэтгэл хөдлөл тогтворгүй, уур хилэнгээ захирах чадвар муу байх, хардах; 6. Хүчирхийлэлтэй, маргаантай орчинд өсөх, гэр бүлийн хүмүүжил – гэр бүлийн хүчирхийлэл, тогтмол зөрчилдөөнтэй орчинд өсөх; 7. Боловсрол, ёс суртахууны хүмүүжил, зан төлөвийн төлөвшил дутагдалтай байх; 8. Хууль, эрх зүйн талаарх мэдлэг дутмаг байдлаас үүдэн зөрчил, хүчирхийллийг хэвийн үзэгдэл гэж хүлээн зөвшөөрөх хандлагатай байх; 9. Хадам төрөл төрөгсдийн зүгээс дарамт үзүүлэх, зөрчилдөх, үл ойлголцох.	3. Хүүхдүүдээ бодож тэвчих, нөхцөл байдлыг нуух; 4. Сэтгэл зүй тогтворгүй байх, уураа зохицуулж чаддаггүй; 5. Гэр бүл доторх зөрчлийг шийдвэрлэж чаддаггүй байх; 6. Сэтгэл зүйн хувьд өөрийгөө илэрхийлж чаддаггүй, итгэлгүй байх; 7. Өөрийн аав, ээжийн хүчирхийлэлтэй тохиолдлоос эмэгтэй хүний амьдрал ийм л байх ёстой гэж боддог болох; 8. Нөлөөнд автаж, өөрийгөө буруутгах; 9. Биеэ хамгаалах чадвар сул байх; 10. Орон нутгийнхандаа мэдэгдэж ялгаварлан гадуурхагдахаас айх, бусдаас ичих, нуух; 11. Өөр очих газаргүй, бусад хүмүүст төвөг удахыг хүсэхгүй байх; 12. Хуулийн мэдэг дутмаг байх.
--	--

Хохирогч/даван туулагчдын кейст хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд, хүчирхийллийн гол шалтгаан нь жендэрийн тэгш бус байдал болохыг батлан харуулж байна. Энэ нь зөвхөн гэмт хэрэг үйлдэгчдийн үйлдлээр хязгаарлагдахгүй, харин хувь хүний өсөж торнисон өрхийн болон нийгмийн өргөн хүрээтэй орчны нөхцөл байдалтай нягт уялдаатай юм. Ийм шалтгаануудын дотор гэр бүлийн боловсрол, хүмүүжил, зөрчил маргааныг шийдвэрлэх чадвар сул, амьжиргааны түвшинтэй холбоотой бэрхшээлүүд, хүүхэд насандаа хүчирхийлэлд өртсөн байдал, хүчирхийлэл үйлдэж буй болон өртөж буйгаа ойлгох байдал багтана. Эдгээр асуудлуудын дийлэнх нь нийгэм дэх жендэрийн тэгш бус байдлаас үүдэлтэй. Жишээлбэл, эмэгтэйчүүд хамтран амьдрагч/нөхрөөсөө эдийн засгийн хувьд хараат байх нь боловсрол болон хөдөлмөр эрхлэлт дэх тэгш бус байдалтай холбоотой бол, уламжлалт жендэрийн хэвшмэл хандлагууд нь эмэгтэйчүүдийн эрх мэдэлтэй болох орон зайг хязгаарлаж, эрчүүдийн сэтгэл хөдлөлийг илэрхийлэх чадамжийг хумьж байдаг. Энэ нь зөрчил маргааныг эрүүл, үр дүнтэй аргаар шийдвэрлэх боломжийг бууруулж байдаг байна.

Хүчирхийллийн шалтгааныг эргэн харахад, даван туулагчид өөрсдөө дараах суурь асуудлуудыг түлхүү дурдсан байдаг. Үүнд: гэр бүлийн хүмүүжлийн эерэг бус арга, эдийн засгийн тогтворгүй байдал, эдийн засгийн харилцаан дахь хамаарал, зөрчил шийдвэрлэх чадваргүй байдал болон архины хамаарал зэрэг орно. Эдгээр нь нийгэм дэх тогтолцооноос хамаарсан жендэрийн тэгш бус байдлын илрэл буюу эрэгтэйчүүдийг тэжээгч, шийдвэр гаргагч байхаар, эмэгтэйчүүдийг хараат, асран хамгаалагчийн байр суурьтайгаар нийгэмд эзлэх байр суурийг нь тодорхойлсноор хүчирхийлэл үйлдэгдэх нөхцөлийг бий болгож, түүнийг давтан үйлдэгдэх, хүчирхийллийг хүлцэх, хүлээн зөвшөөрөх хандлагыг бэхжүүлдэг байна.

Эдгээр хүчин зүйл нь хувь хүн болон өрхийн түвшинд илэрч байгаа ч, тэдгээр нь илүү өргөн хүрээний жендэрийн хувьд тэгш бус нийгмийн тогтолцооноос хамаарсан байдаг. Эцгийн эрхт ёсны хэм хэмжээ, жендэрийн уламжлалт үүрэг хариуцлага нь нийгмийн хандлага, хүлээлтийг тодорхойлж, ЖСХ-ийг хэвийн мэт хүлээн зөвшөөрөх, цаашид үргэлжлүүлэх хөрс суурийг бүрдүүлдэг. Олон тохиолдолд, эрэгтэй хүнийг удирдагч, ноёрхогч байхаар шаардаж, эмэгтэй хүнийг дуулгавартай, тэвчээртэй, дуугүй байхыг нийгэм шахдаг. Ийм эрх мэдлийн тэнцвэргүй байдал нь гэр бүлийн хүрээнд хамаарал, дуугүй тэвчих байдлыг улам бүр гүнзгийрүүлж, хүчирхийллээс гарах боломжийг хязгаарлаж байдаг.

Энэ мэт хүчирхийллийг хүлээн зөвшөөрсөн тогтолцоог дараах нийтлэг нийгмийн итгэл үнэмшлүүд улам бэхжүүлж байна. Үүнд: “Нөхөр нь эхнэрээ зодох нь хэвийн үзэгдэл”, “Эхнэр нь гэртээ хүүхдээ харж, нөхөр нь мөнгө олдог”, “Гэр бүлийн асуудлыг гадагш гаргах ёсгүй”, “Сайн эхнэр гэдэг нь гэр бүлийнхээ төлөө бүхнийг тэвчдэг”, “Хэрэв эмэгтэй хүчирхийлэлд өртсөн бол тэр өөрөө буруутай байж таарна” гэх

мэт. Ийм итгэл үнэмшил нь жендэрийн тэгш бус байдлыг бататгахаас гадна хүчирхийллийг хэвийн мэт үзэх хандлагыг улам бүр гүнзгийрүүлж, хохирогчдод тусламж хүсэх сэдлийг мохоож, дуугүй байх соёлыг түгээж байдаг.

Ийм нөхцөл байдалд дээрх хэвшсэн буруу хандлагыг сууриас нь таслан зогсоох шаардлага тулгарч байна. Иймд хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролын тогтолцоогоор нь дамжуулан гэр бүл болон нийгмийн орчин дахь хүчирхийллийн бүх хэлбэрийг танин мэдэх, ялган ойлгох чадвартай болгож төлөвшүүлэх нь онцгой ач холбогдолтой. Эрх тэгш байдал, харилцан хүндлэл, хүчирхийлэлгүй орчныг эрхэмлэсэн соёлыг өсөн хөгжиж буй бага үеэс олгох нь хүчирхийллийн үе дамжсан мөчлөгийг таслах суурь нөхцөл болно.

Эдгээр шалтгаанууд нь үндэсний хэмжээнд хийгдсэн дараах судалгаануудын үр дүнтэй нийцэж байна. ЖСХ-ийн асуудлыг хөндсөн Монгол Улсад хийж байсан хамгийн томоохон судалгаа нь 'Хүчирхийллийн нүцгэн үнэн' сэдэвт ЖСХ-ийн судалгаа бөгөөд 2017 онд НҮБ-ын Хүн амын сан (НҮБХАС)-аас санхүүжүүлэн ҮСХ гүйцэтгэсэн. Уг судалгааны тайланд дурдсанаар эмэгтэйчүүдийн 57.9% нь амьдралдаа аль нэг хэлбэрийн хүчирхийлэлд өртөж байсан бол, 31.2% нь бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байжээ. Судалгаанд хамрагдсан Хэнтий болон Дархан-Уул аймгуудын хувьд эмэгтэйчүүдийнх нь бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан гэж хариулсан хувь нь улсын дунджаас өндөр буюу 31.5% болон 41.0%-тай байжээ.

Уг судалгаанд дурдсан анхаарал татахуйц зүйл нь жендэр болон хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд хандах эмэгтэйчүүдийн хандлагыг тодруулахад бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүд хүчирхийллийг илүү их хүлцэн тэвчих, зөвтгөх хандлагатай байгаа нь ажиглагдсан. Түүнчлэн ГБХ-ийн шалтгааныг дурдахдаа, ажилгүйдэл болон ядуурлаас хамаарсан дарамт, архидалт, эдийн засгийн хараат байдал, дагавар хүүхэд, хойд эцэг/эхийн харилцаа, гэр бүлийн хүмүүжлийн доголдол, гэр бүлээс гадуурх харилцаа гэх мэт шалтгаануудыг дурдаж байсан. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд ямар нэгэн байгууллага, үйлчилгээнд хандахгүй байгаа шалтгааны гол нь гэр бүлийн нэр хүнд унахаас айсан (25.9%), хүчирхийлэл байдаг л зүйл, ноцтой асуудал биш (20.9%) хэмээн хүлцэн тэвчих хандлага бүхий шалтгаанууд нэрлэгдэж байжээ. Гэр бүлийн хүчирхийлэл нь дан ганц өртөгчид бус гэр бүлийн гишүүдэд, хүүхдүүдийн хувьд зан байдлын доголдол, хүчирхийлэлд өртөгчийн хувьд сэтгэцийн эрүүл мэндийн асуудал үүсгэж байж болзошгүй талаар энэхүү судалгаа харуулжээ. Энэхүү таамаглалыг хамгийн сүүлд 2024 онд АХБ-аас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн 'Эрэгтэйчүүдийн амьдралын туршлага ба Хүчирхийлэл' сэдэвт судалгааны үр дүн батлан харуулсан бөгөөд хүүхэд насандаа хүчирхийлэлд өртсөн байдал насанд хүрсэн үедээ илүү их хүчирхийлэл үйлдэх магадлалыг нэмэгдүүлж байгааг энэхүү судалгаа харуулсан юм⁵. Мөн ажилгүйдэл болон ажлаас үүдэлтэй стресс, архины зохисгүй хэрэглээ болон сэтгэл гутралын нөхцөл байдал нь хамтран амьдрагчийнхаа эсрэг хүчирхийлэл үйлдэх байдалтай шууд хамааралтай байжээ (Lang, Munkh-Achit, & Gerelt-od, 2024). Тиймээс хүчирхийллийн зөрчил, гэмт хэргийн гол үйлдэгч болж буй эрэгтэйчүүдийн хувьд бага наснаас нь эхлэн бүхий л орчинд хүчирхийлэл, эрэгтэйлэг байдлын талаарх соёл, тогтсон хандлагыг өөрчлөх, сэтгэцийн эрүүл мэндийн талаар боловсрол олгох замаар хүчирхийллээс сэргийлэх хэрэгцээ байгаа нь харагдаж байлаа.

АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлсэн 'Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл (2019-2023)'-ийн хүрээнд 2023 онд хийгдсэн 'Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн виктимологи судалгааны тайлан'-д дурдсанаар 2017-2022 оны хооронд ГБХ үйлдэх гэмт хэрэгт 7046 хохирогч байгаагаас, 90.05% нь эмэгтэй, 540 буюу 8.76% нь хүүхэд байжээ. Уг тайланд дурдсанаар хүчирхийллийн хохирогч болоход нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн хүчин зүйл болох ядуурал, ажилгүйдэл ихээхэн нэрлэгдсэн бол, үүнээс үүдэлтэй гэр бүлийн зөрчил маргаан, эрсдэлүүд нэмэгдэж байгааг дурджээ. Мөн уг судалгаанд ГБХ үйлдэж байгаа гол шалтгаануудыг нэрлүүлэхэд, архидалт (61%), гэр бүлийн гишүүдийн өссөн орчны, соёлын ялгаа (48%), ажилгүй, орлого муу байдал (39%), нийгмийн хэвшмэл хандлага буюу гэр бүл доторх эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эрх мэдлийн ялгаа (36%) тус тус нийтлэг дурдагджээ.

⁵ Азийн Хөгжлийн Банк. (2024). Эрэгтэйчүүдийн амьдралын туршлага ба хүчирхийлэл. Азийн Хөгжлийн Банк.

ҮСХ-оос 2017 онд хийсэн ЖСХ-ын судалгаанд бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдээс шалтгааныг нь асуухад 62.2% нь хүчирхийлэгч буюу нөхөр/хамтрагч нь архи ууж согтуу байсан хэмээн хариулсан. Мөн хохирогчдын дунд хүчирхийлэлд өртсөн ч хууль сахиулах байгууллагад хандахгүй тохиолдол нэлээдгүй байгаа бөгөөд гэр бүлээ хадгалж үлдэх гээд мэдэгдэхийг хүсдэггүй (50%), хууль эрх зүйн мэдлэг дутмаг (43.3%), дахин ирэх заналхийлэл, дарамтаас айсан (40%), гэр бүл, садан төрлийн таарамжгүй харилцааг үүсгэх, дэврээхээс айсан (33.3%) зэрэг шалтгаануудыг дурджээ.

Эдгээр шалтгаанууд ерөнхийдөө хоёр үндсэн асуудлаас хамааралтай байгаа бөгөөд нэн түрүүнд, хувь хүний хүчин зүйлээс хамааралтайгаар гэр бүлийн харилцааг авч үлдэх, нэр төрөө хадгалахыг хүссэн байдал, хоёрдугаарт, институцийн хүчин зүйлээс хамааралтай буюу хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор хууль, эрх зүйн мэдлэг дутмаг, түүнээс хамааран хууль сахиулах байгууллагад итгэх итгэл бага, шийдвэрлэж чадахгүй гэж үзсэнтэй холбоотойгоор хүчирхийлэгчээс ирэх дараагийн дарамт, заналхийллээс айх айдас байгаа нь ажиглагдлаа. Эдгээр шалтгаануудад хүчирхийлэгч талаас архи, согтууруулах ундааны хэрэглээ гол хүчин зүйл болж байгаа бол хохирогч талаас хохирогчийн болгоомжгүй зан үйл буюу гэмт хэргээс зайлсхийхийн тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй байх, нуун дарагдуулах болон тэвчин хүлцэх зан үйл, харин хууль сахиулах байгууллага талаас хохирогчийг мэдлэгжүүлэх, хамгаалах арга хэмжээ дутмаг байгаатай холбоотой хүчин зүйлс байна.

НҮБХАС-аас 2020 онд гүйцэтгэсэн “Дотны хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн эдийн засгийн өртөг, зардлын тооцоо” судалгаанд дурдсанаар хүчирхийлэлээс үүдэлтэй нийт өртөг 601.2 тэрбум төгрөг (247 сая ам.доллар) болж байгаа бөгөөд үүнд хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр авч байгаа үйл ажиллагааны нийт зардал (үйлчилгээний урсгал зардал) 24 тэрбум 167.9 сая төгрөг (9.9 сая ам.доллар), ямар нэгэн арга хэмжээ аваагүйгээс үүдэлтэй хүчирхийлэлд өртсөн тохиолдолд гарах нийт хохирлын өртөг 577 тэрбум төгрөг (237 сая ам.доллар) болж байгааг дурджээ. Мөн ГБХ-тэй холбоотой бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өсөн нэмэгдэхийн хэрээр гол хохирогч болж буй эмэгтэйчүүдийн хувьд үр дагавар нь илүү хүндэрч, өөрийгөө болон хамтрагчаа хохироох тохиолдлууд ихсэж байгааг ЦЕГ-аас мэдээлжээ.

“Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн хэргийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн төлөв байдлыг судлах”⁶ тайланд онцлон дурдсанаар, ЖСХ-ийн тархалт жил бүр өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор нийгэмд үзүүлж буй нөлөө нь эрх зүйн тогтолцооны үр дүнгүй байдалтай шууд холбоотой байна. Одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй хуулийн хүрээнд оноогдож буй шийтгэлүүд нь ихэвчлэн гэмт хэргийн шинж чанарт нийцэхгүй байхаас гадна, зарим тохиолдолд хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээ болох баривчилгаа нь тухайн хэргүүдэд илүү тохиромжтой, нөхөн сэргээх шинжтэй хариу арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

Тайланд мөн дурдсанаар, хүчирхийлэгчид чиглэсэн зан төлөвийн сургалтын хөтөлбөрүүдэд сэтгэл зүйн хөтөлбөрүүдийг тусгаагүй, мөн гэм буруутны онцлог, зан үйлийн шалтгааныг гүнзгий судалж, чиглүүлэх чадавх байхгүй байгаа нь сургалтын үр дүнг эргэлзээтэй болгож байна. Түүнчлэн, эдгээр сургалт, хөтөлбөрийн чанар болон үр нөлөөг хянах үр ашигтай механизм бүрдээгүй байгаа нь зохих үр дүн хүлээлтэд нийцэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, хохирогчдод гарч буй сэтгэл зүйн болон эдийн засгийн дарамттай хавсарснаар хүчирхийллийн тохиолдлыг мэдээлэхээс зайлсхийх, цаашлаад хүчирхийлэл дахин давтагдах, улам даамжрах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн. (2023). Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн хэргийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн төлөв байдал. Улаанбаатар Хууль зүйн үндэсний хүрээлэн. Эх сурвалж: <https://nli.gov.mn/wp-content/uploads/2023/05/12-1-ger-buliin-huchirhiilel.pdf>

Бүлэг 3. ЖСХ-тэй тэмцэх хариу арга хэмжээ

ЖСХ-тэй тэмцэхийн тулд дөрвөн үндсэн чиглэлээр цогц арга хэмжээ авах шаардлагатай. Үүнд: ЖСХ-ийг үл тэвчих, хүчирхийлэлгүй нийгмийг бий болгохын тулд урьдчилан сэргийлэх; хохирогчийн аюулгүй байдлыг ханган хамгааллын үйлчилгээ үзүүлэх; хохирогчдын нэр төрийг сэргээж, нийгэмд эргэн нэгтгэгдэхэд нь дэмжлэг болохуйц нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх; мөн буруутай этгээдэд ял шийтгэл оногдуулах, зан үйлд нөлөөлөх боловсрол олгох арга хэмжээнүүд юм. ЖСХ-тэй үр дүнтэй тэмцэхийн тулд эдгээр бүх чиглэл тус бүрд онцгойлон анхаарч, уялдаа холбоотой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү судалгааны үр дүнг эдгээр дөрвөн чиглэлийн дагуу дараах бүлгүүдэд танилцуулж байна.

3.1. ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Энэхүү бүлэгт Монгол Улсад ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулж буй хууль эрх зүйн зохицуулалтууд, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг болон түүний хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд, тэдгээрийн үр дүнтэй холбоотой үр дүнг тусган танилцууллаа.


1.1.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо

Монгол Улсад үндэсний хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах чиг үүрэг бүхий зөвлөлийг улс болон аймаг, хотын түвшинд байгуулж байсан түүх 1965 оноос эхтэй. 1974 оноос түүний нэршлийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл (ГХУСА33) болгон өөрчилж, 1995 оноос Засгийн газрын тухай хуулийн өөрчлөлтөөр Хууль зүйн сайдад гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого зохицуулалтын ажлыг хариуцуулж эхэлсэн байдаг.

Харин хууль, эрх зүйн хувьд хамгийн анх 1997 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 'Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль'-ийг баталж, уг хуультай нийцүүлэн ГХУСА33-ийг Хууль зүйн сайдаар ахлуулсан 21 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, ажиллах журмыг нь баталсан. Түүнээс хойш, бүрэлдэхүүн болон ажиллах журамд нэмэлт өөрчлөлтүүд хийгдэж явсаар өнөөгийн бүтэц бүрджээ. Хамгийн сүүлд 1997 онд баталсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль нь 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр баталсан 'Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай' хууль шинэчлэгдсэн батлагдсанаар хүчингүй болгосон.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 14 дүгээр зүйлийн 14.2-т зааснаар "улсын хэмжээнд ГХУСА33 ажиллах ба орон тооны ажлын албатай байна" гэжээ. Үүний дагуу, Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолын хавсралтаар "ГХУСА33-ийн ажиллах журам"-д зохицуулах зөвлөлийн Ажлын алба, түүний чиг үүргийг тогтоон баталсан.

Дүрс 8. Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт



Уг зөвлөл нь улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр олон нийтийн оролцоонд тулгуурлан, салбар дундын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулж, эрх зүйт нийгмийг төлөвшүүлэх эрхэм зорилготой бөгөөд үүний дагуу үндэсний аюулгүй байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөө, төр, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн дэг журмыг бэхжүүлж, иргэний ухамсар, соёлыг төлөвшүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Уг зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор хариуцан хамрах асуудлын хүрээнд нийт 5 тусдаа дэд зөвлөл чиг үүргийг хуваан гүйцэтгэж байгаа бөгөөд эдгээрээс 'Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл' болон 'Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл' нь энэхүү судалгааны хүрээнд хамруулсан ЖСХ-тэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх асуудлыг шууд хариуцан ажиллаж байна. Эдгээр дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсад ГХУСА33-ийн 2024 оны 10-р сарын 29-ний өдрийн 1 дугаар тогтоолын дагуу дараах байдлаар шинэчлэн баталжээ.

Үүнээс гадна, улсын хэмжээнд ГХУСА33-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын нийслэл, 21 аймаг, 9 дүүрэг, 330 гаруй сумд салбар зөвлөл ажиллаж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, нийслэл, сум, дүүрэгт түүний ИТХ-ын даргаар удирдуулсан орон тооны бус зөвлөл зохицуулан ажиллах бөгөөд салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн шатны ИТХ Зохицуулах зөвлөлөөс баталсан нийтлэг журамд нийцүүлэн баталдаг. Санхүүжилтийн хувьд, зохицуулах зөвлөл, түүний ажлын албаны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг бол Салбар зөвлөл, түүний орон тооны нарийн бичгийн даргын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тодорхой ажил арга хэмжээг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хөрөнгөөр санхүүжүүлж байна.

1.1.2. Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөнүүд

ГХУСА33 болон түүний дэргэд ажиллаж буй Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлүүд жил бүрийн 2 дугаар сард багтаан үйл ажиллагааны төлөвлөгөөг баталдаг. Эдгээр чиглэл нь ГХУСА33-өөс Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй ерөнхий чиглэлийг харуулж байгаа тул энэ чиглэлд төлөвлөгдсөн ажлууд, нөөцүүдийг уялдуулах, бусад талуудтай үйл ажиллагааг нь нийцүүлэх, давхцалаас сэргийлэхэд анхаарах нь зүйтэй.

ГХУСА33-ийн зүгээс 2024 онд ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд жендэрийн хэвшмэл ойлголтуудыг өөрчлөх, хууль таниулах, гэр бүлийн харилцааг сайжруулах нөлөөллийн ажлуудыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх ажлуудыг НҮБХАС-ийн дэмжлэгтэйгээр өргөн хүрээнд зохион байгуулжээ. Тухайлбал, жилийн үйл ажиллагааны тайланд дурдсанаар Жендэрийн эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхалтыг хориглох талаар иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр төрийн 13, төрийн бус 19 байгууллагатай хамтран 835.765 иргэдэд, мөн үйл ажиллагаа явуулдаг 105 аж ахуй нэгж байгууллагын 441,000 ажилтанд 84 удаагийн, давхардсан тоогоор 1,276,765 иргэдэд “Зөрчлийн тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулийн талаар мэдлэг олгох сургалт, өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулжээ.

Мөн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 10 дугаар зүйлийн 10.2.7 дахь заалтын хэрэгжилтийг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд сэтгүүлчдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, сэтгүүлчдийн эрх зүйн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх заалтын хүрээнд сургалтыг нийт 70 орчим хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдэд, 11 байгууллага, агентлагийн хэвлэл мэдээлэл хариуцсан албан хаагчдад хүргэн ажиллажээ.

Мөн Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөнд дараах 5 зорилгын хүрээнд 29 үйл ажиллагаа төлөвлөгдөж, 2024 төгсгөлд 91% -ийн гүйцэтгэлтэй дүгнэгджээ.

- 1) Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- 2) ГБХ, хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалсны үндсэн дээр уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тэмцэх ажлыг зохион байгуулах;
- 3) ГБХ, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх;
- 4) ГБХ, хүүхдийн эсрэг гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, хохирогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 5) Соён гэгээрүүлэх явдал болно.

Уг зөвлөлийн 2024 оны жилийн эцсийн тайланд дурдсанаар НҮБХАС-ийн дэмжлэгтэйгээр ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын тайланг хэвлүүлэх, ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах ажлыг зарлах, ТХБ болон НЦҮТ-үүдийн үйл ажиллагаанд хүртээмжтэй байдлын үнэлгээ хийлгэх, албан хаагчдыг хүний эрхийн чиглэлээр сурган, сургагч багш бэлтгэх, хэвлэл, мэдээллийн байгууллагуудыг жендэрийн мэдрэмжтэй мэдээлэх чиглэлд сургах ажлуудыг гүйцэтгэжээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар хороо, салбар зөвлөлөөс эдгээр бүх ажлыг гүйцэтгэхэд нийт 21 аймаг, нийслэлийн хэмжээнд 2024 онд нийт 430.3 сая төгрөг буюу нийт бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нийт зардлын 1.7 хувийг эзлэхүйц зардлыг зарцуулж байгааг уг тайланд дурджээ. Санхүүжилтийн хувьд мөн дутмаг байгаа нь уг төлөвлөгдсөн ажлын биелэлт буурахад нөлөөлж буй буй хүчин зүйл болж байгааг уг жилийн эцсийн тайланд дурджээ.

Харин Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл нь 2025 онд дараах гурван үндсэн зорилтын хүрээнд нийт 28 үйл ажиллагаа төлөвлөсөн байна (дэлгэрэнгүйг Хавсралт 3-аас үзнэ үү). Үүнд:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах – 6 үйл ажиллагаа (жишээлбэл, эрх зүйн шинэчлэл, стандартуудыг шинэчлэх, зохицуулалтын механизм байгуулах);
2. Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх – 18 үйл ажиллагаа (жишээлбэл, судалгаа, сургалт, олон нийтийн мэдлэг олгох аян, боловсролын хөтөлбөрийн агуулга боловсруулах);
3. Хохирогч, даван туулагчдыг хамгаалах, шаардлагатай үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх – 4 үйл ажиллагаа (жишээлбэл, хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө, нөхөн сэргээх хөтөлбөрүүд, тогтолцоог сайжруулах дэмжлэг).

2025 онд уг Дэд зөвлөл нь эрх зүйн орчныг бэхжүүлэхийг тэргүүлэх чиглэл болгон ажиллах бөгөөд үүнд холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, стандартуудыг шинэчлэх, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах зэрэг арга хэмжээ багтана. Мөн урьдчилан сэргийлэх болон

олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулж, судалгаа хийх, гол оролцогч талуудад сургалт зохион байгуулах, залуусыг оролцуулах, гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхэд хамгааллын талаарх хүртээмжтэй боловсролын агуулга боловсруулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнээс гадна хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хууль зүйн зөвлөгөө, нөхөн сэргээх хөтөлбөр, холбогдох байгууллагуудын дэмжлэгийн тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр ажиллана. 2023 онд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх Монгол Улсын Засгийн газрын тайлан”-г боловсруулахдаа 2022 он хүртэлх мэдээлэлд үндэслэн нийтэлсэн. Гэсэн хэдий ч уг тайланд шинээр батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022–2031)”-ний хэрэгжилттэй холбоотой үр дүн, мэдээлэл тусгагдаагүй, мөн төлөвлөгдсөн 13 үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх олон нийтэд зориулсан тайлан хараахан нийтлэгдээгүй байна.

Үүнтэй зэрэгцэн ‘Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022–2031)’ хэрэгжиж байна. Ерөнхий сайдаар ахлуулдаг ЖҮХ нь уг салбар хоорондын төлөвлөгөөг баталсан бөгөөд үүний Зорилт 1.5.-д ЖСХ-тэй тэмцэхэд салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг эрчимжүүлэх тухай тусгасан байна. Тус стратегийн үйл ажиллагаа нь зөвхөн урьдчилан сэргийлэх арга хэмжээ бус, мөн ЖСХ-ийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, тусламж, дэд бүтцийг сайжруулахад гол анхаарлаа төвлөрүүлж байна. ЖҮХ-ны үндсэн чиг үүрэг нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, тусгай арга хэмжээг боловсруулж батлах, хэрэгжилтийг нь хянах, зохицуулах явдал боловч стратегийн хэрэгжилт нь зөвхөн уг хороогоор хязгаарлагдахгүй юм. Харин гишүүн байгууллагууд болон холбогдох бусад оролцогч талууд хууль, эрх зүйн хүрээнд хүлээсэн чиг үүргийнхээ дагуу хамтран оролцох бүтэцтэйгээр хэрэгжихээр тусгагдсан болно. Онцлон дурдвал, уг стратегид ЖСХ-тэй холбоотой Зорилт 1.5-д ЖСХ-тэй тэмцэх салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх юм. Уг зорилтын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ) нь бүх яамд, орон нутгийн засаг захиргаа, Хүний Эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) болон мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах, зохицуулах үүрэгтэй тал болон сонгогдож, уг зорилтын биелэлтийг хангахад чиглэн ажиллах тэргүүлэгч байгууллага болохоор заажээ.

Хүснэгт 7. ЖСХ-тэй тэмцэх салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг эрчимжүүлэх ажлын хамрах хүрээ

Судалгаанд суурилж тусламж үйлчилгээ, нөлөөллийн ажлыг сайжруулах	Хууль, журмуудыг шинэчлэн боловсруулах, сайжруулах	Хохирогч, даван туулагчдад чиглэсэн арга зүй, чадавхыг сайжруулах	Даван туулагчдад чиглэсэн үйлчилгээний дэд бүтцийг сайжруулах
1. ЖСХ-ийн үндэсний хоёр дахь судалгаа хийнэ. 2. Судалгаанаас гарах зөвлөмжийн дагуу хуулийн хэрэгжилтийг сайжруулна. 3. ГБХ-тэй тэмцэх, хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтын ажиллагааг сайжруулсан сайн туршлагыг судалж нэвтрүүлнэ. 4. ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулна.	1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журмуудыг хуулийн үзэл баримтлал, агуулгын үүднээс шинжилж, боловсронгуй болгоно. 2. Засаг захиргааны анхан шатны нэгжид ажиллаж байгаа Хамтарсан багийн болон ТХБ-ны үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлэх хуулийн заалтыг хэрэгжүүлнэ. 3. Хүүхэд, ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн хувийн нууцаа хамгаалуулах эрхийг бүрэн баталгаажуулсан эрх зүйн орчин бий болгоно.	1. Хохирогчид үзүүлэх цогц үйлчилгээний туршлага, арга зүйг орон нутгийн удирдлага, ТББ-уудад нэвтрүүлж, чадавхжуулна. 2. Малчдыг гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэлтийг сайжруулах, хохирогчийг хамгаалах үр дүнтэй тогтолцоо, арга зүйг бий болгоно. 3. ЖСХ, бэлгийн дарамтын хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар хүртээмж, цар хүрээг сайжруулна. 4. ЖСХ-ийн хохирогчид үйлчлэх НЦҮТ-д шүүхийн шинжилгээний үйлчилгээг нэгтгэн үзүүлнэ.	1. ГБХ-ийн хохирогч болон өрх толгойлсон эмэгтэйчүүдэд зориулсан нийтийн сууцыг сургууль цэцэрлэгт ойрхон барьж байгуулна. 2. Нийслэл дэх ТХБ хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд болон эмэгтэйчүүд, ХБИ, ахмад настнуудад үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төрөлжүүлэн байгуулж, санхүүжилтийг хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Эдгээр 13 багц ажлаас хоёр багц ажил нь урьдчилан сэргийлэх чиглэлд хийх ажил байгаа бөгөөд нэгдүгээр ажил болох ЖСХ-ээс сэргийлэх нөлөөллийн ажил нь бүх яамд болон бүх шатны ИТХ, Засаг даргын чиг үүргийн хувьд оногдсон тогтмолжсон арга хэмжээ байгаа бол хоёрдугаар ажил болох малчдын дунд ГБХ-ээс сэргийлэх ажил нь ГБХНХЯ болон ХЗДХЯ-ны удирдлагаар ХХААХҮЯ болон

ХЭҮК-той хамтарсан ажлууд байна. Хэдийгээр зорилтын үндсэн томьёолол нь салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг эрчимжүүлэх боловч, гол хэрэгжүүлэгч тал болон хамтран хэрэгжүүлэгч талуудын алинд нь ч ТББ, хувийн хэвшил гэх мэт бусад талуудын оролцоог огт дурдаагүй байна.

Хувийн хэвшлийн хувьд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11.4-т зааснаар “Ажил олгогч ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх талаар сургалт, давтан сургалтын хөтөлбөр боловсруулах, хөдөлмөрийн дотоод журамд гомдлыг шийдвэрлэх” журмыг тусгах чиг үүрэгтэй. Энэхүү үүргийнх нь хувийн хэвшилд хэрэгжүүлэх сургалтуудаар дамжуулан зан үйлийг өөрчлөх сургалтуудыг системтэйгээр хүргэх боломж байгаа ч, үүнд чиглэсэн санаачилга, бүртгэл, тайлан мэдээлэл дутмаг байлаа.

Эдгээртэй зэрэгцэн үндэсний хэмжээнд хүчирхийллээс сэргийлэхээр ажиллаж буй нэгэн томоохон тал нь ГХУСА33 боловч үндэсний хэмжээний энэхүү стратеги төлөвлөгөөнд дурдагдаагүй байгаа нь ЖҮХ болон ГХУСА33 хоорондын уялдаа холбоо дутмаг байгааг илтгэж байна. Үүнийг судалгааны хүрээнд хийгдсэн оролцогч талуудын ярилцлагын үеэр ч мөн адил дурдаж байсан бөгөөд ГХУСА33-ийн хоёр дэд зөвлөл болох Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлүүдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь үндэсний ЖСХ-ээс сэргийлэхэд зорилттой шууд уялдах тул, хоё тал хоорондын хамтын ажиллагааг сайжруулах шаардлага байна.

Шигтгээ 1

...Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үүргийг хуулиараа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл хариуцна гэж заасан. Уг зөвлөл удирдах, бусад байгууллагын уялдаа холбоог гаргаж ажиллах үүргийн хүрээнд жил болгон холбогдох аян, сургалт, үйлчилгээнүүдийг явуулдаг ч жил ирэх тусам гэр бүлийн хүчирхийлэл өсөөд байгаа. Энэ нь хамрах хүрээ, төсвийн хувьд хязгаарлагдмал байдлаас болж байна. Засгийн газрын зүгээс энэ чиглэлд төсөв маш бага хуваарилж байгаа бөгөөд олон жилийн хугацаанд НҮБ-ын Хүн амын сан, Азийн хөгжлийн банк, улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, Азийн сан, Дэлхийн зөн Монгол ОУБ зэрэг олон хөгжлийн түншүүдийн төслийн хүрээнд санхүүжүүлсээр ирсэн.

Эдгээр төслүүдийн хүрээнд Монгол Улсад сүүлийн 20 гаруй жил хүчирхийллийн хохирогчид бий болсон үр дагавартай буюу нэгэнт хүчирхийлэл гарсны дараа хохирогчийг хамгаалах байраар хангах, чадавхжуулах, нөхөн сэргээх, зэрэг үр дагаврыг шийдвэрлэх ажил илүү түлхүү хийгдэж ирсэн. Тийм учраас хүчирхийлэл буурахгүй байна. Бууруулах арга нь хүч хэрэглэхгүйгээр асуудлыг шийдвэрлэдэг үр чадварыг нь олгох, ерөнхий боловсролын сургуульд байхаас нь хөвгүүдэд уур бухимдлаа хянах, асуудлыг зөвшилцлийн аргаар шийдвэрлэх үр чадвар олгох хэрэгтэй.

Эрэгтэйчүүдийн амиа хорлолт жилд 450-500 хүн амиа хорлож байна. Эрэгтэйчүүд асуудлаа шийдвэрлэх аргаа мэдэхгүй байна. Энэ нь мөн хүчирхийллийн суурь шалтгаан болж байгаа ч, үүнд чиглэсэн ажил дутмаг байгаа нь энэ төрлийн зөрчил, гэмт хэрэг буурахгүй гол шалтгаан нь гэж таамаглаж байна.

Төрийн байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Ялангуяа, ГХУСА33-ийн ажлын алба нь үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангах, салбар, дэд зөвлөлүүдийг мэргэжил, арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, үйл ажиллагаанд шаардагдах тайлан, мэдээ, статистик, тоо баримт, лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулах, танилцуулах, зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах, олон улсын байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, үр дүнг танилцуулах чиг үүрэгтэй. Энэ нь үндэсний болон орон нутгийн хэмжээнд судалгаа, нотолгоог бүрдүүлэх, бүтцээрээ дамжуулан илүү олон талуудтай хамтрах, мэдээлэл тархаах зэрэг маш чухал нөөц бүхий зөвлөл учраас бүхий л яамд, салбар, түвшинд хэрэгжүүлэх ажлуудтай хамтрах, үр дүнг өргөжүүлэхэд чухал юм.

Эдгээрээс гадна, төрийн байгууллагын төлөөлөлтэй хийсэн чанарын ярилцлагад хөндөгдсөн чухал асуудал нь урьдчилан сэргийлэх ажлын хүргэж буй арга хэлбэр, үр нөлөөний асуудал юм. Тухайлбал, урьдчилан сэргийлэх ажлыг байгууллагууд гол төлөв зөвхөн сургалтаар ойлгож байна. Сургалтаар дамжуулан ЖСХ-ийн агуулгыг өгч байсан нь цар хүрээний хувьд нөөцөөс хамааран хязгаарлагдмал хүрээнд хүрдэг, мөн давтамжийн хувьд цуврал, тогтмол биш учраас системтэй, урт хугацааны зан үйлийн өөрчлөлтийг бий болгож чаддаггүй болохыг дурдаж байсан. Ялангуяа, төрийн байгууллагуудын хувьд хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд олон нийттэй харилцах, сургалт сурталчилгаа бэлтгэн тархах зэрэг чиг үүрэг бүхий хүний нөөц хангалтгүй, техник технологи, олон газруудад хүрэх санхүүжилт дутмаг учраас олон нийтэд чиглэсэн ажил цахим орчинд илүү түлхүү хийгдэж байгааг дурдаж байв.

Хүснэгт 8. ЖСХ-ээс сэргийлэх ажлын сул тал, сорилтууд, цаашид сайжруулах арга замын талаарх оролцогчдын санал бодол

Сул тал, сорилтууд	Сайжруулах арга зам
• Хүчирхийллийн дараах шийдлүүдэд илүү төвлөрсөн арга барилтай; • Хүчирхийлэл гарахаас өмнөх арга хэмжээ нь сургалт төвтэй; • Сургалтуудын агуулга, арга хэлбэр нь хуучирсан, нас, бүлгийн онцлогт тохиромжгүй; • Биечилсэн сургалтууд төсвөөс хамааран цар хүрээ, давтамжийн хувьд хязгаарлагдмал; • ЖСХ-ийн талаар бэлтгэгдсэн сургагч багш нар, хүний нөөц дутмаг; • Хүчирхийлэл үйлдэгчдэд буюу холбогдогч талд чиглэсэн сургалтууд дутмаг, зан үйлийг өөрчлөх сургалт хийх хугацаа богино; • Олон нийтэд хүрэх, сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх чиглэлд тусдаа орон тоо хязгаарлагдмал; • Олон нийтийн сургалтад хамрагдах сонирхол бага; • Зохион байгуулж буй цагаас хамааран өндөр настнууд эсхүл хөдөө мотоцикл унадаг учраас эрэгтэйчүүд нь илүү; • Өгсөн ойлголт мэдлэгийг, зан үйл болгон төлөвшүүлэх урт хугацааны, тогтвортой хэрэгжиж зан үйлийг өөрчлөх кампанит ажил дутмаг; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсөв бага, хугацаа хязгаарлагдмал.	• Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт хүний эрхийн агуулгыг тусгах замаар хүний эрхийн мэдрэмжтэй иргэнийг багаас нь бэлтгэх; • ЖСХ-ийг илрүүлэх, нөхцөл байдлыг тодорхойлох судалгаануудыг давтамжтай хийх замаар нотолгоонд суурилсан сургалт, сурталчилгааны агуулга, төлөвлөгөөг гаргах; • Салбар бүрд жендэрийн шинжээч, мэргэжсэн сургагч багш нарыг бэлтгэх замаар салбаруудын урьдчилан сэргийлэх санаачилгуудыг идэвхжүүлэх; • Хүчирхийлэл үйлдэгч, зөрчил гаргагчдад зориулан дахин хүчирхийлэл үйлдэхээс сэргийлэх урт хугацааны албадан зан үйлийг өөрчлөх сургалтыг үр дүнтэй, жигд хүргэх, сургагч багш нарыг бэлтгэх; • Нас, хүйс, байршил болон хөгжлийн бэрхшээлийн олон хэлбэрт нийцсэн байдлаар урьдчилан сэргийлэх агуулга, мэдээлэл бэлтгэх; • ЖСХ-ийн чиглэлээр хэрэгжсэн хөгжлийн төслүүдээс үр дүнтэй нь нотлогдсон олон нийтэд суурилсан, хэвлэл мэдээлэлд суурилсан аргачлалуудыг (Community-based behavior Change Communication, Respect Framework, SASA together etc.) нэвтрүүлэх, цар хүрээг өргөжүүлэхэд хөрөнгө оруулах; • Үндэсний салбар дундын санаачилгуудад хувийн хэвшлийг татан оруулах, санаачилгыг урамшуулах.

Хэдийгээр урьдчилан сэргийлэх чиглэлд хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, сургах чиглэлд олон ажлыг хийж байгаа боловч шинэлэг арга барил, аргачлалыг зөвхөн төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа нь цар хүрээ, үр дүнгийн хувьд хязгаарлагдмал байна. Эдгээр шинэ арга барил, аргачлалууд нь үр дүнтэй байгааг үнэлгээний үр дүнгүүд илэрхийлж байгаа тул үндэсний болон салбарын түвшинд нэвтрүүлэх, төлөвлөлтөд тусгах, холбогдох зардлыг шийдэх тал дээр төрийн байгууллагууд идэвх санаачилгатай ажиллах шаардлагатай байна.

Шигтгээ 2

...НҮБХАС жил бүр 16 хоногийн аяныг зохион байгуулж, хууль эрх зүйн шинэчлэл, хүчирхийлэлтэй тэмцэх талаарх мэдлэг, мэдээллийг олон нийтэд хүргэдэг. Гэхдээ мэдээлэл түгээх нь зөвхөн эхний алхам бөгөөд иргэдийн ухамсарт нөлөөлж, бодит үйлдэлд шилжүүлэх нь илүү төвөгтэй асуудал байдаг. Бид 2023 онд төслийнхөө 2 дугаар үе шатын хүрээнд "Олон нийтэд түшиглэсэн зан үйлийг өөрчлөх" чиглэлийн ажлууд хийж үзсэн. Архангай аймагт 2 сургуулийг сонгож, багш нар, сурагчид, ажилчидтай хамтраад "Safe School" төсөл хэрэгжүүлсэн. Энэ нь хүмүүсийн санаачилга, оролцоог сайжруулахад тусалсан. "Sasa together" зэрэг олон улсын туршлагатай стратегиудыг ашиглан цогц арга барилаар үйл ажиллагаа явуулсан. Медиа суурилсан аргаар олон залуучуудыг оролцуулж, контент бүтээдэг хүмүүсийг нэгтгэн, оролцоонд суурилсан тоглоомын аргаар хүмүүст ойлголт хүргэсэн. Олонд танигдаж хүндлэгдсэн хүнээр дамжуулан, зөв мэдээллийг бусад хүмүүсд тараах нь илүү үр дүнтэй байсан. "Respect Framework" гэх ("Relationship, harm, improvement of women, and service") гэдэг стратегийг ашигласан бөгөөд олон улсын хэмжээнд туршигдаж, үр дүнтэй нотлогдсон стратегиудыг үүний цаана явж байдаг. Эдгээрээс олон нийтэд түшиглэсэн ажлыг илүү онцлоод хийх юмсан гэж бодож байна. Тиймээс урьдчилан сэргийлэх ажлыг өргөжүүлэх шаардлагатай гэж үзэж, энэ чиглэлд ажиллаж байна. Бидний анхаарч буй гол асуудал нь хэрэгжүүлэх байгууллагуудын чиг үүрэг, үүрэг хариуцлага, хамтарсан багийн үйл ажиллагаа юм. GBV (Gender-Based Violence) чиглэлд хамтарсан багт нийгмийн салбар, цагдаа, боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд багтаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлд техник, арга зүйн дэмжлэг үзүүлэн үргэлжлүүлж байна.

"Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь" төслийн багийн төлөөлөл,
 НҮБХАС

Эдгээрээс гадна, гол оролцогч талуудын дундаж буй гол санаа нь урьдчилан сэргийлэх ажлуудын хүрээнд зөвхөн ЖСХ эсвэл гэр бүлийн хүчирхийлэл гэж харалгүйгээр СӨБ, ЕБС, хөгжлийн хөтөлбөрүүдээр дамжуулан гэр бүлийн боловсрол, хүний эрхийн боловсрол багаас нь олгох замаар зөв хандлага, зан үйлийг төлөвшүүлэх нь илүү үр дүнтэй, урт хугацааны шийдэл болно гэж үзэж байна.

Үүнээс гадна, урьдчилан сэргийлэх ажлын цар хүрээг нэмэгдүүлэхийн тулд ТББ-ууд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар урт хугацааны зан үйлийг өөрчлөх нөлөөллийн ажлуудыг хүргэх боломжтой юм. Мөн хүн амын зорилтот бүлгүүдэд нийцсэн агуулга, сурталчилгааны материал бэлтгэх, шинэ арга, аргачлал нэвтрүүлэх, зөвхөн хохирогч, даван туулагчдад бус хүчирхийлэл үйлдэгч, зөрчил гаргагч нарын зан үйлийг өөрчлөхөд анхаарч давтан үйлдэхгүй байхад нь урьдчилан сэргийлсэн ажлыг эрчимжүүлэх ажил шаардлагатай байгаа нь харагдлаа. Эдгээр жил тутам өсөн нэмэгдэж, хохирол учруулж буй ЖСХ-ийг урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлд үндэсний хэмжээнд тогтолцоог бүрдүүлэх, чадавх бэхжүүлэх, нөлөөллийн ажлуудыг олон улсын хөгжлийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр, хамтран хэрэгжүүлээд байна.

НҮБХАС нь Монгол Улсад жендэрийн эрх тэгш бус байдлыг бууруулах, ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр хоёр үе шаттайгаар хэрэгжсэн "Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь" төслийг хэрэгжүүлсэн бөгөөд эхний шат (2016-2020) нь бодлогын орчныг сайжруулж, үүрэг хүлээгчдийн чадавхыг нэмэгдүүлэх, даван туулагчдыг хамгаалах үйлчилгээний механизмыг бий болгоход чиглэсэн бол хоёрдугаар шат нь даван туулагчдыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бэхжүүлэх, төрийн хариу арга хэмжээний механизмыг институтчилэх, олон нийтийн хандлагыг өөрчлөхөд анхаарч ажилласан байна. Төслийн үнэлгээгээр ЖСХ-ийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлж, тодорхой бүлгүүдийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд татан оролцуулсан ч нийгмийн тэгш бус хандлагыг өөрчлөх нөлөө нь тодорхой бус хэвээр үлдсэн бөгөөд эрэгтэйчүүд, хөвгүүдийг урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл явцад бүрэн хамруулж чадаагүй гэж дүгнэжээ (Pawlak, Batmunkh, & Magsar, 2023). НҮБХАС-аас уриалан жил бүрийн ЖСХ-тай тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд ЖСХ-ийн эсрэг эрх зүйн орчныг сайжруулах, даван туулагчдад үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх, нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, мөн эрэгтэйчүүд, цөөнхийг тэгш хамруулан жендэрийн эрх тэгш байдлыг хангах уриалгуудыг гаргасан нь энэ чиглэлд ажиллаж буй талуудын харгалзан үзвэл зохих тэргүүлэх чиглэлийг тодотгон харуулж байгаа юм.

Эдгээрээс гадна, ЖСХ-д өртсөн иргэдэд хохирогч-төвтэй хандлагад суурилсан хууль зүйн туслалцаа авах хүртээмжийг сайжруулах зорилготой 'Монгол Улсад ЖСХ-тэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх төсөл (2019-2023)'-ийг Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO) хэрэгжүүлсэн. Энэхүү төсөл нь гэр бүлийн хүчирхийлэл болон түүний хохирогчдод илүү чиглэн, хууль сахиулах, шүүхийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, үйлчилгээг сайжруулах чиглэлд сургалтын материал, платформуудыг боловсруулах, хөгжүүлэх, арга зүйг сурталчлах, чиглэлд илүү хувь нэмэр оруулан ажиллажээ.

Эдгээрээс одоогийн байдлаар идэвхтэй хэрэгжиж буй төсөл нь АХБ-аас санхүүжүүлэн хэрэгжүүлж буй ЖСХ-ийг бууруулах чиглэлд 'Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах болон жендэрийн мэдрэмжтэй бодлогоор дамжуулан хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн жендэрийн тэгш байдлыг сайжруулах нь (2024-2026)' төсөл нь уг жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний, салбарын, орон нутгийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтэд жендэрийн тэгш байдлын асуудлыг үр дүнтэй тусгах, үндэсний чадавхыг бэхжүүлэх, хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын амьжиргааг сайжруулахад түлхүү анхаарч ажиллаж байна.


3.2 Хохирогч хамгааллын үйлчилгээ

Монгол Улсад ЖСХ-ийн хохирогчдод хамгааллын үйлчилгээ үзүүлэх төрийн тогтолцоо бүрдсэн гэж үзэж болно. Улсын хэмжээнд 102, 107, 108 шуурхай тусламжийн утсуудаар 24/7 дуудлага хүлээн авч, улсын хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагын дэргэд **40 ТХБ, НЦҮТ** үйл ажиллагаа явуулж, жилд 4,953 гаруй иргэдэд хамгааллын үйлчилгээг үзүүлж байна. 10 жилийн өмнө гэхэд хохирогч хамгааллын үйлчилгээ хязгаарлагдмал хүрээнд, зөвхөн цөөн тооны иргэний нийгмийн байгууллагын хүчин чармайлтаар хүрдэг байсан бол өнөөдөр аймаг, дүүрэг бүрд тодорхой бүтэцтэй болж, тогтолцооны түвшинд хөгжиж байна.

Олон нийт ТХБ, НЦҮТ-ийн талаар хангалттай мэдээлэлгүй хэвээр байгаа ч шаардлагатай нөхцөлд цагдаагийн албан хаагчдын тусламжтайгаар хамгаалах байранд байрлаж, үйлчилгээ авах боломжтой юм. Үйлчилгээ авсан иргэдийн сэтгэл ханамж өндөр байгаа нь нэг талаас тогтолцооны ахиц дэвшил, анхан шатанд ажиллаж буй мэргэжилтэн, албан хаагчдын хүчин зүтгэлийн үр дүн юм.

Үйлчилгээний процессийн хувьд, хүчирхийлэлд өртсөн хохирогч ихэнх тохиолдолд цагдаагийн байгууллагад ханддаг бөгөөд цагдаагийн байгууллагаас хохирогчийг харьяа ТХБ, НЦҮТ, ТББ болон хамтарсан багт холбосноор “хамгааллын үйлчилгээ”-г үзүүлэх үйл явц эхэлж байна (Дүрс 9).

Дүрс 9. ЖСХ-ийн хохирогчид хамгааллын үйлчилгээг үзүүлж буй механизм



Эх сурвалж: Судалгааны баг

Үйлчилгээний тогтолцоон дахь анхан шатны хамгийн гол нэгж нь “хамтарсан баг” юм. Хамтарсан баг нь хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийлэл, эрсдэлт нөхцөл байдлаас, гэр бүлийн гишүүдийг гэр бүлийн орчин дахь хүчирхийллээс (1) урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах (2) хохирогч хамгааллын үйл ажиллагааг төлөвлөх, холбон зуучлах, хэрэгжилтэд нь хяналт тавих, (3) нөхөн сэргээх үйлчилгээ (эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн хамгаалал, хүүхэд хамгааллын үйлчилгээ)-г зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй ажилладаг. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 801 хамтарсан баг ажиллаж байна. Хамтарсан багийн зүгээс тухайн хохирогчид нөхцөл байдлын үнэлгээ хийж, шаардлагатай үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулснаар дараагийн шатны холбогдох байгууллагууд уруу холбон зуучилж байна.

Дүрс 10. Хамтарсан багийн бүтэц, чиг үүрэг



Иргэн өөрөө мэдээлэлтэй бол, эсвэл дуудлагын дагуу ирсэн цагдаагийн албан хаагчийн хийсэн аюулын зэргийн үнэлгээгээр эрсдэл өндөр гарсан тохиолдолд цагдаагийн албан хаагчаар дамжуулан НЦҮТ, ТХБ уруу хандаж үйлчилгээ авах боломжтой.

НЦҮТ-ийн хувьд хохирогчдод эрүүл мэнд, сэтгэл зүй, эрх зүй, аюулгүй байдлын хамгаалалт зэрэг хуульд заасан бүх үйлчилгээг нэг дороос шуурхай үзүүлэх гол чиг үүрэгтэй. Шуурхай тусламж буюу богино хугацааны үйлчилгээг үзүүлсний дараа шаардлагатай тохиолдолд хохирогчийг дараагийн байгууллагууд уруу холбон зуучилдаг.

Харин ТХБ-ны хувьд хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангах гол үүрэгтэй. Бусад шаардлагатай үйлчилгээг холбогдох байгууллагуудтай хамтран хүргэх чиг үүрэгтэй байгууллага юм. Хохирогч хамгааллын чиглэлээр хуулийн дагуу үзүүлж буй үйлчилгээг Хүснэгт 9-д, НЦҮТ болон ТХБ-ны үйл ажиллагаа, үйлчилгээний ялгааг Хүснэгт 17-д харуулав.

Хүснэгт 9. ЖСХ-ийн хохирогчид үзүүлж буй хамгааллын үйлчилгээний төрөл

	Хүүхэд	Насанд хүрэгч
Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч бол		ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 33-р зүйл: 1. Аюулгүй байдлын хамгаалалт; 2. Эрх зүйн туслалцаа; 3. Холбон зуучлах үйлчилгээ.
Бэлгийн хүчирхийллийн хохирогч бол	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7-р зүйлд заасны дагуу хохирогч хүүхдэд үзүүлэх шуурхай тусламжийн үйлчилгээнд: 7.1 Аюулыг зайлуулах, аюул учруулах нөхцөл байдлыг арилгах 7.2 Хүүхдийг гэр бүлээс нь түр хугацаагаар тусгаарлах 7.3 Эмнэлгийн яаралтай тусламж, сэтгэл зүйн болон хууль зүйн анхан шатны зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээнд нэн даруй холбон зуучлах	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 6-р зүйл: 1. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ (түр хамгаалах байранд байрлуулах, биечилсэн хамгаалалт, хамгаалалтын хэрэгслээр хангах...) Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид шаардлагатай тохиолдолд хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжтой.
Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч бол		Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 12-р зүйл: 1. Хууль зүйн туслалцаа; 2. Гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах.

Оролцогч талуудтай хийсэн чанарын ярилцлагын үр дүнгээр хууль эрх зүйн түвшинд хохирогч хамгааллын тогтолцоог лайкертын шкалаар 1-5 хүртэлх түвшингээр үнэлүүлэхэд үйлчилгээний зохицуулагдсан байдал, эрх зүйн орчин бүрдсэн байдлыг талууд 4 түвшинд үнэлсэн. Ерөнхий талуудын чиг үүрэг тодорхой, салбар яам бүрд холбогдох хуулийг хэрэгжүүлэх журам, зохицуулалтыг нарийвчлан баталсан. Гэвч ТХБ, НЦҮТ-ийн чиг үүрэг, үйлчилгээний ялгаа бага байх, ТХБ/НЦҮТ-ийн санхүүжилтийн зохицуулалтад уялдаагүй байдал үүсэх, ТХБ-ны үйлчилгээний стандартыг дахин нарийвчлах шаардлага үүссэн зэрэг эрх зүйн зохицуулалтын түвшинд сайжруулах, уялдаа холбоог хангах, нарийвчлах хэрэгцээ байгааг харгалзан талууд дээрх үнэлгээг өгч байв. Мөн шинэчилэгдэн батлагдсан хуулиудтай уялдуулан холбогдох журам заалтуудад шинэчлэл оруулах шаардлагатай. Тодруулбал, УИХ-аас Хүүхэд хамгааллын тухай хууль (шинэчилсэн найруулга)⁷-ийг 2024 онд баталсан. Уг шинэчлэлээр дараах гол өөрчлөлтүүдийг хуулинд нэмж оруулсан (MLSP, 2024):

1. Хүүхэд хамгааллын арга хэмжээнүүдийг нарийвчлан зааж, шуурхай тусламж болон хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнүүдийг үзүүлэхээр нарийвчлан тусгасан;
2. Сум, хороонд хүүхэд хамгааллын чиглэлийн нийгмийн ажилтны ажлын байрыг шинээр үүсгэж ажиллуулахаар заасан;
3. Гэр бүлийн орчноос гадна бусад орчин дахь хүүхэд хамгааллын асуудлуудыг тусгасан. Тухайлбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрх, оролцоог хангах тухай, сургуулийн орчин, цахим орчин, гамшиг онцгой нөхцөл байдлын үе дэх хүүхэд хамгаалал оруулсан;
4. Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хөгжүүлсэн;
5. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг үйлчилгээний хэлбэр тус бүрээр улс орон нутгийн төсөвт тусгах, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг төсөвлөхдөө өмнө онд шийдвэрлэсэн кейсийн тоонд тулгуурлаж зарцуулах дүнг тогтоох зэрэг зохицуулалтуудыг нэмж оруулсан байна.

Эдгээр өөрчлөлтүүдтэй холбоотойгоор ЖСХ-ийн насанд хүрээгүй хохирогчид үзүүлэх үйлчилгээний журам болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь хүүхэд хамгааллын асуудалтай холбоотой журмуудыг шинэчлэх хэрэгцээ, шаардлага үүсэж байгаа нь судалгааны явцад мөн дурдагдаж байв.

Дүрс 11. Хохирогч хамгааллын үйлчилгээний эрх зүйн орчин, түүний хэрэгжилтийг үнэлсэн байдал, 1-5 хүртэлх шкалаар үнэлүүлэв (1 маш муу, 5 маш сайн)



1.2.1 Аюулгүй байдлын хамгаалалт

Эрх зүйн орчин, үйлчилгээний нөхцөл байдал: Аюулгүй байдлын хамгаалалтыг (1) түр хамгаалан байрлуулах, (2) нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, (3) Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээнүүд (*биечилсэн хамгаалалт, хамгаалалтын хэрэгслээр хангах г.м...*) гэсэн төрлүүдээр үзүүлж байна. Монгол Улсад 2025 оны байдлаар төр, ТББ-ын харьяанд нийт 17 НЦҮТ, 23 ТХБ⁸ үйлчилгээ үзүүлж байна. Эдгээр төвүүдийн нийт үйлчлүүлэгч хүлээн авах хүчин чадал нь 400 хүн/ор байв. Бүх төвүүд хүүхэд болон насанд хүрэгчдийг нэг байгууламжинд хамтад нь хүлээж авдаг. Дан хүүхэд хүлээж авдаг хамгаалах байр Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар

⁷ 2024 оны 01 сард шинэчлэгдсэн батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулинд дараах гол өөрчлөлтүүд туссан:

⁸ ЦЕГ-ын харьяа 3, ТББ-ын харьяа 3, ХГБХХЕГ-ын харьяа 17

(ХГБХХЕГ)-ын харьяанд бэлгийн хүчирхийллийн хохирогч охид болон бусад хүүхдүүдэд зориулсан хоёр ТХБ ажиллаж байна. ХХГХ-ийн хохирогчийг хүлээж авах чиглэлээр төрийн төрөлжсөн төрийн ТХБ байхгүй, 2 ТББ-ын дэргэд хамгаалах байр⁹ ажилладаг. Сүүлийн 5 жилийн хугацаанд ЦЕГ-ын дэргэдэх ТХБ-нд хамгааллын үйлчилгээ авсан ХХГХ-ийн нэг л кейс, 2023 оны 5 сард бүртгэгдсэн, бусад бүх тохиолдлууд нь ТББ-ын хамгаалах байранд үйлчилгээ авчээ.

Хүснэгт 10. ТХБ, НЦҮТ төвийн тоо, оноор

	2020	2021	2022	2023	2024
ТХБ: Төрийн	16	19	19	20	20
ТХБ: Төрийн бус	3	3	3	3	3
Нэг цэгийн үйлчилгээний төв	14	16	17	17	17
Нийт	31	36	37	40	40

Эх сурвалж: ГБХНХЯ-авсан мэдээлэл болон ТББ-уудын мэдээллийг нэгтгэв

Эдгээр төвүүдээс 2024 оны байдлаар нийт 4953 иргэн хамгааллын үйлчилгээ авсан. Тэдгээрийн 99% нь ГБХ-ийн хохирогч, 1% нь бэлгийн болон ХХГХ-ийн хохирогчид байна (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Сүүлийн 5 жилийн хугацаанд ТХБ/НЦҮТ-ийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо

	2020	2021	2022	2023	2024
Төрийн үйлчилгээ үзүүлсэн					
Хүүхэд	2147	2916	3226	2159	3073
Насанд хүрэгчид	1568	1657	1569	1636	1809
ТББ-ын үйлчилгээ үзүүлсэн (хүүхэд, насанд хүрэгчид нийт)					
Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ (ГБХ, Бэлгийн хүчирхийлэл)	233	125	188	180	60
Хүйсийн Тэгш Эрхийн төв ТББ (ХХГХ-д үйлчилгээ үзүүлдэг)	15	7	23	37	10
Талита Ази ТББ (ХХГХ-д үйлчилгээ үзүүлдэг)	TBD	TBD	10	14	1
Нийт	4659	4942	4461	4026	4953

Эх сурвалж: ХГБХХЕГ, ЦЕГ, ГХУСА33, ТББ-аас авсан мэдээллийн нэгтгэв

Хүснэгт 12. Үйлчилгээ авсан насанд хүрсэн үйлчлүүлэгчийн тоо, 2022-2024

Он	Бие махбодийн хүчирхийлэлд өртсөн	Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн	Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн	ХХГХ-т өртсөн
2022	1175	1115	192	59	33
2023	966	1101	108	44	51
2024	1323	1368	918	28	11

Эх сурвалж: ХГБХХЕГ-аас авсан мэдээлэл

Үйлчилгээ үзүүлсэн байдлаар нь авч үзвэл:

Хүснэгт 13. 2024 онд НЦҮТ, ТХБ-аас үйлчилгээ авсан насанд хүрэгчдийн тоо, төрлөөр, давхардсан тоогоор

Үзүүлсэн үйлчилгээ	Төрийн НЦҮТ/ТХБ-аас	ХЭҮТ	ХТЭТ	Талита Ази
Аюулгүй байдлын хамгаалалт	342	60	10	1
Эмнэлгийн тусламж үйлчилгээнд	158	96	5	1
Сэтгэл зүйн үйлчилгээнд	205	192	9	1
Эрх зүйн туслалцаа	223	246	10	1
Боловсролын үйлчилгээ	-	15	3	-
Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ	148	41	1	-
Бусад	63	-	0	-

Эх сурвалж: ХГБХХЕГ, ТББ-аас авсан мэдээллээр

Одоогийн байдлаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ТХБ, НЦҮТ-үүд нь ЖСХ-ийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ хүртээмжтэй эсэх, цаашид эдгээр төвийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай болохыг тодорхойлсон бөгөөд эрэлт хэрэгцээ өндөр байгаа нь дээрх тооцооллоос харагдаж байв.

⁹ 2007 оноос Хүйсийн тэгш эрх төв ТББ, 2014 оноос Талита Ази ТББ ХХГХ ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх хамгаалах байруудыг ажиллуулж байна.

ДЭМБ-ын судалгаагаар, дэлхий нийтэд эмэгтэйчүүдийн 30% нь амьдралынхаа хугацаанд дор хаяж нэг удаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртдөг гэсэн тооцоо бий (*ДЭМБ-ын Нөхөн үржихүйн эрүүл мэнд, судалгааны газар, Лондонгийн эрүүл ахуй, халуун орны анагаах ухааны сургууль, Өмнөд Африкийн анагаах ухааны судалгааны төв, 2013*). Монгол Улсад энэ үзүүлэлт 31.2% буюу олон улсын дунджаас өндөр биш ч түүнтэй ойролцоо түвшинд байгааг ҮСХ тогтоосон байна (NSO, 2017). Уг тархалтыг нийт эмэгтэй хүн амд харьцуулан тооцвол, 2024 оны байдлаар хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй 318,210 эмэгтэй байна гэж үзэж болно (Хүснэгт 14). Гэвч энэ бүх хохирогч хүчирхийлэлд өртсөн тухайгаа мэдээлдэггүй бөгөөд 2024 онд цагдаагийн байгууллагад хандсан тохиолдол нь нийт хохирогчдын ердөө 4.5% буюу 14,525 тохиолдол байна.

Хүснэгт 14. ТХБ, НЦҮТ-ийн үйлчилгээний багтаамж, түүний хүрэлцээтэй байдлыг тооцохтой холбоотой тоон мэдээллүүд

Нийт орны тоо	Дүн	Эх сурвалж
Монгол Улсын нийт 15-64 насны эмэгтэйчүүд	1,020,836	ҮСХ-ны хүн амын тоо, 2024
ЖСХ-ийн гаралт (Дотно хамтрагчийн зүгээс үйлдэгдсэн)	31.2%	ҮСХ-ны ЖСХ-ын судалгаа, 2017
Жилд дунджаар ЖСХ-д өртөж буй эмэгтэйчүүд	318,210	Судалгааны багийн тооцоо
Жилд цагдаагийн байгууллагад хандсан ЖСХ-ийн тоо	14,525	ЦЕГ-ийн мэдээлэл, 2024 (зөрчил, гэмт хэргийн тоог нэгтгэв)
Нийт хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдээс тусламж хүсэж хандсан/мэдээлсэн хохирогчийн хувь	4.5%	Судалгааны багийн тооцоо
Одоогийн ТХБ, НЦҮТ-ийн нийт багтаамж, орны	400	ХГБХХЗГ-ийн нэгдсэн мэдээлэл
Нэг хохирогчийн байрлаж буй дундаж ор хоног	17	Тус судалгаанд хамрагдсан иргэдийн тоон мэдээлэл
Одоогийн ТХБ, НЦҮТ-ийн нөөцөөр жилд үйлчилгээ үзүүлэх боломжтой хүний тоо	8,459	Судалгааны багийн тооцоо

Харин одоо ажиллаж буй нийт 40 НЦҮТ, ТХБ-ууд нь нийлээд 400 орны хүчин чадалтай бөгөөд нэг хохирогч дунджаар 17 хоног байрлаж үйлчилгээ авдаг гэж үзвэл жилд нийтдээ 8,459 хүнд үйлчлэх боломжтой байна. Энэ нь бодит эрэлт буюу тусламж хүсэж хандсан 14,525 тохиолдлын тал орчимд л хүрч үйлчлэх боломжтой гэсэн үг юм. Түүнчлэн урьдчилан сэргийлэх ажлын үр дүн сайжирснаар хохирогчдын илрүүлэлт, хандалт нэмэгдэх хандлагатайг харгалзан үзвэл, одоогийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлага байгааг энэхүү тооцоолол харуулж байна.

Талуудаас гарсан саналаар, орон нутгаас илүү төвлөрөл, эрэлтээ даган Улаанбаатар хотод хохирогч хамгааллын үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх, ингэхдээ одоогийн ТХБ-аас илүү НЦҮТ, ялангуяа эмнэлэгт түшиглэсэн төвүүдийн хүчин чадал, хүрэлцээг нэмэгдүүлэх шаардлагатайг салбарын мэргэжилтнүүд онцолж байв.

Аль байршилд, ямар үйлчилгээг ойртуулах шаардлагатайг тодорхойлох нь дараагийн түвшний нарийвчилсан судалгаа, төлөвлөлтийн асуудал юм. Харин энэхүү ерөнхий тооцооллыг одоогийн ТХБ, НЦҮТ-ийн хүчин чадал нь ерөнхий хүчирхийлэлд өртөгсдийн эрэлт хэрэгцээнд хүрэлцээтэй эсэхийг урьдчилсан байдлаар зураглах зорилгоор, нээлттэй мэдээлэлд тулгуурлан хийсэн болно.

1.2 Тулгамдаж буй асуудлууд:

ТХБ/НЦҮТ, тэдгээрийн үзүүлж буй үйлчилгээний талаарх олон нийтийн ойлголт хангалтгүй хэвээр байна: Гурван жил тутам ҮСХ-оос гүйцэтгэдэг НЦҮТ, ТХБ-ны талаарх иргэд, олон нийтийн мэдлэг, хандлагыг үнэлэх судалгааны хамгийн сүүлийн буюу 2023 оны үр дүнгээр хөдөө орон нутагт амьдарч буй иргэдийн 82.6%, нийслэлд амьдарч буй иргэдийн 74.5% нь өөрийн оршин суугаа аймаг, дүүрэгт НЦҮТ/ТХБ байдгийг мэдэхгүй гэж хариулсан байна (NSO, 2023). Ойролцоогоор 5 хүн тутмын 1 нь л эдгээр үйлчилгээний талаар сонсож байсан, тодорхой мэдээлэлтэй байна. ТХБ/НЦҮТ-ийн талаарх мэдээллийг ажлынхан, бусад танил (26.3%), найз нөхөд (17.5%), телевиз (14.5%), олон нийтэд зориулсан бусад арга хэмжээнүүд (12.4%) гэх мэт эх үүсвэрүүдээс авсан гэжээ. Өөрөөр хэлбэл, яг үйлчилгээний талаарх мэдээллийг илүү хүн хоорондын харилцаагаар дамжуулж авсан байдал илүү нийтлэг байна. Харин олон нийтэд чиглэсэн урьдчилан сэргийлэх мэдээллийн кампанит аянуудын хувьд төв суурин газар амьдарч байгаа хүмүүст интернэт болон телевизээс голдуу мэдээлэл авч, хөдөө амьдарч байгаа иргэд телевизээс голдуу мэдээлэл авсан байна (NSO, 2023).

Тэгвэл энэхүү судалгаанд хамрагдсан 50 хохирогчдын ихэнх нь цагдаад дуудлага өгч бүртгүүлсний дараа НЦҮТ, ТХБ-ны талаарх мэдээллийг анх удаа авсан байх бөгөөд цагдаагийн байгууллагаар дамжуулан холбогдож, үйлчилгээ авсан байсан. Энэ нь олон нийтээс мэдээлэл аваагүй үед цагдаагийн албан хаагч хамгаалах байрны үйлчилгээг санал болгож, мэдээлэл өгч буй гол тал болохыг харуулж байсан. Үйлчилгээний талаар урьдчилан мэдэж, шууд ТХБ, НЦҮТ-д хандсан хүн 18% (5 хүн тутмын 1 орчим) байсан нь ҮСХ-ны судалгааны дүнтэй ижил түвшинд юм. Үүнээс харахад хамгаалах байрны үйлчилгээний талаарх ойлголт хангалтгүй хэвээр байгаа бөгөөд энэ нь хохирогчдын үйлчилгээний хүртээмжид шууд нөлөөтэй юм.

Шигтгээ 3

...Хамгаалах байр байдаг гэдгийг мэддэг байсан ч бүр хэвтэрт ортлоо зодуулсан хүнд хүмүүс очдог газар л гэж боддог, тийм ойлголттой байсан. Тэгэхээр хүмүүст таниулах, мэдээлэл өгөх ажлууд хийвэл хэрэгтэй...

...Хуулийн болон халамжийн ямар нэг үйлчилгээ аваагүй, тийм үйлчилгээ үзүүлдэг гэж мэдээгүй юм байна. Чиний ярианаас хамгаалах байранд ийм үйлчилгээнүүд авах боломжтой байсан юм уу гэж бодож байна.

...Өмнө нь огт мэдээлэлгүй байсан. Цагдаад хандаад тэндээс л мэдээлэл аваад ирсэн шд. Саяхан манай нэг найз бас нөхөртөө зодуулаад гээд ярьж байсан. Намайг өмнө нь хамгаалах байранд байрлаж байсныг мэдэх болохоор яаж ханддагийн, яадаг юм гээд залгаж байсан. Хүмүүс ер нь ихэнх нь хамгаалах байрны талаар мэдээлэлгүй байдаг шүү.

ТХБ-аар үйлчлүүлэгчдийн ярианаас

Мөн даван туулагч нартай хийсэн кейс ярилцлагын үр дүнгээр зарим хохирогч хамгаалах байрны үйлчилгээ аваад гарсан ч дараа нь чухам ямар үйлчилгээ авах боломжтой байсан талаар хангалттай ойлголтгүй хэвээр байгаа тухайгаа дурдсан байна. Ихэнх тохиолдолд үйлчлүүлэгчид хамгаалах байр нь зөвхөн аюултай орчноос холдох, түр хугацаанд байрлах боломжийг олгодог гэж ойлгож, бусад нэмэлт үйлчилгээний талаар өөрийн саналаа илэрхийлэх нь бага байгаа нь ажиглагдсан. Өөрөөр хэлбэл, үйлчлүүлэгчийг анх ирсэн цагаас нь эхлэн сэтгэл зүй, эрх зүй, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ авах боломжтой талаар бүрэн мэдээлэл өгөх нь хохирогчийг эрх мэдэлжүүлэх, чадавхжуулах буюу даван туулагч төвтэй арга хандлагыг хэрэгжүүлэх хамгийн эхний алхам болох тул цаашид иргэдэд ТХБ/НЦҮТ-өөс авах боломжит үйлчилгээдийг таниулах хэрэгцээ байна.

Түр хамгаалах байрны төрөлжүүлсэн үйлчилгээ хязгаарлагдмал хэвээр байна. Хүчирхийллийн хохирогчдыг гэмт хэргийн төрөл, сэтгэцэд үзүүлэх нөлөө, бие махбодод учруулсан гэмтлийн байдлаас шалтгаалан төрөлжүүлэн байрлуулах хэрэгцээ байсаар байгаа бөгөөд хүйс болон тусгай хэрэгцээгээр нь ангилах шаардлага ч үүсдэг. Олон улсад түр хамгаалах байр нь ямар ч бэрхшээлтэй, онцлог хэрэгцээтэй хүнд хүртээмжтэй байхыг шаарддаг бөгөөд ямар ч төрлийн хүчирхийлэлд өртсөн хүнд үйлчлэх боломжтой байх зарчмыг баримталдаг. Гэвч бэлгийн хүчирхийлэл болон ХХГХ-ийн хохирогчид ихэвчлэн сэтгэл зүйн хувьд илүү хүнд гэмтэлтэй, урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ шаарддаг тул тусгайлан төрөлжүүлсэн байрлуулах зайлшгүй хэрэгтэй гэж үздэг.

Бодит байдал дээр янз бүрийн гэмт хэргийн хохирогчдыг нэг дор байрлуулах нь сөрөг үр дагавартай байдгийг ч хамгаалах байрны ажилтнууд онцолж байна. Тухайлбал, хохирогчид бие биедээ сөргөөр нөлөөлөх, буруу ташаа мэдээлэл түгээх, дээрэлхэх, сэтгэл зүйг нэмж гэмтээх, зан харилцааны таагүй уур амьсгал үүсгэх байдлууд нийтлэг үүсдэг байна. Иймээс хамгаалах байрны үйлчилгээг гэмт хэргийн төрлөөр төрөлжүүлэх хэрэгцээ өндөр бөгөөд холбогдох журамд ч энэ талаар тусгасан байдаг. Тухайлбал, ТХБ-ны үйлчилгээ үзүүлэх журмын 2.5-д *түр хамгаалах байрыг хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, эрэгтэй, эмэгтэй хохирогчдын хэрэгцээнд тохируулан төрөлжүүлэн байгуулж болно* гэж заасан. Гэвч өнөөдрийн байдлаар ХГБХХЕГ-ын харьяа 108 хамгаалах байрны дэргэд зөвхөн бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүлээн авах байр, ХТЭТ болон Талита Ази ТББ-ын харьяа хүний наймааны хохирогчдыг хүлээн авах хоёр байр л үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь хамгаалах байрыг төрөлжүүлэх асуудал ахиц багатай байгааг харуулж байгаа бөгөөд цаашид энэ

чиглэлд байрны техник хүрэлцээнээс гадна үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийг хамт бэлдэж чадавхжуулах цогц дэмжлэг шаардлагатай байна.

Хүчирхийлэлд өртсөн тусгай хэрэгцээт, бэлгийн цөөнх иргэдийн онцлог хэрэгцээ нь хамгаалах байранд хангагдахгүй байх эрсдэлтэй. ЛГБТИК+, бэлгийн цөөнх бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамгаалах байранд хэрхэн байрлах, үйлчилгээ авах нь ТХБ болон НЦҮТ-ийн мэргэжилтнүүдийн мэдлэг, хандлагаас шууд хамаарах нөхцөлд байна. Хохирогчийг түр хамгаалан байрлуулах MNS 6040:2019 стандартын 7.13-д ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээг харгалзан, хүртээмжтэй орчин бүрдүүлэх талаар заасан боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх боломжтой хамгаалах байр цөөхөн хэвээр байна. Харин ЛГБТИК+ хүмүүсийн хувьд, ялангуяа трансжендэр иргэдийг хэрхэн байрлуулах, хамгаалах байранд ялгаварлан гадуурхахгүй байх талаар ямар нэгэн тусгай заалт байхгүй, стандарт, зааварчилгаа тодорхой бус байна. Үүнээс шалтгаалан өөрийн бэлгийн чиг баримжааг ил тод илэрхийлээгүй иргэд хамгаалах байранд хандах боломжтой боловч, хүйсийн ялгаатай байдлыг илэрхийлсэн кейсийн үед хэрхэн зохицуулах талаар чиглэл тодорхойгүй байгаа нь тэдний үйлчилгээ авах нөхцөлд сөргөөр нөлөөлнө. Энэ чиглэлд ХТЭТ, НҮБХАС, ГХУСА33-өөс 2024 оны 10-р сард үйлчилгээ үзүүлэгчдийг чадавхжуулах, сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, цагдаа, эмнэлгийн байгууллага, ТХБ, НЦҮТ-ийн 30 гаруй албан хаагчдыг хамруулсан. Гэсэн хэдий ч цаашид хамгаалах байрны стандартад ЛГБТИК+ болон бэлгийн цөөнх хүмүүс хамгаалах байранд хандахад хэрхэн үйлчилгээ үзүүлэх талаар нарийвчлан тусгах нь даван туулагч төвтэй хамгааллын үйлчилгээг нэвтрүүлэхэд чухал алхмын нэг болох юм.

Шигтгээ 4

... Т бол трансжендэр эмэгтэй, орон нутагт төрж өссөн боловч гэр бүлийнхэн болон нутгийн хүмүүстээ гадуурхагдсаны улмаас Улаанбаатар хотод ирж амьдарсан. Түүний хүйсийн баримжаа трансжендэр эмэгтэй гэдгийг нь мэдмэгц түүнийг хамаатнууд нь гэрээсээ хөөж, байгууллага нь ажлаас халсан. Ковид-19 цар тахал түүний амьдралд хүчтэй нөлөөлж, түрээсээ төлж чадаагүйн улмаас орон гэргүй болсон. Т гудамжинд амьдрах болж, бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэлд улам их өртөх болсон. Аюулгүй байдлыг хайж тэр хэд хэдэн удаа ТХБ-д ТББ-ын дэмжлэгтэй хандах гэж оролдсон боловч түүнд үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан. Транс эмэгтэй тул ТХБ-ны ажилтнууд түүнд үйлчилгээ үзүүлэх боломжгүйгээ мэдэгдсэн

НЦҮТ, ТХБ-ны үйлчилгээнд хийсэн мониторингийн судалгааны тайлан, ЛГБТ төв, 2024

Аюулгүй байдлыг хангаж байгаа ч үйлчилгээний орчин нөхцөл тааруу: Хохирогчид хамгаалах байранд ирэх үед нууцлалын гэрээ байгуулах, харуул хамгаалалттай болохыг тайлбарлах, холбогдох ажилтнууд ээлжээр хонож ажиллах зэрэг журмын дагуу авдаг арга хэмжээнүүд нь аюулгүй байдлын мэдрэмжийг нэмэгдүүлж, хохирогчдод итгэлтэй мэдрэмжийг төрүүлж чаддаг. Үйлчилгээ авсан хохирогч (судалгаанд хамрагдсан иргэд)-дын аюулгүй мэдрэмжийн түвшинг 1-5 хүртэлх шкалаар үнэлүүлэхэд, үйлчилгээ авахын өмнө дунджаар 2.41 байсан бол дараа нь 3.85 болж нэмэгдсэн нь хамгаалах байрны аюулгүй байдлыг хангах үйлчилгээний үр дүнг харуулж буй юм. Мөн авсан үйлчилгээг төрлөөр нь сэтгэл ханамжийг үнэлүүлэхэд аюулгүй байдлын хамгаалалт хамгийн өндөр буюу 98%, хохирогчид үйлчилгээ авах явцдаа өөрийгөө бүрэн аюулгүй мэдрэмжтэй байсан гэж хариулжээ.

ЖСХ-ийн хохирогч нь ТХБ-нд зөвхөн аюулгүй байдлаа хамгаалуулахаас гадна сэтгэл зүйн тайван байдлаа хамгаалуулах, таатай тогтвортой орчин бүрдүүлэх, тав тух алдагдахгүй байхад байрны орчин нөхцөл чухал нөлөөтэй. Даван туулагч төвтэй аргачлалын дагуу хамгаалах байрны үйлчилгээ, орчин нөхцөл нь үйлчлүүлэгчид аюулгүй байдлын мэдрэмжийг төрүүлэхүйц байх ёстой гэж үздэг. Гэтэл бодит байдал дээр ТХБ-уудын үйлчилгээний орчин нөхцөл, тав тухыг тааруу гэж дүгнэж болохоор байна¹⁰.

2022 онд улсын 12 ТХБ, НЦҮТ-дийн дунд хийсэн түр хамгаалах байрны стандартын хэрэгжилтийг үнэлсэн судалгаагаар хамгаалах байрны орчин нөхцөл тааруу байгааг онцолсон байх бөгөөд үүнээс хойш хамгаалах байрны орчин нөхцөл сайжраагүй болох нь тус судалгааны хүрээнд цуглуулсан анхдагч мэдээлэл, талбар дахь ажиглалтаас харагдаж байв. Тухайлбал, ЖСХ-ийн насанд хүрсэн

¹⁰ Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээ

хохирогчдыг голлон хүлээж авч байгаа ЦЕГ-ын харьяа ТХБ нь 1978 онд ашиглалтад орсон барилгад 2014 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байна. Хамгаалах байрны халаалт, дулааны асуудал, ариун цэврийн өрөөний орчин нөхцөл хангалтгүй байх, урсгал засвар удаан хийгдээгүйгээс ус алдах, дусаал гоожих зэрэг асуудлууд үйлчилгээ авсан хүмүүсийн саналд олонтаа дурдагдаж байв.

Шигтгээ 5

Орчин нэлээн тухгүй, тухай үед жаахан бороотой байхад л сэрүүхэн байсан өвөл бол нэлээн хүйтэн байхаар санагдсан...

...Чийгтэй орчинд хүүхэд маш их өвдсөн, хүүхдээ өвтгөхгүйн тулд цэвэрлэгээ муутай байсан болохоор би өөрөө цэвэрлэгээ хийсэн. Тэр хавийн хүмүүсийг нь дайчилсан, хүмүүс жаахан дурамжхан л байсан байх...

...Дуусаал гоождог, чийгтэй, сэрүүхэн, манай хүүхдүүд тийм орчинд байж үзээгүй болохоор сэтгэл санаа нь таагүй байгаа дээрээ бүр сэтгэл зүй нь унаад хэцүү байсан...

ТХБ-аар үйлчлүүлэгчдийн ярианаас

Мөн ХГБХХЕГ-ын харьяа бусад хамгаалах байруудын ашиглалтын нөхцөл ч стандартад нийцэхгүй байдлууд ажиглагдсан. Барилга байгууламж, зай талбай, тохижилтын хувьд шаардлага хангахуйц хамгаалах байр цөөн байгаа бөгөөд урсгал засвар удаан хийгдээгүйгээс барилгын нөхцөл муудаж, эвдрэл гэмтэл, ажиллагаагүй болсон зүйлс нэмэгдсэн нь үйлчлүүлэгчдийн тав тух, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Аюулгүй байдлын үйлчилгээг тогтвортой үзүүлэхэд санхүүжилтийн хүрэлцээ муу байдгаас хангамжийн дутагдал үүсэж, үйлчилгээ үзүүлэгчдийн ажлын цар хүрээ хумигдаж буйг практик дээр ажиллаж буй мэргэжилтнүүд онцолж байв.

Шигтгээ 6

...Хохирогчдыг эмнэлэг рүү зөөх, хүүхдүүдийн боловсролын үйлчилгээг тасалдуулахгүй байлгах зэрэгт байнга хүмүүсээ нааш цааш зөөх хэрэгтэй болдог шдээ. Цэцэрлэгт нь зөөх гээд, өнөөдөр бид нар ярьж байсан, нэг багш маань өдөрт 1000 төгрөг гэхээр 7 хоногт 5000 төгрөгөөр нэг хүүхдийг зөөж байна. Ямар сайндаа сарын дотор нэг багш дээр 20,000 төгрөг гарчихлаа гээд тооцоо хийгээд байж байна. Энэ болгонд ямар ч зардлын эх үүсвэр байхгүй, багш маань өөрөөсөө гаргаад л явж байна. Бас үйлчлүүлэгчээ хаа хамаагүй гадуур дотуур авч явахад эрсдэлтэй байдаг учраас өөрсдийн гэсэн машинтай байх хэрэгцээ маш их байдаг...Гадуур явж байхад таньдаг мэддэг хүнтэйгээ таарчихвий гэж хүмүүс их санаа зовдог...

...Харахад бүх өрөөнд камертай мэт боловч зарим нь ажиллахаа больчихсон. Зарим нь зөвхөн хязгаарлагдмал хүрээнд нь л хардаг болохоор байрлаж байгаа хүн, хүүхдүүд удаад ирэхээр камерт тусдаггүй бүс, хэсэг зэргийг сайн мэддэг болчихдог...

... Манай барилга их удаж байгаа барилга учраас зарим цонх нь цантаад ус гүйгээд бүр юу ч харагдахгүй больчихсон, цонхоороо дулаанаа алдаад зарим өрөөнүүд нь хүйтэн, сэрүүхэн өвөлждөг... Байрны засварын зардал гэж байдаггүй болохоор нөгөө л хувьсах зардлаасаа л бид нар илүүчилдэг...

ТХБ-ны мэргэжилтнүүдийн ярианаас

ОУБ-аас хэрэгжүүлсэн тохижилт, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг харвал:

- 2016-2020 оны хугацаанд Швейцарийн хөгжлийн агентлаг (ШХА), НҮБХАС-аас хэрэгжүүлсэн “Монгол Улсад Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн 1-р шатны хүрээнд 11 НЦҮТ (7 аймаг, 4 дүүрэгт)¹¹-ийг шинээр байгуулж,
- 2021-2022 онд тус төслийн 2-р шатны хүрээнд 5 аймаг, 1 дүүргийн¹² түр хамгаалах байруудыг тохижуулах, техник болон арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлуудыг зохион байгуулсан (UNFPA, 2020).
- 2023 онд Азийн сан, ДЗМОУБ хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд хамгааллын түншлэл компакт” төслийн хүрээнд ХГБХХЕГ-ын харьяанд бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдийг урт хугацаанд хамгаалан байрлуулах, нөхөн сэргээх төвийг байгуулж, техникийн тусламж дэмжлэг үзүүлсэн байна.
- 2022-2024 онд мөн дээрх төслөөс хүний наймааны хохирогчдод хамгааллын үйлчилгээ үзүүлдэг ХТЭТ ТББ-ын 2 хамгаалах байрны засвар тохижилтод, Талита Ази ТББ-ын 2 хамгаалах байрны дотор болон гадаад засвар тохижилтод дэмжлэг үзүүлж, тус бүр 2-3 жилийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн (CPC, Төслийн тайлан мэдээ, , 2024).
- 2022-2024 онд АХБ-аас хэрэгжүүлсэн “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг ГБХ-тэй тэмцэх” төслийн хүрээнд Сэлэнгэ, Сүхбаатар, Увс аймгууд, Улаанбаатар хотын СХД, Налайх дүүргүүдэд шинээр ТХБ байгуулж, ХБИ-нд үйлчлэх боломжтойгоор зарим тохижилтийг хийж хүлээлгэн өгсөн (ADB, Mongolia: Combating Domestic Violence Against: Completion Report, 2024).
- Үүний дараа АХБ-аас Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлж буй “Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд НЦУГ-ын харьяа хамгаалах байрны шинэ барилгын ажил эхэлж, олон улсын стандартад нийцсэн, 40 ортой хамгаалах байр барих ажил 2023 оны 04 сараас эхлүүлээд байна. (Shelter Head, 2024).

ТХБ-ны орчин нөхцлийг дэмжих чиглэлд хөрөнгө оруулалт хийсэн орон нутгуудаас энэхүү судалгаанд хамрагдсан ЖАЙКА-ийн зорилтот байршлууд болох Дархан-Уул болон Хэнтий аймгууд, Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт 2021 онд НҮБХАС-ийн төслийн хүрээнд, СХД-ын хамгаалах байранд 2023 онд АХБ-ны төслийн хүрээнд тохижилтийн туслалцаа дэмжлэг үзүүлсэн байна. Гэсэн хэдий ч тухайн үеийн хөрөнгө оруулалтаар шийдэж чадаагүй хэрэгцээнүүд, урсгал засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн шинэчлэл, орчны бүрдүүлэлт зэрэг хэрэгцээ байсаар байгаа нь одоогийн нөхцөл байдлаас нь харагдаж байв.

- **Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ТХБ болон НЦҮТ-ийн санхүүжилтийн эх үүсвэр уялдаагүй, харьяа байгууллагын эх үүсвэрээс шалтгаалан харилцан адилгүй санхүүжилттэйгээр үйл ажиллагаа явуулж байна.** Судалгааны явцад ТХБ/НЦҮТ-үүдийн санхүүжилтийн ялгаа, түүнээс улбаалсан үйлчилгээний чанарын зөрүүг ажиглахад Монгол Улсад ТХБ/НЦҮТ-үүд нэгдсэн удирдлага, зохион байгуулалттай ажиллаж байгаа эсэхэд эргэлзээ үүсэж байв. Учир нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн харьяаллын 17 НЦҮТ, 20 ТХБ нь дөрвөн өөр байгууллагад харьяалагддаг. Үүнд: (1) Цагдаа, (2) ХГБХХЕГ, (3) Эрүүл мэндийн байгууллага, (4) Шүүх шинжилгээний байгууллага зэрэг болно. Хэдийгээр хохирогчийг хамгаалан байрлуулах үйлчилгээнд мөрдөх журам, стандарт, дүрэм, нийтлэг шаардлага зэрэг эрх зүйн баримт бичгүүд бүх ТХБ боолон НЦҮТ-д ижил хэрэгжиж байгаа ч тэдгээрийг санхүүжүүлэх эх үүсвэр нь тус бүрийн харьяа байгууллагын эх үүсвэрээс хамаарч байгаа нь санхүүжилтийн тогтвортой байдал, улмаар үйлчилгээний чанарт нөлөөлөхүйц хүчин зүйл болж байна.

2017 оны НЦҮТ-ийг санхүүжүүлэх журамд (MLSP, MoJHA, MoH, 2017) аймаг, дүүргийн НЦҮТ-ийн зардлыг аймаг, дүүргийн Засаг дарга нар нь орон нутгийн төсөвтөө суулгахаар, ГССҮТ, ШШҮХ-ийн дэргэдэх НЦҮТ-ийн зардлыг холбогдох байгууллагын төсөвт суулгахаар заасан. Гэвч бодит байдал

¹¹ Төслийн хүрээнд ЖСХ-ийн тархалт хамгийн өндөртэй 7 аймаг (Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Хэнтий, Хөвсгөл, Өмнөговь, Өвөрхангай) болон нийслэл Улаанбаатар хотын дүүрэгт (Хан-Уул, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар) нийт 11 НЦҮТ-ийг шинээр байгуулсан”. [Төслийн 1-р шатны амжилт номноос](#)

¹² Архангай, Баян-Өлгий, Дархан, Завхан, Ховд, Улаанбаатараас Баянзүрх дүүрэг

дээр эрүүл мэндийн салбарт ЖСХ-ийн хариу арга хэмжээнд зориулсан тусгай төсөв байхгүй, тухайн эмнэлгийн байгууллагын жилийн төсөвт ч тусгайлан НЦҮТ-тэй холбоотой зардал тусдаггүй. ЭМДС-аас ч санхүүжилт авдаггүй байна. Тодруулбал, эмнэлэгт түшиглэсэн ГССҮТ-ийн дэргэдэх, Сүхбаатар дүүргийн ЭМТ, Говь-Алтай аймгийн ЭМТ-ийн дэргэдэх НЦҮТ-үүд санхүүжилтийн тун хүндрэлтэй нөхцөл дунд үйл ажиллагаа явуулж байгаа нь цаашдын үйл ажиллагааны тогтвортой байдалд нөлөөлөхүйц хэмжээнд байгааг талууд онцолж байна.

Шигтгээ 7

Сүхбаат ар ДЭМТ-ийн дарга: “Манай эмнэлэг бүхэлдээ гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр санхүүжилт авч байгаа. Уг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд НЦҮТ-өөс үзүүлж буй үйлчилгээ ордоггүй тул НЦҮТ-ийн үйл ажиллагааг хэвийн явуулахад тун хүндрэлтэй байна. Үйл ажиллагааны багахан зардлыг бид дотоод нөөцөөсөө зохицуулан хүргэж ажилладаг.

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв: “Зарим НЦҮТ-үүд тогтвортой ажиллахгүй байгаа шалтгаан нь санхүүжилтгүй, бэлтгэгдсэн мэргэжилтний халаа сэлгээ их, цалин бага, ачаалал ихтэй холбоотой. КОВИД-19-ийн дэгдэлтийн үеэр Сүхбаатар дүүргийн НЦҮТ-ийн байр ковидийн шинжилгээний цэг болсон. Эрүүл мэндийн байгууллагуудын дэргэд үйл ажиллагаа явуулж буй НЦҮТ-үүд хаагдах эрсдэл өндөртэй байгаа.

ЖСХ-ийн эсрэг ЭМ-ийн салбарын хариу арга хэмжээний бэлэн байдал, судалгааны тайлангаас, НҮБХАС, 2023

ТХБ-уудын хувьд нөхцөл байдал мөн ижил, хохирогчийг түр хамгаалан байрлуулах MNS 6040:2019 үйлчилгээний стандартын дагуу хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээг нэг хүнд ногдох хувьсах зардлаар санхүүжүүлэхээр заасан. Гэвч Цагдаагийн харьяа хамгаалах байранд энэ заалт эх үүсвэргүй шалтгаанаар хэрэгждэггүй (Хүснэгт 15). Гэтэл уг хамгаалах байр нь ТХБ-даас насанд хүрсэн хохирогчдыг хамгийн их хүлээж авч, үйлчилгээ үзүүлдэг хамгаалах байр хэдий ч үйл ажиллагааны санхүүжилтгүйгээр өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулж байна (Хүснэгт 16).

Хүснэгт 15. Судалгаанд хамруулсан ТХБ-уудын мэдээлэл

#	Үзүүлсэн үйлчилгээ	Харьяалал	Байгуулагдсан он	Багтаамж (орны тоо)	Санхүүжилтийн эх үүсвэр
1	ЦЕГ-ын дэргэдэх ТХБ	ЦЕГ	2014	30	Төсвийн эх үүсвэргүй. Урсгал зардал нь ЦЕГ-ын төсвөөс шийдвэрлэгддэг.
2	СХД-ийн ТХБ	ХГБХХЕГ	2023	20	ХГБХХЕГ
3	БЗД-ийн Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, ТХБ	ХГБХХЕГ	2017	16	ХГБХХЕГ
4	Дархан-Уул аймгийн ТХБ	ХГБХХЕГ	2018	24	ХГБХХЕГ
5	Хэнтий аймгийн НЦҮТ/ТХБ	ХГБХХЕГ	2018	4	ХГБХХЕГ

Эх сурвалж: ТХБ-уудаас авсан мэдээлэл

Хүснэгт 16. Судалгаанд хамруулсан ТХБ-уудын үйлчилгээ үзүүлсэн хүний тоо, 2023-2024

	2023				2024			
	Хүүхэд		Насанд хүрэгчид		Хүүхэд		Насанд хүрэгчид	
ЦЕГ-ын Түр хамгаалах байр	203	61%	125	39%	284	62%	113	38%
СХД-ийн Түр хамгаалах байр ¹³	121	100%	0	-	352	99%	4	1%
БЗД-ийн Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр	651	100%	0	-	293	100%	0	-
Дархан-Уул аймгийн түр хамгаалах байр	75	79%	19	20%	96	90%	10	10%
Хэнтий аймгийн НЦҮТ/Түр хамгаалах байр	25	86%	4	14%	30	90%	3	10%
Нийт	1075		148		1055		130	

Эх сурвалж: ТХБ-уудаас авсан мэдээлэл

¹³ 2023 оны 09 сард ашиглалтад орсон.

- **Санхүүжилтийн эх үүсвэрийн уялдаагүй зохицуулалтаас шалтгаалан зарим ТХБ-ууд насанд хүрсэн хохирогчдыг хүлээж авахгүй байх хандлага, ойлголтын зөрүү үүсэж байна.** ТХБ-уудын зардлыг тухайн ТХБ-ыг санхүүжүүлэх үүрэг хүлээсэн төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагууд тухайн жилийн төсвийн саналдаа тусган дээд шатны байгууллагаар дамжуулан шийдвэрлүүлэх зохицуулалттай (MLSP, 2020). ТХБ-ны санхүүжилтийн хэмжээг тооцохдоо 2020 онд ХНХ-ын сайдын А/150 тушаалыг мөрддөг. Уг тушаалд зааснаар нэг хүнд ноогдох хувьсах зардлын норматив хэмжээ нь 17.5 ам.доллар (60,680 төгрөг), энэхүү зардалд хохирогчийн хоол хүнс, хувцас, ариун цэврийн хэрэглэл болон төлбөртэй тусламж үйлчилгээний зардлууд багтсан байна.

Үүний дараа 2022 онд ХНХ, Сангийн сайдын хамтран баталсан А/23, 27 Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативд гэр бүлээс тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зардлын бүрэлдэхүүнд үйлчилгээ үзүүлэгчдийн цалин урамшуулал, хүүхдийн хоол, хүүхэд хамгааллын үйлчилгээний багц зарцуудыг багтаан нэг хүүхдийн зардлыг өртсөн хүчирхийллийн төрлөөс хамааран 23.4-1,372.5 USD (81,439-4,760,799 төгрөг) байхаар тогтоосон (MLSP&MoF, 2022). Уг зардал нь ХГБХХЕГ-аар дамжин Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлаас гарахаар эх үүсвэрийг зохицуулсан.

ТХБ үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журамд нэг байрны нийт хүлээн авах үйлчлүүлэгчдийн 20%-ийг насанд хүрэгч, 80%-ийг хүүхэд байхаар тооцож санхүүжилтийг олгохоор журамд тусгажээ. Өөрөөр хэлбэл, ТХБ нийт үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн зардлаа Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлаас ажилласан кейсийн тоогоор, насанд хүрэгчдийн зардлыг орон нутгийн жилийн төсөвтөө суулгах байдлаар шийдвэрлэж байна (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Түр хамгаалах байрны санхүүжилтийг зохицуулж буй журмууд

Журам	Багтсан зардлууд	Норматив дүн
Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив , 2022, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаал	Гэр бүлээс тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зардлын бүрэлдэхүүнд үйлчилгээ үзүүлэгч (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хуульч, эмч, үйлчилгээний ажилтан, харуул г.м)-д олгох цалин урамшуулал, хүүхдийн хоол, хүүхэд хамгааллын үйлчилгээний багц зардал багтана.	Үл хайхрах- 81,439 Сэтгэл санааны- 287,340 Бие махбодын- 257,340 Бэлгийн зүй бус- 4,760,799 төгрөг
Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам , 2020, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/150 дугаар тушаал	Хоол хүнс, Хувцас, ариун цэврийн хэрэгсэл, Төлбөртэй тусламж үйлчилгээ (эрх зүйн, холбон зуучлах, нөхцөл байдлын үнэлгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ, хүүхэд хамгаалал, хөгжлийн үйлчилгээ)	Түр хамгаалах байранд байрлах нэг хүнд ногдох хувьсах зардлын дундаж норматив 60,680 төгрөг

ХГБХХЕГ-ийн харьяа ТХБ-ууд нь Хүүхэд хамгааллын зардлаас голлон санхүүждэг, орон нутгийн төсвөөс тусдаа төсөв авах эсэх нь жигд биш байгаатай холбоотой насанд хүрсэн хохирогчдыг хүлээн авахгүй байх нөхцөл байдал үүсэж, насанд хүрсэн хохирогчдыг Цагдаагийн байгууллагын харьяа хамгаалах байр луу илгээх (Улаанбаатарт), энэ нь цаашлаад насанд хүрэгчдийг зөвхөн Цагдаагийн харьяа хамгаалах байранд хүлээж авдаг гэх ойлголтод хөтөлсөн байдал нийслэлийн бусад ТХБ-ны ажилтнуудтай ярилцлага хийх явцад ажиглагдсан. Гэтэл Цагдаагийн харьяа хамгаалах байр нь жилд 300 гаруй хохирогчийг харьяалал харгалзалгүй хүлээн авдаг, хамгийн хүчин чадал бүхий (30 ортой) байр хэдий ч хувьсах зардлын санхүүжилтгүй, зөвхөн цагдаагийн байгууллагын дотоод нөөцөөс урсгал зардлаа зохицуулж байна.

Энэ мэт санхүүжилтийн уялдаагүй байдал нь үйлчилгээний хүртээмж, чанарт сөргөөр нөлөөлж, зарим хамгаалах байруудын ачааллыг хэт нэмэгдүүлж, улмаар хохирогчдын хамгааллын үйлчилгээ авах боломжийг хязгаарлах эрсдэлтэй байна. Иймд санхүүжилтийн механизмыг тодорхой болгож, бүх хамгаалах байруудад хамаарах хүртээмжтэй, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бий болгох шаардлага тулгарч байна.

- **ТХБ-нд үзүүлж буй үйлчилгээ нь олон талт бус, хохирогчийн сэтгэл зүйг дэмжих болон хөгжих боломж хомс байдгаас үүдэн хохирогчид удаан хугацаагаар байрлах тусам сэтгэл зүйд нь сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.** ТХБ нь үндсэндээ аюулгүй байдлын хамгаалалт болон сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлж, бусад үйлчилгээг цогцоор нь үзүүлэх тал дээр учир дутагдалтай байна. Судалгаанд оролцсон хамгаалах байранд байрлаж байсан эмэгтэйчүүдийн 30% нь хэрэг хянан шийдвэрлэх үйл явцын улмаас 4 болон түүнээс дээш долоо хоног байрласан бөгөөд энэ хугацаанд хамгааллын үйлчилгээний талаарх сэтгэл ханамж нь байрласан хугацаанаас хамааран буурах хандлагатай байгаа нь тоон судалгаа болон кейс ярилцлагуудаас харагдаж байсан. Үүний гол шалтгаан нь хамгаалах байр нь удаан хугацаанд байрлаж буй хохирогчдод "хамгаалагдаж" байгаа гэхээсээ илүүтэй "зорчих эрхээ хязгаарлуулсан" мэт мэдрэмж төрүүлдэгтэй холбоотой юм. Үйлчлүүлэгчид дараах гол асуудлуудыг онцолж байв.
 - НЦҮТ, ТХБ-нд баримтлах дотоод журмын дагуу аюулгүй байдлын үүднээс хохирогчдын гар утсыг хураадаг хэдий ч 3 болон түүнээс дээш долоо хоног байрлаж буй иргэдийн хувьд энэ нь гэр бүл, ойр дотнынхонтойгоо холбоо тогтоох боломжгүй болгож, сэтгэл зүйд нь сөргөөр нөлөөлдөг байна.
 - Гар утасгүй, интернэтгүй, гадаад орчноос бүрэн тусгаарлагдсан хэдий ч хамгаалах байр дотор сэтгэл зүйг тогтворжуулах, хөгжих боломж бүхий үйл ажиллагаа дутмаг байна. Үйлчлүүлэгчид ихэвчлэн хооллох, долоо хоногт 2-3 удаа мэргэжилтэнтэй уулзахаас өөр хийх зүйлгүй байдаг нь удах тусам сэтгэл зүйн хувьд сөргөөр нөлөөлдөг байна. Эдгээр асуудлууд нь хамгаалах байрны үйлчилгээний чанар, үр нөлөөг сайжруулах шаардлагатайг харуулж байгаа бөгөөд хохирогчдыг зөвхөн хамгаалахаас гадна тэдний сэтгэл зүй, нийгмийн харилцаа, хөгжих боломжийг дэмжсэн илүү даван туулагч төвтэй орчинг бүрдүүлэх нь зүйтэй юм.

Шигтгээ 8

... Хамгаалах байранд байрлаж байгаа хүмүүст сургалт, хөгжлийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх хэрэгтэй санагддаг. Тэр болгон нь өөрөө хөдөлмөрт суурилсан засал болж чадна. Тэндээс гарахдаа гар урлал, оёдол ч юм уу нэг үр чадвар шинээр сураад гарвал бас хэчнээн хамгаалуулж байгаагаас гадна, тэнд хоригдож байгаа юм шиг мэдрэмж авахгүй байх. Тийм зүйл байхгүй болохоор утсаа хураалгачихсан хүн чинь элдвийн зүйл бодогдоод зарим хүнд бол өдөр өнгөрч өгөхгүй маш хэцүү санагддаг...

... Энд байх хугацаандаа сургалт, хөгжлийн үйлчилгээнүүд байвал хэрэгцээтэй байна. Би нялх хүүхэдтэй болохоор гайгүй байгаа ч бусад хүмүүсийг харахаар их хүйцгүй харагдаад байдаг. Онлайн номын сан ч юмуу, эсвэл фэйсбүүк, youtube ордоггүй хязгаарлалттай компьютер эд ч юмуу байвал цагийг дэмий өнгөрөөхгүй, хөгжил талаасаа хүн нэг ч болтугай зүйл сураад гарч байвал тэр нь хэрэгтэй байх. Тэнд байх хугацаа хайран. Зүгээр л суугаад байх....

ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн ярианаас

... Тэнд хэт удаан байхаар хүүхдийн сэтгэлзүйд бас сөрөг нөлөөтэй юм шиг санагдсан. Утасгүй болохоор хийх юм цөөтэй. Гарч орж болохгүй гэхээр нэг л хоригдоод байгаа мэдрэмж их авдаг байсан. Би яахав, зохицуулагч багштайгаа хааяа ярьж байгаад хааяа нэг утсаа аваад хүүхдийнхээ багштайгаа холбогддог байсан. Гэхдээ л утасгүй, гарч болохгүй гэхээр удах тусмаа хүнд эсрэгээрээ сөрөг мэдрэмж өгч эхлэхээр...

ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн ярианаас

НЦҮТ ба ТХБ-ны ялгаа, зохион байгуулалтын асуудал. ТХБ, НЦҮТ-ийн гол ялгаа нь аль үйлчилгээг нэн тэргүүнд үзүүлэх үүрэгтэй вэ гэдгээрээ ялгардаг. Тухайлбал, НЦҮТ нь эмнэлэг, шүүх, цагдаа зэрэг хууль сахиулах байгууллагуудыг түшиглэн байгуулагдсан тул эрүүл мэнд, хууль эрх зүй, сэтгэлзүйн үйлчилгээг нэн тэргүүнд үзүүлдэг. Үүний зэрэгцээ, шаардлагатай тохиолдолд хохирогчид 24-72 цагийн хугацаанд түр хамгаалах үйлчилгээ авах боломжтой. Харин нөхцөл байдлаас шалтгаалан урт хугацааны аюулгүй байдлын хамгаалалт шаардлагатай бол ТХБ-нд шилжин байрлах зохицуулалттай. Өөрөөр хэлбэл, НЦҮТ нь хямралын үед түр хугацаанд үйлчлэх дамжин өнгөрөх төвийн үүрэг гүйцэтгэдэг. Харин ТХБ нь хохирогчийг аюулгүй байршуулахыг нэн тэргүүний зорилгоо болгодог бөгөөд бусад үйлчилгээг холбогдох байгууллагуудтай хамтран үзүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 18. НЦҮТ, ТХБ-ны ялгаа

	Нэг цэгийн үйлчилгээний төв	Хамгаалах байр
Гол үйлчилгээ	Эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль зүйн зөвлөгөө, нийгмийн халамжийн үйлчилгээ, холбон зуучлах үйлчилгээ	Аюулгүй байдлыг хангах
Боломжит үйлчилгээ	Түр хугацааны (24 цаг) аюулгүй байдлыг хангах	Эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль зүйн зөвлөгөө, нийгмийн халамжийн үйлчилгээ
Гол зорилго	Хохирогчийг нөхөн сэргээх, хууль эрх зүйгээр дэмжих	Хохирогчийг шууд аюулгүй байлгах
Үйлчлүүлэгчид	ТХБ-нд байрлаж байгаа хохирогчид, гаднаас ирэх өдрийн үйлчлүүлэгчид	Зөвхөн хамгаалах байранд байрлаж буй үйлчлүүлэгчид
Нууцлалын зэрэг	Байршил нээлттэй	Байршил нууцлалын зэрэгтэй

Гэвч практик дээр НЦҮТ болон ТХБ нь яг ижил үйлчилгээг ижил бүтэц, зохион байгуулалтаар үзүүлж байгаа буюу ТХБ, НЦҮТ хооронд ямар нэг ялгаа байхгүй байх нөхцөл ажиглагдсан. Ялангуяа, ХГБХХЕГ-ын харьяа НЦҮТ-үүдийн хувьд энэ байдал нь илүү тодорхой ажиглагдаж байна. Эмнэлэг, цагдаа, шүүх шинжилгээний байгууллагыг түшиглэсэн НЦҮТ нь үндсэн хэлбэрийнхээ дагуу ажиллаж байгаа бол, ХГБХХЕГ-ын харьяа НЦҮТ болон ТХБ нь нэг дор зэрэгцэн үйл ажиллагаа явуулж байгаа жишээ түгээмэл байна. Тухайлбал, Хэнтий аймгийн ТХБ-ны тухайд төв нь ХГБХХЕГ-ын харьяанд бүртгэлтэй хэдий ч нэг барилгад НЦҮТ болон 4 ортой ТХБ хамтдаа үйл ажиллагаа явуулдаг байна. Энэ нөхцөл байдал нь ХГБХХЕГ-ын харьяа ТХБ, НЦҮТ-ийн чиг үүргийн нэгдэх, үйлчилгээний хоёр тусдаа нэгж хоорондын ялгааг бүдгэрүүлж, тодорхойгүй байдал үүсгэж байв.

Шигтгээ 9

Манай аймагт 'Нэгдсэн үйлчилгээний төв' гэж нэрлээд байгаа нь хамгаалах байр шүү дээ. Үйл ажиллагаа нь хамгаалах байрны үйлчилгээ явуулж байгаа. Урт хугацаагаар байрлуулж, хамгаалж байрлуулдаг. Байрлал нь нууц байж цагдаагаар дамжиж очих ёстой. Харин нэг цэгийн үйлчилгээ гэдэг нь яарсан, сандарсан хүмүүс, шөнө дунд гарч ирээд шууд очих газаргүй байгаа хүмүүсийг хүлээж авах ёстой. Хүмүүс хаана очихоо мэддэг байх ёстой. Гэвч энэ төвүүд нь хаана үйл ажиллагаагаа явуулдаг, хэнд үйлчилгээ үзүүлээд байгаа нь тодорхойгүй байдаг. Энэ хоёрын ялгаа маш тодорхой байх ёстой. Нэг цэгийн үйлчилгээний төв нь эмнэлэгийнхээ дэргэд байх нь хамгийн тохиромжтой юм.

ТББ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Үүнээс гадна НЦҮТ-ийн журмаар үйлчилгээг 24 цагийн турш үзүүлэх зохицуулалттай боловч боловсон хүчний хүрэлцээ дутмаг байдлаас шалтгаалан ХГБХХЕГ-ын харьяа НЦҮТ нь ихэвчлэн өдрөөр үйлчилгээг үзүүлж байна. Үүний улмаас шөнийн цагаар эсвэл амралтын өдрүүдэд тусламж авах шаардлагатай иргэд ажлын өдөр, ажлын цагийг хүлээхээс өөр аргагүй нөхцөл байдалд ордог. Мөн тус төв зөвхөн нэг ээлжийн сэтгэл зүйчтэй тул мэргэжилтэн орон нутагт, хөдөө сумдад ажиллаж байх үед НЦҮТ болон ТХБ-д хандсан хохирогчдод үйлчилгээ үзүүлэх боломжгүй болж, үйлчилгээ тасалдах эрсдэл үүсэж байна. Эдгээр нөхцөл байдал нь НЦҮТ-ийн 24 цагийн турш тасралтгүй үйлчилгээ үзүүлэх боломж бодит байдал дээр бүрэн хангагдаж чадахгүй байгааг харуулж байсан.

ТХБ-аас гарсны дараах хохирогчийн аюулгүй, бие даасан байдал: Хохирогч нь НЦҮТ-д 24-72 цагийн хамгааллын үйлчилгээ авч, цаашдын хамгаалал шаардлагатай тохиолдолд ТХБ руу шилжиж, үйлчилгээг үргэлжлүүлдэг. ТХБ-нд хохирогчдын дундаж байрласан хугацаа 7-14 хоног байдаг. Гэвч хамгаалах байрнаас гарсны дараа тэд хаана очих вэ гэдэг асуудалтай тулгардаг.

ЖСХ-ийн онцлог нь хохирогч хүчирхийлэгчээс эдийн засгийн болон эрх мэдлийн олон хэлбэрийн хамааралтай болсон байдаг. Үүний улмаас хүчирхийлэлтэй орчин руугаа буцаж очихоос өөр сонголтгүй болох нь түгээмэл байна. Одоогийн хамгааллын үйлчилгээ нь богино хугацаанд хохирогчийн аюулгүй байдлыг хангаад, улмаар түүнийг гэр бүл рүү нь буцаах нөхцөл байдал үүсгэж байна.

Судалгаанд хамрагдсан хохирогчдын хувьд ТХБ-аас гарсны дараах "орон сууцны дэмжлэг" хамгийн их хэрэгцээтэй тусламж, дэмжлэг гэж дурдагджээ. Хохирогч ТХБ-нд байх хугацаандаа эрх зүйн болон

сэтгэл зүйн дэмжлэг авч, хүчирхийлэгчээс салах шийдвэр гаргасан ч шууд очих газаргүйгээс болж эргээд хүчирхийлэлтэй орчин руу буцах тохиолдол элбэг байдаг.

Монгол Улсад ийм нөхцөлд хамаатан садан, эцэг эх, ах эгч дүүгийн дэмжлэгийг авч, айлд түр хугацаанд амьдрах эсвэл найз нөхдийндөө байрлах зэрэг нийгмийн капиталдаа тулгуурлан асуудлаа түр хугацаанд шийдвэрлэх арга хэмжээг түлхүү авдаг. Гэвч энэ нь хохирогчийн бие даасан байдлыг улам сулруулахаас гадна нэр төрөө хамгаалах соёл, бусдад төвөг учруулахгүй гэх бодлоос үүдэн хүчирхийлэгчтэй харилцаа, гэр рүүгээ эргэж очихоос өөр аргагүй нөхцөлд хүргэдэг байна.

1.2.2 Эрх зүйн туслалцаа

Судалгаанд хамрагдсан иргэдийн тодорхойлсноор ЖСХ-ийн хохирогчдод хууль зүйн туслалцаа үзүүлэх нь хохирогчдод нэн шаардлагатай, хамгийн хэрэгцээтэй үйлчилгээний нэгээр дурдагдсан. Хуулийн дагуу ЖСХ-ийн хохирогчид үзүүлж буй эрх зүйн туслалцаа нь (1) эрх зүйн зөвлөгөө, (2) өмгөөллийн үйлчилгээ гэсэн 2 төрөлтэй (GoM, 2022). Эдгээр үйлчилгээг ЖСХ-ийн хохирогчид биечлэн, утсаар, цахим хэлбэрээр дараах талууд үзүүлж байна:

- **Шуурхай тусламжийн утас:** ГБХ-д өртсөн хохирогчдод 107, 108 дугаарын утсаар үнэ төлбөргүй эрх зүйн зөвлөгөө өгдөг
- **Хууль зүйн туслалцааны төв-** Эрх зүйн туслалцаа авах боломж хязгаарлагдмал иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй байгууллага. 2024 онд тус төв нийт 3,026 үйлчлүүлэгчид хууль зүйн туслалцаа үзүүлж, 11,498 удаагийн эрх зүйн зөвлөгөө өгч, 2,927 хүнд өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэсэн. Үүний ойролцоогоор 12.3% нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хэргүүд байна.
- **ХГБХХЕГ, Хамтарсан багийн мэргэжилтнүүд-**ТХБ/НЦҮТ-ийн нийгмийн ажилтан болон холбогдох мэргэжилтнүүд үйлчлүүлэгчиддээ анхан шатны эрх зүйн зөвлөгөө туслалцааг үзүүлдэг.
- **ТББ-ууд:** Магадлан итгэмжлэгдсэн иргэний нийгмийн байгууллагууд ЖСХ-ийн хохирогчдод анхан шатны эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байна.

Мөн ОУБ-аас ЖСХ-ийн хохирогчдод үзүүлэх эрх зүйн туслалцааг сайжруулах чиглэлд идэвхтэй ажиллаж байна. Тухайлбал, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ, IDLO) нь 2018 оноос хойш тасралтгүй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, ГБХ-ийн хохирогчдод хохирогч-төвтэй хандлагад суурилсан хууль зүйн туслалцаа авах хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

ОУЭЗХБ нь: 2018-2020 онд АНУ-ын санхүүжилтээр, 2020-2023 онд Канадын санхүүжилтээр "Монгол Улсад ЖСХ-тэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх" төслүүдийг хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд:

- ГБХ-ийн хохирогчдод эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг ИНБ-уудыг нэгтгэсэн ["ИНБ-уудын Хамтын Хүч Түншлэл"](#) форумыг байгуулсан. Форумд Улаанбаатар хот болон 19 аймгийн 61 ТББ нэгдсэн. Уг Форум нь нөлөөллийн ажил болон холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх нэгдсэн платформтой бөгөөд 1) 26 гишүүн хууль зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээ үзүүлдэг бол 2) 36 гишүүн ЖСХ-ийн талаар олон нийтэд зориулсан хэлэлцүүлэг, эрсдэлт бүлэгт зориулсан сургалтуудыг тогтмол явуулж, 3) хохирогч-төвтэй хандлагыг бодлогод тусгах чиглэлээр МУЗГ-т нөлөөллийн ажил хийж байна. ИНБ-уудын Форумын 36 гишүүдтэй хамтран ЖСХ, түүний суурь шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийн талаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, олон нийтэд зориулсан 123 хэлэлцүүлгийг 2,213 хүнд, эрсдэлт бүлгийн иргэдэд зориулсан 217 сургалтыг 4,344 хүнд (90% эмэгтэй, 10% эрэгтэй) буюу хүргэжээ.
- Мөн тус төслийн хүрээнд ГБХ-ийн хохирогчид эрх зүйн анхан шатны зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ хэрхэн үзүүлэх талаарх сургалтуудыг 467 мэргэжилтнүүдэд (236 эмэгтэй, 231 эрэгтэй) явуулж, орон нутаг дахь доороос дээш чиглэсэн (bottom-to top) санаачилгуудыг дэмжиж Ховд, Баян-Өлгий, Дорноговь, Өвөрхангай, Дорнод, Увс, Төв, Завхан, Дархан-Уул аймгуудад дэд төслүүдийг хэрэгжүүлэх грантуудыг санхүүжүүлжээ.

Тэдгээр дэд төслүүдээс ЖАЙКА-ийн зорилтот аймгуудын нэг болох Дархан аймагт Цагдаагийн алба хаагчдыг хохирогч-төвтэй арга зүйн сэдвээр сургаж, 11 эрх зүйн хөтчийг бэлтгэх сургалтыг Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо ТББ-аас зохион байгуулсан байна.

Эдгээр үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж, эерэг ахиц дэвшил гарсан тул төслийн дараагийн шатны хэрэгжилтийг 2025 оны 4-р сараас өмнө эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Төслийн хоёр дахь шатанд хохирогчдод үзүүлэх эрх зүйн туслалцааны хүртээмжийг үргэлжлүүлэн нэмэгдүүлэхийн зэрэгцээ ТХБ болон НЦҮТ-ийн үйлчилгээний стандарт, журмуудыг шинэчлэх ажлуудад голлон анхаарахаар төлөвлөжээ.

Үүнтэй зэрэгцэн, ОУЭЗХБ (IDLO) нь 2025 онд "Эрх зүйн салбар дахь хүүхэд хамгаалал" төслийг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд энэ хүрээнд хохирогч болон гэрч болсон хүүхдүүдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх, цаашлаад шинэчлэгдэн батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг дэмжих чиглэлд анхаарч ажиллах тухай мэдээлэл байна¹⁴.

1.2.3 Холбон зуучлах үйлчилгээ

Хамгийн анх хохирогчтой холбоо тогтоосон байгууллага, ажилтан нь холбон зуучлах үйлчилгээг төлөвлөж, шилжүүлэх үүрэгтэй бөгөөд уг үйлчилгээний чанар, үр дүнд хяналт тавьж, кейс хаагдах хүртэл зохицуулалт хийх үүргийг хүлээдэг. Ихэнх тохиолдолд энэ үүргийг хороо, сумын хамтарсан багийн нийгмийн ажилтан эсвэл НЦҮТ-ийн нийгмийн ажилтан гүйцэтгэдэг. Уг үйлчилгээ нь ХНХ-ын сайдын 2017 оны А/73 тушаалаар батлагдсан [Холбон зуучлах үйлчилгээний журам](#)-аар зохицуулагдаж байна.

Холбон зуучлах үйлчилгээний явцад "даван туулагч төвтэй" арга хандлагыг баримтлах нь хамгийн чухал юм. Энэ арга хандлага нь хохирогчийг хамгааллын үйлчилгээнд оролцуулахдаа тэднийг өөрийн хэрэгцээ, шаардлагыг хамгийн сайн мэдэх хүн гэж үзэх бөгөөд нийгмийн ажилтнууд үүнийг үндэслэн тэднийг чадавхжуулах, мэдээллээр хангах, эрх мэдэлжүүлэхэд анхаарна. Даван туулагч төвтэй үйлчилгээний чанарт "ямар үйлчилгээ" үзүүлэхээс илүүтэйгээр "үйлчилгээг хэрхэн" үзүүлэх нь чухал болохыг онцолж үздэг. Хохирогчтой итгэлцлийг бий болгож, тэдний онцлог хэрэгцээг ойлгон, мэдээллээр хангах, сонголт хийх боломж олгох, шийдвэр гаргах эрхийг нь хүндэтгэх нь даван туулагч төвтэй хамгааллын үйлчилгээний үндсэн зарчмууд юм (Хүснэгт 19).

Хүснэгт 19. Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээ үзүүлэх үндсэн 6 зарчим

Аюулгүй байдал	Бүхий л үйл ажиллагаа, үйлчилгээ болон орчин нөхцөлөө үйлчлүүлэгчид тав тухтай, аюулгүй байдлын мэдрэмжийг төрүүлэхүйц байлгах
Итгэлцэл болон ил тод байдал	Мэргэжилтнүүд, ажилтнууд болон үйлчлүүлэгч нь үйлчилгээний бүхий л үйл явцад эрх тэгш, утга учиртайгаар оролцох
Сонголт	Үйлчлүүлэгчдээ үйлчилгээний бүхий л явцад оролцоотой байж, өөрийн саналыг хэлж, сонголт хийх боломжийг бий болгох, үйлчлүүлэгч бүрийн онцгой болон хувь хүний хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээг сонгох
Хамтын ажиллагаа	Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчид хоорондын эрх мэдлийг тэнцвэртэй байлгаж, хамтын ажиллагаатай байх
Эрх мэдэлжүүлэх, чадавхжуулах	Үйлчилгээгээр дамжуулан үйлчлүүлэгчдийг эрх мэдэлжүүлэх, чадавхжуулах
Соёл, түүх, болон жендэрийн асуудал	Үйлчлүүлэгч бүр адил биш тул тухайн үйлчлүүлэгчийн онцлог, эрх, хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээ үзүүлэх

Эх сурвалж: Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээ ба тогтолцоо, ХИС, 2023

Судалгаанд хамрагдсан 50 эмэгтэйдээс ТХБ-нд үйлчилгээ хэрхэн үзүүлсэн талаар асуухад хамгийн өндөр үнэлгээтэй үзүүлэлт нь "хамгаалах байранд өөрийгөө аюулгүй гэж мэдэрсэн" үзүүлэлт байсан бөгөөд нийт оролцогчдын 98% нь үүнтэй санал нийлсэн (дундаж оноо 3-аас 2.98). Харин хамгийн бага үнэлгээтэй нь "эргээд хэвийн амьдралдаа ороход хэрэгцээтэй урт хугацааны дэмжлэг авсан" үзүүлэлт байв (дундаж оноо 2.02). Энэ нь хохирогчдод үзүүлэх эрх мэдэлжүүлэх, чадавхжуулах дараагийн шатны

¹⁴ [Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллага /IDLO/-тай "Эрх зүйн салбар дахь хүүхэд хамгаалал" төслийг хамтран хэрэгжүүлнэ](#)

дэмжлэгүүд хэрэгцээтэй байгааг илтгэнэ. Энэ талаар дараагийн нөхөн сэргээх бүлэгт дэлгэрэнгүй танилцуулна.

НЦҮТ/ТХБ-ны ажилтнуудад даван туулагч төвтэй аргачлалыг таниулах, үйлчилгээний журмууд болон мэргэжлийн стандартуудыг сургах сургалтуудыг НҮБХАС болон бусад олон улсын байгууллагуудтай хамтран нилээдгүй зохион байгуулж ирсэн. Энэхүү сургалтууд цаг хугацааны үр дүнгээ өгч байгаа бөгөөд 2019 онд хийгдсэн судалгаагаар НЦҮТ/ТХБ-ны ажилтнуудын харилцаа, хандлагын түвшинг үйлчлүүлэгчид “дунд түвшинд” гэж үнэлж байсан бол 2023 онд энэ үзүүлэлт мэдэгдэхүйц сайжирч, үйлчлүүлэгчдийн 81.9% нь сайн үнэлгээ өгсөн байна (NSO, НЦҮТ/Түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгаа, 2023). Энэхүү судалгаанд хамрагдсан оролцогчдын хувьд ч гэсэн ажилтнуудын харилцаа, хандлага, мэргэжлийн байдалтай холбоотой санал бага дурдагдаж, үйлчилгээний ерөнхий сэтгэл ханамж 82% нь эерэг буюу сайн үнэлгээтэй байна. Уг эерэг үзүүлэлтийг цаашид хадгалахын тулд ажилтнуудын ажлын ачаалал, ажлын байрны стресс менежментийг сайжруулах, ажлын нөхцлийг дээшлүүлэх, үргэлжлүүлэн мэргэшүүлэх байдалд тасралтгүй хөрөнгө оруулалт хийх нь чухал юм.

Дүрс 12. Даван туулагч төвтэй арга зүйг үйлчилгээндээ баримталж буй байдал, n=50



ОУБ-аас НЦҮТ/ТХБ-ы ажилтнуудын мэргэжлийн байдал, даван туулагч төвтэй арга хандлагыг үйлчилгээндээ мөрдүүлж баримтлах чиглэлд сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг авч үзвэл:

- 2019 онд ШХА, НҮБХАС-аас хэрэгжүүлсэн “Монгол Улсад Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн 1-р шатны хүрээнд НЦҮТ-ийн ажилтнууд нийслэл Улаанбаатар хот руу үйлчилгээний байдалтай танилцах аяллыг зохион байгуулж, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн туршлагатай танилцуулж, үйлчилгээний туршлага хуваалцах ажлыг зохион байгуулсан. Уг аяллаар НЦҮТ-ийн ажилтнууд ХЭҮТ-ийн практик үйлчилгээ үзүүлж буй туршлагаас суралцаж, мөн хуульч, нийгмийн ажилтан, урлагийн сэтгэл засалчийн явуулсан олон талт үйлчилгээны арга барилуудтай танилцаж, үйлчилгээ үзүүлэх практик зөвлөмж авсан байна. (UNFPA, Achievement Book: Combating Gender-based Violence in Mongolia, Project Phase 1, 2020).
- 2021 онд ОУЭЗХБ-аас хэрэгжүүлсэн “Монгол Улсад ЖСХ-тэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийн хүрээнд ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой

“Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч-төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь” судалгааг гүйцэтгэж, гарын авлага боловсруулан шүүгч, прокурор, цагдаагийн алба хаагчдад ГБХ-тэй тэмцэхэд хохирогч-төвтэй хандлагыг хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулсан.

- 2023 онд **Азийн сан, ДЗМОУБ хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд хамгааллын түншлэл компакт”** төслийн хүрээнд ХХГХ-ийн хохирогчийг таньж, холбон зуучлах гарын авлагыг боловсруулсан. 2023 онд ХХГХ-ийн гэрч, хохирогч хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх арга зүйн сургалтыг мэргэжлийн 51 сэтгэл зүйчдэд, 2024 онд Форензик ярилцлагын¹⁵ арга зүйн сургалтыг Цагдаагийн байгууллага болон ХГБХХЕГ-ын харьяа байгууллагын 21 албан хаагчдад зохион байгуулсан байна (CPC, Төслийн тайлан мэдээ, , 2024).
- 2023 онд **Хүүхдийг Ивээх Сангийн “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь”** Хохирогчид ээлтэй, гэмтлийн дараах сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэх 11 модуль бүхий сургалтын гарын авлага, арга зүйг зөвлөх үйлчилгээний мэргэжлийн багуудтай хамтран боловсруулж, төслийн сонгогдсон дүүргийн хүүхэд хамгааллын салбарын нийт 1,289 мэргэжилтэн, алба хаагчдыг нийт 121 удаагийн сургалтад хамруулсан.
- 2022-2024 онд **АХБ-аас хэрэгжүүлсэн “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг ГБХ-тэй тэмцэх”** төслийн хүрээнд 2023 онд хамтарсан багийн 915 гишүүд, ГХУССЗ-ийн 148 албан хаагчдыг ГБХ-ээс урьдчилан сэргийлэх болон шинээр батлагдсан хамтарсан багийн удирдамжийн дагуу сургасан. Мөн төслийн зорилтот 5 байршил дахь ТХБ/НЦҮТ, шуурхай тусламжийн утасны ажилтнууд болон сэтгэл зүйчдээс 110 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө, анхан шатны хариу арга хэмжээний арга барил, хууль сахиулах ажиллагааны талаар хоёр өдрийн сургалтад зохион байгуулсан. 2023 оны 7-12-р сарын хооронд 771 хамтарсан багийн 4,581 гишүүнийг ГБХ-ээс урьдчилан сэргийлэлт болон үр дүнтэй хариу арга хэмжээний чиглэлээр сургаж бэлдсэн (ADB, Mongolia: Combating Domestic Violence Against: Completion Report, 2024).

Тулгамдаж буй асуудал: Сонсголын бэрхшээлтэй иргэд даван туулагч төвтэй үйлчилгээнд хамрагдах боломжгүй байна. Даван туулагч төвтэй арга хандлагыг хэрэгжүүлэхэд зайлшгүй онцлог, хэрэгцээг нь харгалзах шаардлагатай нийгмийн бүлэг бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд юм. ҮСХ-оос 2017 онд гүйцэтгэсэн “ЖСХ-ийн судалгааны дүнгээр Монгол гурван эмэгтэй тутмын нэг нь бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэсэн дүн гарч байсан бол уг нөхцөл байдал хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн дунд ойролцоогоор 2 дахин өндөр байна гэсэн судалгааны дүн байна. Гэвч цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн ГБХ-ийн хохирогчдын нэг хүрэхгүй хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байгаа нь эдгээр бүлгийн иргэд хууль хяналтын байгууллагад хандаж тусламж, дэмжлэг авч чадахгүй байгааг харуулдаг (ADB, 2020).

Хохирогч хамгааллын үйлчилгээг ХБИ-ийн онцлог хэрэгцээг нийцүүлж, хүртээмжтэй хүргэхийн тулд хамгаалах байрны стандарт, үйлчилгээний нийтлэг шаардлагад нарийвчилсан зохицуулалтууд зайлшгүй тусах шаардлагатай.

ГБХ-тэй тэмцэх хуулийн 33.7 дахь хэсэгт *бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчид үйлчилгээ үзүүлэхдээ орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангах* талаар зохицуулалтыг тусгасан боловч хуулийн энэ заалтыг хэн, хэрхэн, хангах талаар нарийвчлан зохицуулсан заалт холбогдох журмуудад тусаагүйн улмаас хуулийн хэрэгжилт хангалтгүй байсныг 2020 онд АХБ-аас гүйцэтгэсэн судалгааны дүгнэлтэд онцолж байжээ (ADB, 2020). Гэвч уг нөхцөл байдлаас хойш 5 жилийн дараа эрх зүйн орчинд ахиц дэвшил огт гараагүй байна. Өнөөдрийг хүртэл сонсголын бэрхшээлтэй хүн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хохирогч хамгааллын үйлчилгээнд болон хэрэг хянан шийдвэрлэх процесст хэлмэрчийн туслалцааг хаанаас хэрхэн авах, авсан тохиолдолд зардлын эх үүсвэрийг хаанаас гаргах нь тодорхойгүй байна.

¹⁵ **Форензик ярилцлага (Forensic Interview)** гэдэг нь хохирогч, ялангуяа хүүхэд болон эмээг бүлгийн хүмүүсээс гэмт хэрэг, хүчирхийлэл, мөлжлөгтэй холбоотой мэдүүлэг авахдаа шинжлэх ухааны үндэслэлтэй, сэтгэлзүйн болон хууль эрх зүйн зарчмуудыг баримтлан, шударга, нарийн аргачлалаар явуулдаг ярилцлагын аргачлал юм.

Өнгөрсөн 2024 онд Хууль зүйн туслалцааны төв¹⁶ 117 хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэ төлбөргүй хуулийн туслалцаа үзүүлсэн¹⁷ боловч, аль ч тохиолдолд дохионы хэлмэрчийн зардлыг хариуцаж гаргуулсан тохиолдол гараагүй байна.

Шигтгээ 10

Хэл ярианы бэрхшээлтэй нэг хохирогчтой ажиллаж байгаа. Тэр хохирогч 5 гэрчтэй. Гэтэл би гэрч, хохирогчоос хамтад нь мэдүүлэг авах гэж 5 удаа хэлмэрчтэй уулзах хэрэгтэй болдог. Нэг удаад хэлмэрчтэй ярилцлага хийхэд 3 цаг болсон. Хэлмэрчийн нэхэмжлэлийн төлбөр 350,000 төгрөг болсон. Тэр хэлмэрийн хувьд одоо болтол мөнгөө гаргуулж авья гээд байдаг. Хэрэг шийдэгдээгүйн гол учир нь хэлмэрчийн зардал гаргах эх үүсвэр байхгүй. ХНХЯ, цагдаагийн төсөвт суулгасан гэдэг боловч тэр нь бас л тодорхойгүй байдаг.

Өмгөөлөгчдийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

1.2.4 Эх оронд нь буцаан авчрах үйлчилгээ

Хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ) нь бусад төрлийн ЖСХ-ээс ялгаатай нь үндэстэн дамнасан байдлаар үйлдэгддэг онцлогтой. Иймээс ХХГХ-ийн хохирогчдод нэн тэргүүнд шаардлагатай хамгааллын үйлчилгээ нь тэднийг эх оронд нь буцаах ажиллагаа байдаг. Энэ нь өндөр зардал шаардахаас гадна төрийн болон ТББ-ын хамтын ажиллагаа зайлшгүй шаарддаг. Иймд хамгийн эхэнд хохирогчийг таньж тогтоох асуудал чухлаар тавигддаг.

Гадаад улсад ХХГХ-ийн хохирогч болсон Монгол иргэдийг эх оронд нь эргүүлэн авчрах үйл ажиллагааг Гадаад харилцааны сайдын баталсан журам (Гадаад харилцааны сайдын 2024 оны А/71 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан [Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам](#))¹⁸-ын хүрээнд зохион байгуулж байна. Энэ чиглэлд ИНБ-аас *Хүйсийн тэгш эрх төв* ТББ, олон улсын байгууллагуудаас *НҮБ-ын Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ)*, *Азийн сан* ОУБ төрийн байгууллагуудтай (ГХЯ, ГБХНХЯ, ГХУСАЗЗАА, Дипломат төлөөлөгчийн газрууд, ЭЦА гэх мэт) хамтран ажиллаж байна.

Өнгөрсөн онуудын байдлаар Монгол Улс 2022 онд Мьянмар Улсаас 12 монгол иргэнийг, 2023 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ), Лаос, Тайланд Улсаас 12 монгол иргэнийг эх оронд нь буцаан авчрах ажлыг зохион байгуулжээ¹⁸.

ХХГХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журмаар (2024) тухайн улс дахь Дипломат төлөөлөгчийн газар нь хохирогчдыг эх оронд нь буцаах ажиллагааг зохион байгуулж, шаардлагатай зардлыг эхний ээлжинд Дипломат төлөөлөгчийн газар өөрөөсөө гаргахаар зохицуулсан. Улмаар уг зардлыг Консулын газарт хүргүүлж холбогдох эх үүсвэрээс нөхөн олгохоор зохицуулснаар өмнө хохирогчийг эргүүлэн татахад тулгамддаг байсан гол асуудал болох санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдсэн байна.

ОУБ-аас энэ чиглэлд НҮБ-ын ОУШХБ нь 2007 оноос хойш хилийн чанадад ХХГХ-ийн хохирогч болсон иргэдийг эх оронд нь буцаах чиглэлээр санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлж, тогтвортой хамтран ажиллаж байна.

¹⁶ Хууль зүйн туслалцааны төв нь эрх зүйн туслалцаа авах боломж хязгаарлагдмал иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй байгууллага юм.


¹⁷ [Хууль зүйн туслалцааны төвийн 2024 оны өмгөөллийн үйлчилгээний тоон мэдээ](#)

¹⁸ [2024 Trafficking in Persons Report - U.S. Embassy in Mongolia](#)

3.3 Нөхөн сэргээх үйлчилгээ

Нөхөн сэргээх үйлчилгээ нь ямар нэг хэлбэрээр хүчирхийлэлд өртсөн хохирогчдын бие махбод, сэтгэл зүй, нийгмийн болон хөдөлмөр эрхлэх чадавх, бие даасан байдлыг аль болох бүрэн сэргээх, нийгэмд эргэн нэгтгэх, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэдэг. (UN, 2022). Монгол Улсад ЖСХ-ийн нөхөн сэргээх, эргэн нийгмийн амьдралд нэгтгэгдэхэд нь дэмжих үйлчилгээг хамтарсан багуудаар дамжуулан НЦҮТ болон бусад чиг үүргийн байгууллагуудтай хамтран үзүүлж байна. Хамтарсан баг, ТХБ, НЦҮТ-ийн нийгмийн ажилтан хамгийн анх нөхцөл байдлын үнэлгээг хийснээр тухайн хүнд шаардлагатай нөхөн сэргээх үйлчилгээнүүдийг төлөвлөж, холбогдох байгууллагууд уруу холбон зуучилдаг (Дүрс 13). Хуулийн дагуу ЖСХ-ийн хохирогчид голлон үзүүлж буй нөхөн сэргээх үйлчилгээ нь (1) эрүүл мэнд, (2) сэтгэл зүй, (3) хөдөлмөр, халамжийн үйлчилгээ гэсэн ерөнхий төрлүүдэд хуваагдаж байна (Хүснэгт 20).

Дүрс 13. ЖСХ-ийн хохирогчид үзүүлж буй хохирогч хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээний ерөнхий зураглал



Эх сурвалж: Судалгааны мэдээлэл

Хүснэгт 20. Нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх талуудын чиг үүрэг


	Талууд	Ерөнхий чиг үүрэг
1	Эмнэлэг/Эрүүл мэндийн ажилтнууд	Хохирогчид шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хадгалах, холбогдох нийгмийн ажилтан бусад талуудтай хамтарч ажиллах
2	Мэргэжлийн боловсролын байгууллагууд	Нийгмийн халамжийн ОНОТХ-ээр гэрээлсэн мэргэжлийн сургалтын байгууллагууд зорилтот бүлгийн иргэдэд мэргэжлийн боловсрол олгох сургалт зохион байгуулах
3	ТББ-ууд, гэр бүлийн төвүүд	Өөрсдийн дотоод дүрмийн дагуу сэтгэл зүй, эрх зүйн нөхөн сэргээх үйлчилгээнүүдийг үзүүлэх
4	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын байгууллага/Халамжийн нийгмийн ажилтан	Хохирогчийг асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ болон нийгмийн халамжийн тэтгэмжид хамруулах, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээг зохион байгуулах
5	Хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх төв	Бэлгийн хүчирхийлэл, ХХГХ-ийн хохирогч хүүхдүүдэд урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх
6	Нэг цэгийн үйлчилгээ төвүүд	Эрүүл мэндийн шуурхай тусламж, сэтгэл зүй, хууль зүйн нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх, дараагийн үйлчилгээнүүдэд холбон зуучлах

Хүснэгт 21. ЖСХ-ийн хохирогчид үзүүлж буй нөхөн сэргээх үйлчилгээний төрөл

	Хүүхэд	Насанд хүрэгч
Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч бол	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8-р зүйлд заасны дагуу хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд: 1.1 Хүүхдийг асрах зөвлөгөө 1.2 Сэтгэл зүйн зөвлөгөө 1.3 Зан авирын өөрчлөлтөд чиглэсэн нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө	ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 33-р зүйл: 1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ; 2. Сэтгэл зүйн үйлчилгээ (Зөвлөгөө, Засал); 3. Нийгмийн халамжийн үйлчилгээ; 4. Хүүхэд хамгааллын үйлчилгээ;
Бэлгийн хүчирхийллийн хохирогч бол	1.4 Хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон сургалтад хамруулах, холбон зуучлах 1.5 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ 1.6 Сургууль завсардсан хүүхдийг зохих боловсролын байгууллагад зуучлах 1.7 Хүүхэд эцэг эхийн харилцааг сайжруулах сургалтад хамруулах	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 6-р зүйл: Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх туслалцаа: 1. Сэтгэл зүйн туслалцаа 2. Эрүүл мэндийн туслалцаа 3. Нийгмийн бусад туслалцаа
Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч бол	1.8 Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд хуульд заасан шаардлагад нийцүүлэн хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх 1.9 Гэр бүлийн гишүүдийг ажилд зуучлах 1.10 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх 1.11 Согтууруулах ундааны хамааралтай асран хамгаалагчдыг үйлчилгээнд хамруулах 1.12 Хүчирхийллийн харилцаатай эцэг эхийг албадан болон сайн дурын сургалтад хамруулах 1.13 Хүүхэд үрчилж авсан эцэг эхэд хариуцлага хүлээлгэх 1.14 Гэр бүлээс тусдаа орчинд амьдарч байгаа хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ үзүүлэх 1.15 Бусад	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 12-р зүйл: 1. Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ; 2. Сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ; 3. Ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах;

Сүүлийн 5 жилийн хугацаанд хамгаалах байраар үйлчлүүлсэн 50 эмэгтэйдгээс авсан тоон судалгааны үр дүнгээр ТХБ-нд аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ авч байх хугацаандаа авсан нөхөн сэргээх үйлчилгээдийг Дүрс 14-д харуулав. Үйлчилгээнээс хамгийн нийтлэг авсан үйлчилгээ нь сэтгэл зүйн зөвлөгөө бол хамгийн бага авсан үйлчилгээ нь хөдөлмөр, халамжийн үйлчилгээ байна. Хамгаалах байраар үйлчлүүлж буй хохирогчдын 5 хүн тутмын нэг нь л халамжийн үйлчилгээ авчээ.

Дүрс 14. Судалгаанд хамрагдсан оролцогчдын авсан нөхөн сэргээх үйлчилгээ, давхардсан тоогоор (n=50)




Хамгаалах байранд авсан үйлчилгээтэй холбоотойгоор хохирогчийн бие махбодь, сэтгэл зүй, мэдрэмжинд гарсан эерэг өөрчлөлтүүдийг тодруулахад хамгийн гол эерэг өөрчлөлтүүд нь хохирогчийн аюулгүй байдал хангагдсанаар сэтгэл зүйн тогтворжиж сэтгэл санааны байдал дээрдсэн гэдэг хариулт голлож байна. Эсрэгээр хамгийн бага өөрчлөлт гарсан үзүүлэлт нь хөдөлмөр эрхлэх, хамгаалах байрнаас гарсны дараа бие даан амьдрах чадвар байна. Энэ нь авсан үйлчилгээтэй шууд холбоотой бөгөөд ТХБ-аас үйлчилгээ авсан иргэдийн хувьд хамгаалах байрнаас гарсны дараах урт хугацааны дэмжлэг, тэр дундаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн үйлчилгээ дутмаг байгаа нь харагдаж байна.

Дүрс 15. Үйлчилүүлэгчид гарсан өөрчлөлт: Үйлчилгээний өмнөх, дараах байдал, (n=50)



Доорх хэсэгт эдгээр үйлчилгээ тус бүртэй холбоотой эрх зүйн зохицуулалт, талуудын чиг үүрэг болон тулгамдаж буй асуудлуудыг танилцуулав:

Дүрс 16. Нөхөн сэргээх үйлчилгээний эрх зүйн орчин, түүний хэрэгжилтийг үнэлсэн байдал, 1-5 хүртэлх шкалаар үнэлүүлэв (1 маш муу, 5 маш сайн)



хүндрэл бэрхшээлтэй асуудлууд байгааг дор үйлчилгээ тус бүрээр танилцууллаа.


3.3.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

Эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээг ТХБ-ны дуудлагын дагуу харьяа эмнэлгийн ажилтан очиж үзүүлнэ, бусад тохиолдолд хамгаалах байрны ажилтнууд хохирогчийг харьяа эмнэлгийн байгууллагад хүргэж, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулдаг. Эдгээр үйлчилгээг хэрхэн үзүүлэхийг ЭМ-ийн сайдын 2014 оны ЭМ, ХЗ-н сайдын А/356, А/182 ["Гэрч, хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"](#)-аар зохицуулж байна. Уг журамд зааснаар ЖСХ-ийн хохирогчид улсын төсвөөс санхүүжих, эрүүл мэндийн даатгалаас санхүүжих заалттай үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг. Бусад үйлчилгээний зардлыг Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас гаргуулж, буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр заажээ.

Хамгаалах байрны албан хаагчдын мэдээлснээр ТХБ-нд ирж буй хохирогчид нь бие махбодын ил бэртэл гэмтлээс гадна бэлгийн замын халдварт өвчин, ханиад томуу болон нойргүйдэх, ходоод хямрах, зэрэг архаг хууч өвчтэй байх нь нийтлэг байдаг. Түүнчлэн, ихэнхдээ ГБХ-д өртсөн эмэгтэйчүүд хүүхдүүдийнхээ хамтаар хамгаалах байранд ирдэг тул өвлийн улиралд хүүхдийн ханиад томуу болон бусад халдварт өвчнөөс үүдэлтэй эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрэлт хэрэгцээ өндөр байдаг байна.

ЖСХ-ийн хохирогч нарт үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээний хувьд анхан шатны эмнэлгүүд ихэвчлэн дараагийн лавлагаа шатлалын эмнэлгүүд рүү холбон зуучлах үйлчилгээг хамгийн түгээмэл үзүүлж, 2,3-р шатлалын эмнэлгүүд гэмтлийн тусламж, сэтгэл зүйн зөвлөгөө, нөхөн сэргээх эмчилгээг хамгийн түгээмэл үзүүлж байна (Дүрс 17).

Дүрс 17. ЖСХ-ийн хохирогчдод эрүүл мэндийн тусламж үзүүлсэн байдал, эмнэлгийн шатлалаар (n=104)



Эх сурвалж: [ЖСХ-ийн эсрэг ЭМ-ийн салбарын хариу арга хэмжээний бэлэн байдал судалгааны хүрээнд үйлчилгээ үзүүлсэн 104 эрүүл мэндийн ажилтнуудаас авсан анхдагч судалгааны мэдээлэл](#)

Судалгаанд хамрагдсан 50 эмэгтэйн 38% нь эмнэлгийн үзлэг, оношилгоонд хамрагдах, шинжилгээ өгөх, шүүх шинжилгээний байгууллагад хандах, хүүхдээ үзүүлэх, эм тариа авах зэрэг ямар нэг хэлбэрээр эрүүл мэндийн үйлчилгээг ТХБ-нд байрлаж байх хугацаандаа авсан байсан. Тэдний туршлага болон бусад үйлчилгээ үзүүлэгчдийн мэдээллээс үзэхэд дараах асуудлууд эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотойгоор хөндөгдөж байна:

- **ТХБ болон НЦҮТ дэх орон тооны эмчийн асуудал:** ХГБХХЕГ-ын дэргэдэх НЦҮТ болон зарим ТХБ-ууд нь харьяа өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй гэрээлэх хэлбэрээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хохирогчдод үзүүлдэг. Гэвч тогтмол ажиллагаатай, бүтэн цагийн эмч, мэргэжилтэнгүй байх нь хэрэгцээ гарсан үед шуурхай үйлчилгээ авах боломжийг хязгаарладаг. Үүний улмаас ӨЭМТ рүү зорчих эсвэл эмчийг хүлээх шаардлага гардаг нь үйлчилгээний хүртээмжийг бууруулахад нөлөөлдөг байна.
- **Хохирогчийн мэдээллийн нууцлалыг хадгалах, үзлэгийн аюулгүй орон зайг бүрдүүлэх асуудал:** ЖСХ-ийн хохирогчид харьяа орон нутгийн эмнэлгийн байгууллагад очиж үйлчилгээ авахад нийтлэг тулгамддаг, санаа зовоосон асуудал нь бусад үйлчлүүлэгчдийн адил энгийн хүлээлгийн хэсэг, хүлээн авах өрөөнд эсвэл амбулаторит үзүүлдэг нь хохирогчдын хувийн, нууцлал хангасан түвшинд үйлчилгээ авах боломжийг хязгаарлаж байдаг. Энэ чиглэлээр ЭМ-ийн байгууллагад мөрдөж буй ямар нэг үйлчилгээний стандарт одоогоор байхгүй, ЖСХ-ийн хохирогчтой хэрхэн харилцаж, үйлчлэх талаар нэгдсэн заавар чиглүүлэг, сургалт дутмаг байдгаас санаатай болон санаандгүй үйлдлээр хохирогчийн талаарх мэдээлэл задрах эрсдэлтэй байна. Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж үзүүлэгчдийн ЖСХ-ийн мэдлэгийн түвшинг хэмжсэн судалгаагаар 52.3% хангалтгүй гэж дүгнэгдсэн бөгөөд, ялангуяа хөдөө орон нутгийн эмнэлгийн ажилтнуудын мэдлэг, ойлголт сул байна (UNFPA, 2023).

Шигтгээ 11

Түр хамгаалах байранд өвчтэй хүмүүс их ирнэ. Түр хамгаалах байран дээр маань яг мэргэжлийн эмч байхгүй учраас эрүүл мэндийн үйлчилгээ авах гэхээр тэдгээр хүүхдүүд, томчуудыг зөөх, аюулгүй байдлыг нь хангаад явах хүн хэрэгтэй болдог. Нийгмийн ажилтан нэг хүүхдээ үзүүлэх гээд бусад хүүхдээ орхиод явах хэцүү. Хатгаатай хүүхэд орж ирлээ гэж бодвол эмнэлэг дээр нь очоод үзүүлээд цээжний зураг авхуулж эм тариаг нь бичүүлнэ гээд ажиллагаа ихтэй. Тэгэхлээр нөхөн сэргээх үйлчилгээнээс яг эрүүл мэнд үйлчилгээг чанартай хүртээмжтэй үзүүлэхэд эмчийн хүрэлцээнээс үүдэлтэй дутагдалтай талууд гарч байгаа.

ТХБ-ны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Эмчийн орон тоо томоохон асуудлуудын нэг байдаг. Жишээлбэл, манай хамгаалах байрны хувьд өрхийн эмнэлэгтэй гэрээ байгуулж, хүүхдийн эрүүл мэндийн хяналтыг тогтмол хийлгэдэг. Эрүүл мэндийн асуудал гарсан тохиолдолд өрхийн эмч нар ээлжээр ирж, үзлэг хийж, шаардлагатай арга хэмжээг авдаг. Гэвч хамгаалах байрнуудын байршил ихэвчлэн алслагдмал, нууцлал өндөртэй байдаг тул тогтмол эмнэлгийн байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллаж чадаж байгаа гэж хэлэхэд хэцүү..

ТХБ-ны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Эмч, сувилагч, эмч, цэвэрлэгч, үйлчлэгч гэдэг ч юм уу хоорондоо хохирогчийн талаар ярьсан мэдээлэл нь санаатай болон санаандгүйгээр тарах эрсдэлтэй. Ямар түвшний мэдээллийг эмзэг мэдээлэл гэж үзэх юм гээд эмнэлгийн ажилтнуудад заавар, чиглүүлэг нь тодорхой байх ёстой. Цагдаагийн ажилтнууд тодорхой үеүдэд хэлж сануулдаг ч бүх хүнд хүрч, мэдээлэлтэй байлгах боломжгүй тул эрүүл мэндийн байгууллага өөрөө үүнд бэлтгэлтэй, ойлголттой байх ёстой юм.

Цагдаагийн алба хаагчтай хийсэн ярилцлагаас

3.3.2 Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ

Хүчирхийллийн хохирогчийг нөхөн сэргээхэд хамгийн чухал, урт хугацаанд шаардлагатай үйлчилгээ болох сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ нь (1) сэтгэл зүйн зөвлөгөө, (2) сэтгэл заслын үйлчилгээ гэсэн 2 төрлөөр хохирогчид хүрдэг. Сэтгэл зүйн зөвлөгөөг ХНХ-ын 2017 оны А/74 тоот [Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх журам](#)-ын дагуу тус ХГБХХЕГ-ын сэтгэл зүйчид, харин сэтгэл заслын үйлчилгээг ЭМЯ-ны 2017 оны А/394 тоот [Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам](#)-ын дагуу мэргэжлийн сэтгэцийн эмч нар үзүүлж байна.

Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдээс ТХБ-нд байрлаж байх хугацаандаа хамгийн нийтлэг авсан үйлчилгээ сэтгэл зүйн зөвлөгөө байсан. Нийт хохирогчдын талаас илүү хувь (58%) сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг авсан байна. Гэхдээ эндээс хүчирхийлэлд өртсөн бүх үйлчлүүлэгч сэтгэл зүйн зөвлөгөө авдаггүй болохыг харж болно. Энэ нь тухайн үйлчлүүлэгчийн байрласан хугацаа, сэтгэл зүйчдийн ажлын ачааллаас хамаардаг байж болно.

Кейс ярилцлагуудаас харахад сэтгэл зүйн үйлчилгээ нь үр дүн сайтай ч, давтамж хангалтгүй байгаа нь анзаарагдсан. Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцсон 10 даван туулагчийн ихэнх нь долоо хоногт 1-2 удаа сэтгэл зүйчтэй уулздаг байсан талаар дурдсан байна. Давтамж бага байсан ч оролцогчид сэтгэл зүйн дэмжлэг авсандаа сэтгэл хангалуун байсан бөгөөд сэтгэл зүй нь тогтворжиход эерэг нөлөөтэй байсныг онцолж байсан.

Цаашид ТХБ-нд үзүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулахад дараах хүндрэлүүд тулгарч байгааг үйлчилгээ үзүүлэгч талууд онцолж байна:

- **Мэргэшсэн сэтгэл зүйчдийн хүрэлцээ.** Ялангуяа орон нутагт мэргэжлийн сэтгэл зүйч, мэргэшсэн сэтгэцийн эмчийн нөөц дутагдалтай байгаа нь хүчирхийллийн хохирогчид үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд шууд нөлөөлж байна. Тухайлбал, Хэнтий аймгийн хэмжээнд гэхэд 2 сэтгэл зүйч ажиллаж байна.
- **Ажлын ачаалал, хүний нөөцийн дутагдал.** Ихэнх ТХБ, НЦҮТ-д сэтгэл зүйчийн нэг л орон тоотой ажиллаж байна. Энэ нь 24 цагийн үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй болж, амралтын өдрүүдэд болон сумд, орон нутагт ажиллах үед үйлчилгээ тасалдах эрсдэл үүсгэдэг.
- **Мэргэжилтнүүдийн тасралтгүй чадавхжуулалт:** Сургалт чадавхжуулах ажлууд ОУБ, ХГХХГ-аас багагүй явуулж ирсэн. Тухайлбал, НҮБХАС-ийн “Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд НЦҮТ-ийн ажилтнуудад, тэр дундаа сэтгэл зүйчдэд зориулсан сургалтуудыг зохион байгуулсан. Мөн Хүүхдийн эрхийн үндэсний төвийн “Охидыг мөлжлөг, хүчирхийллээс хамгаалах нь” төслийн хүрээнд сэтгэцийн гэмтэлд суурилсан, даван туулагч төвтэй арга зүйн хүрээнд сургалт явуулсан. Түүнчлэн, 2023 онд АХБ-ийн “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг ГБХ-тэй тэмцэх” төслийн хүрээнд тус төслийн зорилтот орон нутгуудад байрлах ТХБ-ууд, НЦҮТ-үүд-ийн сэтгэл зүйч нарт хоёр өдрийн хөтөлбөртэй “ГБХ-ийн хохирогчдод сэтгэл зүйн зөвлөгөө,

үйлчилгээ үзүүлэх нь” сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан. Мөн уг төслийн хүрээнд анхан шатанд ажиллаж буй мэргэжилтнүүдийн сэтгэл зүйн эрүүл мэнд, ажлын байрны стрессийг бууруулахад чиглэсэн сургалтуудыг зохион байгуулж байжээ.

Хэдий мэргэжилтнүүдийг чадавхжуулах ажлууд ОУБ-ын дэмжлэгтэйгээр багагүй зохион байгуулагдаж байгаа ч төрийн албан хаагчдын тогтвор суурьшил, хүчирхийллийн хохирогч нартай ажиллаж буй алба хаагчдын ажлаас халсрах байдлаас үүдэн хүний нөөцийн тогтвортой байдал сул хэвээр байна. Иймд хүний нөөцийг сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх шаардлагатай. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, бэлгийн цөөнх болон бэлгийн хүчирхийлэл, ХХГХ-д өртсөн зэрэг гэмт хэргийн төрлөөс хамаарсан хохирогчийн онцлогийг таниулах, арга зүйд сургах сургалтууд тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

Шигтгээ 12

Миний хувьд ярилцах хэрэгцээ шаардлага их байсан. Сэтгэл зүйчтэйгээ ойр байж өмнө сонсож байгаагүй урам зоригийг авч, өөрийгөө буруутгах шаардлагагүй, өөрийнхөө төлөө зоригтой дугарч чадсан нь өөрийгөө болоод эргэн тойрныхоо хүмүүсийг мөн хамгаалж байгаа зэргээр итгэл, урам өгдөг байсанд нь маш их баярладаг.

ЖСХ-ийн хохирогчтой хийсэн кейс ярилцлагаас

Одоогоор хамгаалах байранд ганцхан сэтгэл зүйч ажилладаг тул хүрэлцээ тун хэцүүхэн байна. Нэмэлт сэтгэл зүйч ажиллавал хохирогчдод үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээ илүү хүртээмжтэй байхад дэмтэй. Одоогийн ажилтнууд ээлжийн ажил хийж, дараагийн өдөр нь шууд үндсэн ажлаа үргэлжлүүлэх шаардлагатай байгаа нь тогтвортой, тууштай ажиллахад ихээр сөргөөр нөлөөлдөг.

Хэнтий аймгийн НЦҮТ-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Хүчирхийлэлд өртөөд ирсэн хүмүүс маш их айдастай, түгшилттэй байдаг. Өөртөө болоод бусдад үр хүүхэддээ маш их санаа зовсон хүмүүс ирдэг. Тэгэхлээр зөвхөн сэтгэл зүйн зөвлөгөөнөөс гадна сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх чадвартай хүний нөөц орон нутгийн түвшинд маш хэрэгтэй. Зүгээр эмч ирээд суух, сэтгэцийн эмч ирээд суух, сэтгэл зүйч ирээд суух сэтгэл засалч ирээд суух ялгаатай, шал өөр. Би өөрөө сэтгэцийн эмгэг судалдаг судлаач эмч учраас давуу талтай байгаа ч намайг тэтгэвэртээ гарсны дараа мэргэжлийн хүн зайлшгүй шаардлагатай.

Дархан аймгийн ТХБ-ны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

3.3.3 Нийгмийн халамжийн үйлчилгээ

Эдийн засгийн хувьд хараат, боловсролын түвшин бага, ажил эрхэлдэггүй, олон хүүхэдтэй байх зэрэг хүчин зүйлсээс үүдэн ЖСХ-ийн хохирогчид эрх мэдлийн тэнцвэргүй байдалд орж, хүчирхийлэгчээс холдох боломж нь хязгаарлагдаж байдаг. Даван туулагчдыг урт хугацаанд нөхөн сэргээх, бие даасан амьдралд хөтлөх хамгийн чухал үйлчилгээний нэг нь хөдөлмөрийн дадал олгох, орлогын эх үүсвэртэй болоход чиглэсэн дэмжлэг юм. Монгол Улсад энэ төрлийн дэмжлэг нь Нийгмийн халамжийн үйлчилгээний нэг хэсэгт хамаардаг.

Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу хүчирхийлэлд өртсөн иргэнд Хүснэгт 22-д харуулсан үйлчилгээдээс [Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ \(ОНОТХҮ\)-г](#) үзүүлэхээр заасан.

Хүснэгт 22. Нийгмийн халамжийн тухай хуульд заасан Монгол Улсад үйлчилж буй халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнүүд

Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу			
Нийгмийн халамжийн тэтгэвэр	Нийгмийн халамжийн тэтгэмж	Нийгмийн халамжийн үйлчилгээ	Нийгмийн хөгжлийн үйлчилгээ
- Өндөр настан бол - Одой иргэн бол - Хөгжлийн бэрхшээлтэй бол - Тэжээгчээ алдсан хүүхэд бол	- Асаргааны тэтгэмж - Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн бол	- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ - Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	- Боловсролыг дэмжих үйлчилгээ - Эрүүл мэндийн дэмжих үйлчилгээ

18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх	- Онцгой тохиолдлын тэтгэмж - Хүүхдийн мөнгөн тэтгэмж		Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ
--	--	--	--

ОНОТХУ-г 2023 онд нийт 11,297 иргэнд үзүүлсний 68% нь эмэгтэйчүүд. Нийт үйлчилгээ авсан иргэдийн дийлэнх нь ХБИ байх ба сэргээн засах үйлчилгээ хамгийн олон хүнд хүрчээ.

Дүрс 18. 2023 онд Улсын хэмжээнд ОНОТХУ-г үзүүлсэн нийт хүний тоо



Эх сурвалж: ГБХНХЯ-ны 2023 оны мэдээлэл

Эдгээр ОНОТХУ-ээс Хүснэгт 23-д харуулсан 5 төрлийн үйлчилгээг хүчирхийлэлд өртсөн иргэнд үзүүлэхээр журамласан. Гэвч эдгээр үйлчилгээг авсан нийт иргэдийн дунд хэд нь хүчирхийллийн хохирогч байсан талаар задаргаатай мэдээллийг гаргах боломжгүй байна.

Хүснэгт 23. ЖСХ-ийн хохирогчдод үзүүлэх нийгмийн халамжийн ОНОТХ-ийн үйлчилгээний жагсаалт

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнүүд
18.1.1.амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах; 18.1.4.түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах; 18.1.7.иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх; 18.1.8.гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах; 18.1.9.нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.

Эх сурвалж: Олон нийтийн оролцоонд түшиглэсэн дараах халамжийн үйлчилгээ (ОНОТХУ)

ТХБ, НЦҮТ-өөс 2024 онд үйлчилгээ авсан нийт 1809 насанд хүрэгчдийн бүртгэлээс үзвэл, 17% нь хөдөлмөр, халамжийн тэтгэмж, үйлчилгээнд холбон зуучлуулсан байх ба эдгээр 319 хүний 16% (n=289) нь халамжийн үйлчилгээнд, 1.6% (n=30) нь хөдөлмөр эрхлэлтэд холбон зуучлуулсан байна.

Халамжийн үйлчилгээ авсан иргэдийн дийлэнх нь асаргааны, хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүнсний эрхийн бичиг зэрэг үйлчилгээнд зуучлагдсан байх ба 18.1.1 (бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих сургалт), 18.1.9 (орлогын эх үүсвэртэй болох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах) зэрэг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнүүдэд холбон зуучлагдсан хүчирхийлэлд өртсөн хүн өнгөрсөн онд улсын хэмжээнд 30 кейс байгаа нь маш бага үзүүлэлт юм.

Тус судалгаанд хамрагдсан 50 эмэгтэйчүүдийн хувьд мөн ижил, 20% нь л нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан ба дийлэнх нь халамжийн тэтгэмжинд хамрагдсан байна. Эндээс үзвэл, ойролцоогоор ТХБ, НЦҮТ-өөр үйлчлүүлж буй ЖСХ-ийн 5 хохирогч тутмын 1 нь л хөдөлмөр, халамжийн үйлчилгээг авч байна.

Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр олон хөтөлбөр хэрэгжиж, жилд ойролцоогоор 2-3 тэрбум төгрөгийн төсөв зарцуулдаг (UNDP, 2023) хэдий ч тэдгээрийн хүртээмж ЖСХ-ийн хохирогчдод хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл, төрөөс ЖСХ-ийн хохирогчдыг эдийн засгийн хувьд бие даан амьдрахад чиглэсэн дэмжлэг сул байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд багтсан эдгээр сургалт, хөгжлийн үйл ажиллагааг ТХБ-нд зохион байгуулах, эс бөгөөс хамгаалах байранд байрлаж буй иргэдийг нийгмийн халамжийн сургалтуудад хамруулах чигийн зохион байгуулалтыг зайлшгүй хийх хэрэгцээтэй. Судалгааны явцад хохирогч эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагуудаас хамгийн их давтагдсан нийтлэг асуудал байсан нь **хамгаалах байранд байх хугацаандаа ямар нэгэн сургалт, чадавхжуулах үйл ажиллагаанд хамрагдах боломж хязгаарлагдмал явдал** байлаа. Тэдний дийлэнх нь хамгаалах байранд орсон даруйдаа гар утсаа хураалгаж, гадуур чөлөөтэй зорчих эрхгүй болдгоос, ялангуяа 2 ба түүнээс дээш хоног байрлаж буй үйлчлүүлэгчдийн хувьд ерөнхийдөө өдөр хоногийг “хийцгүй өнгөрөөх” нөхцөл байдалд байдгаа хуваалцсан. Хүчирхийллээс ангижирч, аюулгүй орчинд байх нь өөрөө маш том дэвшил боловч энэ хугацаанд ямар нэгэн ур чадвар эзэмших, ирээдүйд бие даасан байдлыг нь дэмжихэд чиглэсэн ямар нэг сургалт, хөгжлийн үйл ажиллагаа байвал даван туулагчдын сэтгэл зүйд ч, эдийн засгийн боломжинд ч эерэгээр нөлөөлөх боломжтой гэдгийг ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд дэвшүүлж байна.

Шигтгээ 13

...Хамгаалах байранд байрлаж байгаа хүмүүст сургалт, хөгжлийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх хэрэгтэй санагддаг. Тэр болгон нь өөрөө хөдөлмөрт суурилсан засал болж чадна. Тэндээс гарахдаа гар урлал, оёдол ч юм уу нэг ур чадвар шинээр сураад гарвал бас хэчнээн хамгаалуулж байгаагаас гадна, тэнд хоригдож байгаа юм шиг мэдрэмж авахгүй байх. Тийм зүйл байхгүй болохоор утсаа хураалгачихсан хүн чинь элдвийн зүйл бодогдоод зарим хүнд бол өдөр өнгөрч өгөхгүй маш хэцүү санагдана.

...Урт хугацааны дэмжлэг, хамгаалах байрнаас гарсны дараа яах вэ гэдэг дээр дэмжлэг байвал илүү хэрэгтэй байна. Мөн энд байх хугацаандаа ажилтай болоод гарвал илүү хэрэгтэй байна.

ТХБ-аар үйлчлүүлсэн даван туулагчдын ярианаас

ЖСХ-ийн хохирогчдыг эдийн засгийн хувьд чадавхжуулах чиглэлээр ОУБ-аас дэмжлэг үзүүлэх оролдлогууд хязгаарлагдмал байсан ч цөөн сайн туршлагууд байсан. Тухайлбал:

- 2023-2027 оны хооронд ЖАЙКА-аас Зорилтот бүлгийн иргэдийг хөдөлмөр эрхлэх боломжтой болгох замаар бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх төслийг хэрэгжүүлж байна. Уг төсөл Улаанбаатар хотын Сүхбаатар, Баянзүрх дүүрэг болон Дундговь аймгийг хамарч, хөдөлмөр эрхлэлтийн сургалтууд зохион байгуулан, дадлагажуулж, ажлын байранд зуучлах замаар оролцогчдын өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилготой. Хэдийгээр энэхүү төсөл ЖСХ-ийн хохирогчдыг тусад нь онцгойлон авч үзсэн эсэх нь тодорхойгүй байгаа ч зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн чиглэсэн томоохон туршилтын төсөл байна.
- 2022-2024 онд АХБ-аас хэрэгжүүлсэн “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг ГБХ-тэй тэмцэх” төслийг хэрэгжүүлсэн. Энэ төслийн хүрээнд зорилтот таван байршил¹⁹ ЖСХ-д өртсөн 115 эмэгтэйг бизнес санал боловсруулах, санхүүгийн болон эрх зүйн мэдлэг олгох сургалтад хамруулсан бөгөөд тэднээс 50 эмэгтэйн жижиг бизнесийн төслийг санхүүжүүлэн дэмжсэн байна. Энэ нь зөвхөн санхүүгийн дэмжлэг төдийгүй, хохирогчдыг өөрсдийн амьдралаа бие даан авч явах итгэл, чадвартай болгоход чухал түлхэц өгсөн сайн туршлага болжээ.

¹⁹ Увс, Сэлэнгэ, Сүхбаатар аймгууд, Улаанбаатар хотын СХД, Налайх дүүргүүд

Шигтгээ 14

АХБ-ны ЖСХ-ийн хохирогчдын амьжиргаа дээшлүүлэх хөтөлбөр маш үр дүнтэй хэрэгжсэн. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ эхлээд ЖСХ-ийн хохирогчдод стресс менежмент, хүчирхийлэлтэй холбоотой сөрөг туршлагаа даван туулах сэтгэл зүйн, хувь хүний хөгжлийн сургалтуудыг зохион байгуулсан нь ихээхэн үр дүнтэй байсан.

Уг хөтөлбөрөөс нэг ажиглагдсан онцлог зүйл нь бүгд хүчирхийлэл үйлдэгч нөхрөөсөө салаагүй, тэгэхээр Монголын соёлд сална гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй юм байна. Дийлэнх нь харилцаагаа хадгалж үлдэхийг хүсдэг юм байна лээ. Гэхдээ амьжиргаа дэмжих хөтөлбөрөөр өөрсдийнх нь эдийн засгийн орлого нэмэгдэж, тэр хэрээр манай нөхрийн хүчирхийлэл үйлдэх нөхцөл нь багассан гэж эмэгтэйчүүд өөрсдөө хэлсэн. Эдийн засаг дээшилсэн тохиолдолд хүчирхийлэл буурдаг. Нэг ёсондоо эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг нь эдийн засгийн талаас нь багасгаж байгаа хэрэг юм.

АХБ-ны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Эдгээр жишээнүүдээс харахад ЖСХ-ийн хохирогчдыг эдийн засгийн хувьд бие даасан, тогтвортой орлоготой иргэн болгоход чиглэсэн ажлууд цөөн ч гэсэн тодорхой үр дүнтэй туршлагууд байна. Цаашид энэ төрлийн урт хугацааны дэмжлэгийг нэмэгдүүлж, ЖСХ-ийн хохирогчдод илүү хүртээмжтэй, үр дүнтэй байдлаар хүргэх шаардлагатай нь харагдаж байна.

3.4 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

ЖСХ-ийн эсрэг хариу арга хэмжээний нэн чухал бүрэлдэхүүн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа буюу хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх явдал юм. Энэ нь зөвхөн хохирогчдод ач холбогдолтойгоос гадна, ЖСХ нь ноцтой үр дагавартай, хүлцэн тэвчих ёсгүй зүйл гэсэн ойлголтыг нийгэмд бий болгодог. Хууль ёсны арга хэмжээ, ял шийтгэл нь үр дүнтэй, зохистой байснаар хууль дээдлэх ёсыг бататгаж, хохирогчдын эрх, эрхэм чанарыг хамгаалж, тэднийг нөхөн сэргэхэд дэмжлэг үзүүлнэ.

Мөн хариуцлага хүлээлгэх ажиллагаа үр дүнтэй, хууль ёсны арга хэмжээнүүд уялдаа холбоотой, тогтвортой байж, зохистой шийтгэл хүлээлгэснээр ирээдүйд хүчирхийлэл үйлдэж болзошгүй иргэдэд тодорхой анхааруулга, сануулга болж, хүчирхийлэл үйлдэх эрсдэлийг бууруулдаг. Цаашилбал, хүчирхийллийг үл тэвчих, жендэрийн тэгш байдлыг дэмжих нийгмийн хэм хэмжээг бэхжүүлж, олон нийтийн мэдлэг ойлголтыг өөрчлөх боломжтой юм.

Хүчирхийллийн тойргийг таслан зогсооход хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гол үүрэгтэй. Шударга ёсны системээр дамжуулан хүчирхийлэл үйлдэгчдийг нөхөн сэргээх болон соён гэгээрүүлэх сургалтуудад албадан хамруулж, тэдний сөрөг зан байдал, хандлагыг өөрчлөх боломжтой. Энэ төрлийн арга хэмжээнүүд нь хүчирхийлэл дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж, хүчирхийлэл үйлдэгчдэд зан байдлаа өөрчлөх боломжийг олгож, урт хугацаандаа орон нутгийн аюулгүй байдалд хувь нэмэр оруулдаг.

Тиймээс тайлангийн энэхүү хэсэг Монгол улс дахь ЖСХ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудыг онцолж, хууль эрх зүйн орчин, институцийн чадавх, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх үйл явцыг хэлэлцэнэ.

Одоогийн хууль, эрх зүйн орчин

Монгол Улсад Эрүүгийн хууль (2015) болон Зөрчлийн тухай хууль (2017)-аар ЖСХ үйлдэгчид хариуцлага хүлээлгэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг (The National Legal Institute of Mongolia, 2021). Хэдийгээр тус хуулиудад ЖСХ гэж тусгайлан заагаагүй байдаг ч ЖСХ-ийн тодорхой хэлбэрүүд болох гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, ХХГХ-ийг тодорхой эрүүгийн гэмт хэрэг, зөрчил болгон тусгасан байна.

Хүснэгт 24. ЖСХ-тэй холбоотой гэмт хэрэг, зөрчлүүд

ЖСХ-ийн төрлүүд	Хүчирхийллийн төрлүүд	Эрүүгийн хууль	Зөрчлийн тухай хууль
Гэр бүлийн хүчирхийлэл	Бэлгийн, Бие махбодын, Эдийн засгийн, Сэтгэл санааны	11.7 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	5.4 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих
		10.1.2 Гэр бүлийн хүчирхийлэл үлдэж хүнийг алах	
		11.1 Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	
		11.4 Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	
		11.6 Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах	
Бэлгийн хүчирхийлэл	Бэлгийн, Бие махбодын, Сэтгэл санааны	12.1 Хүчиндэх	6.26 Бэлгийн дарамт учруулах
		12.2 Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	
		12.3 Бэлгийн мөлжлөг	
		16.8 Хүүхэд садар самууныг сурталчлах, уруу татах	
		16.9 Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах	
Хүн худалдаалах	Бэлгийн, Бие махбодын, Эдийн засгийн, Сэтгэл санааны	13.1 Хүн худалдаалах	-

Албан хаагчид дээр дурдсан эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)-ийг мөрдөн ажилладаг бол зөрчлийг бүртгэх, хянах, шийдвэрлэх

ажиллагаа явуулахдаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017)-ийг баримтлана. Тухайн хуулиудад гэмт хэрэг болон зөрчлийг хянан шийдвэрлэх бүхий л үйл явц болон хэрэгжүүлэгч, оролцогч талуудын эрх, үүргийг нарийн тусгасан байдаг.

Институцийн бүтэц, чадавх

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар ЖСХ-тэй холбоотой зөрчлийг цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, эрүүгийн хэргийн шүүх шалган шийдвэрлэдэг байна. Эдгээр талуудын үүргийг дараах тус хуульд дараах байдлаар тусгажээ.

Хүснэгт 25. ЖСХ-тэй холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэх талуудын үүрэг

№	Талууд	Зөрчил шалган шийдвэрлэх үүрэг
1	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан дараах зөрчлийг шалган шийдвэрлэнэ: 5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 1.Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй; 2.Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн; 3.Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан;
2	Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан дараах зөрчлийг шалган шийдвэрлэнэ: 6.26 дугаар зүйл. Бэлгийн дарамт учруулах 2.Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах үүргээ биелүүлээгүй
3	Эрүүгийн хэргийн шүүх	Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 6.26 дугаар зүйлд заасан дараах зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулна: 5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 4.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг: 4.1.зодсон; 4.2.хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; 4.3.бусадтай харилцахыг хязгаарласан; 4.4.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан 6.26 дугаар зүйл. Бэлгийн дарамт учруулах 1.Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн 2.Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах үүргээ биелүүлээгүй

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар дараах гол талууд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж, оролцох ба талуудын үүргийг дараах байдлаар заасан байна.

Хүснэгт 26. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогч голлох талуудын үүрэг

№	Талууд	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үүрэг
1	Мөрдөгч	Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуульд заасан эрх, үүргийн дагуу, эсхүл прокурорын даалгавраар энэ хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулна
2	Өмгөөлөгч	Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах

№	Талууд	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үүрэг
		эрхээр хангах зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулна.
3	Прокурор	Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцоно.
4	Шүүх	Анхан шатны шүүх хуралдаанаар тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэх, гэм буруутай бол түүнд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хянан шийдвэрлэнэ. Давж заалдах шатны шүүх хуралдаанаар анхан шатны шүүхийн ажиллагаа, шийдвэртэй холбогдуулан гаргасан талуудын гомдол, эсэргүүцэл үндэслэлтэй эсэхийг хянан шийдвэрлэнэ. Хяналтын шатны шүүх хуралдаанаар гомдол, эсэргүүцлийн дагуу шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэнэ.

Гэмт хэрэг болон зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч эдгээр талуудын чадавх нь ЖСХ-д зүй зохистой, даван туулагч төвтэй, үр дүнтэй байдлаар арга хэмжээ авахад нэн чухал. Хохирсон иргэн хамгаалуулж, гэмт этгээдэд хариуцлага хүлээлгэн, шударга ёсыг бэхжүүлж, ЖСХ-ийн хэргийг үр дүнтэй шийдвэрлэхэд талууд шаардлагатай ур чадвар, мэдлэг ойлголтыг эзэмшсэн байх ёстой. Харин чадавх дутмаг бол процедурын алдаанаас шалтгаалан мөрдөн шалгах, нотлох баримт цуглуулах ажиллагаануудад доголдол үүсэж, хэргийг хэрэгсэхгүй болгох эрсдэлтэй. Тиймээс хуулийг үнэн зөв хэрэгжүүлэх, ЖСХ-ийн нарийн төвөгтэй байдлыг ойлгох, хохирогчдод сэтгэл зүйн хохирол дахин учруулахгүй байхын тулд талуудыг сургах, чадавхжуулах шаардлагатай байдаг.

Монгол Улсын хувьд ЖСХ-ийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдын энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, даван туулагч төвтэй хандлагад сургахад чиглэсэн тодорхой хэмжээний чадавхжуулах үйл ажиллагаанууд сүүлийн жилүүдэд идэвхтэй хэрэгжсэн байна. Тухайлбал, АНУ болон Монгол Улсын хоорондын Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний хүрээнд 2020 оноос хойш хэрэгжиж буй “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд дараах сургалтуудыг улсын хэмжээнд зохион байгуулсан байна.

Хүснэгт 27. “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтууд

№	Сургалтын нэр	Оролцогчид
1	Цахим орчинд үйлдэгддэг хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх нь	Цагдаа, прокурор болон шүүхийн байгууллагын 45 алба хаагч
2	Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн хэргийг хянан шийдвэрлэхэд хохирогч-төвтэй хандлагыг бэхжүүлэх	Нийслэлийн 9 дүүргийн прокурор, цагдаагийн байгууллагын 120 алба хаагч
3	Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх, алба хаагчдыг хохирогч-төвтэй хандлага	21 аймгийн нийт 120 алба хаагч, нийслэлийн нийт 37 алба хаагч
4	Хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдэд урлагийн сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх арга зүй олгох	Цагдаагийн байгууллагын 90 алба хаагч
5	Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээ болон хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын арга зүй	Орон нутгийн цагдаагийн байгууллагын 14 сэтгэл зүйч
6	Хохирогч-төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	Хууль зүйн туслалцааны төвийн төв, орон нутгийн 45 өмгөөлөгч
7	Хохирогч-төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	21 аймгийн өмгөөлөгчдийн салбар зөвлөлийн 100 гаруй өмгөөлөгч
8	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч-төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын 785 алба хаагч (шүүгч-

№	Сургалтын нэр	Оролцогчид
		135, прокурор-168, цагдаагийн алба хаагч-482)
9	“Форензик ярилцлага (Forensic Interview)” хийх аргачлалыг нутагшуулах ажлын хүрээнд сургагч багш бэлтгэх сургалт	Цагдаагийн байгууллагын 20, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын 12 албан хаагч
10	Хөгжлийн бэрхшээлтэй хүний болон ЛГБТИК+ хүний эрхийн сургагч багшаар бэлтгэх сургалт	Хууль сахиулах байгууллагын болон нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны 115 алба хаагч

Эх сурвалж: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл

Уг төслийн тогтвортой байдлыг нь хангах зорилгоор сургалтын гарын авлагууд, цахим хичээлүүдийг бэлдэж байгаа талаар ганцаарчилсан ярилцлагад дурдаж байв. Тухайлбал, “Хохирогч-төвтэй, хүүхдэд ээлтэй мөрдөн шалгах ажиллагаа” гэсэн 8 модуль цахим хичээлийг бий болгож, ЦЕГ-ын сургалтын платформд оруулахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Ингэснээр мөрдөх чиг үүрэгтэй ажиллах гэж байгаа албан хаагч бүр тухайн 8 модуль хичээлийг заавал үзэх болох юм.

Тус төслөөс гадна бусад олон улсын байгууллагын хэрэгжүүлж буй төслүүдийн хүрээнд хууль сахиулах байгууллагуудын ажилтнуудыг чадавхжуулах үйл ажиллагаанууд хийгдсэн. Тухайлбал,

- Японы хүүхдийг ивээх сангийн хэрэгжүүлж буй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь (2021-2024)” төслийн хүрээнд “Хүүхэд хамгааллын чадавхжуулах сургалт”-ын 11 модуль гарын авлага, хөтөлбөр боловсруулан, 2023 онд 1,289 үйлчилгээ үзүүлэгч, албан хаагч (Save the Children Mongolia, 2024), үүнээс цагдаагийн байгууллагын 70 гаруй алба хаагч сургалтад хамрагдсан байна.
- АХБ-ны “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд ЖСХ, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой цахим сургалтын модулийг боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын цахим сургалтын платформд байршуулсан байна. 2024 оны 6-12 сарын байдлаар нийт 1,654 цагдаагийн албан хаагч тус цахим модулиудыг үзэж, судалжээ (ADB, 2024).
- Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын “Монгол улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх нь (2019-2023)” төслийн хүрээнд [“ГБХ-тэй тэмцэхэд хохирогч-төвтэй хандлагыг хэрэгжүүлэх хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага”](#)-ыг шинэчлэн боловсруулж, түүний дагуу 136 цагдаа, прокурор, шүүгч нарт холбогдох байгууллагуудын Сургалт, судалгааны төвтэй хамтран сургалт зохион байгуулжээ. Мөн гэр бүлийн хохирогчид эрх зүйн анхан шатны зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ хэрхэн үзүүлэх талаарх сургалтуудыг 467 мэргэжилтнүүдэд явуулсан байна (IDLO, 2023).

Эдгээрээс харахад сүүлийн жилүүдэд хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдыг ЖСХ, хохирогч-төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр чадавхжуулах үйл ажиллагаануудыг ОУБ-ын хэрэгжүүлж буй төсөл, буцалтгүй тусламжийн хүрээнд идэвхтэй зохион байгуулсан байна. Харин эдгээр сургалтуудын үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд албан хаагчдад олон талуудаас ялгаатай агуулга, аргачлал бүхий сургалтууд орохоос сэргийлж, нэг удаагийн бус хэд хэдэн удаагийн давтан сургалт орох шаардлагатай болохыг олон улсын байгууллагын төлөөлөл онцолж байв.

Зөрчил шалган шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үйл явц

Зөрчлийн тухай хуулиар хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчил гэж үздэг. Зөрчлийн тухай хуульд хүн худалдаахтай холбоотой зөрчлийг зүйлчлээгүй байдаг ба эрүүгийн хуулиар хүн худалдаалах гэмт хэргийг зохицуулдаг байна. Харин Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, Бэлгийн дарамт учруулахтай холбоотой зөрчлүүдийг энэ хуулийн дагуу шалгаж, шийдвэрлэдэг байна. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны процессыг доорх зургаар хялбаршуулан харуулав.

Дүрс 19. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үйл явц



Эх сурвалж: Судалгааны баг

Харин Эрүүгийн хуульд зааснаар “энэ хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг, энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хохирол, хор уршиг учирсныг гэмт хэрэгт тооцно”. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дараах үе шатын хүрээнд явагдаж байна.

Дүрс 20. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат



Эх сурвалж: Шүүхийн академи

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд

Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийллийн 4 хэлбэрийг бүрэн гүйцэд хуульчлаагүй байна (IDLO, 2021): Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийн 4 хэлбэрийг заасан ч Зөрчлийн тухай хуульд эдгээр хэлбэрээр илрэх зарим үйлдлийг зөрчил гэж тооцоогүй байна (ILEPHS, URIUIAM, 2021). Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэл гэдгийг ГБХТХ-д сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэж зааж, хүчирхийллийн төрөл бүрийг нарийвчлан авч үзсэн байдаг. Харин

Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан, ахмад настны тэтгэвэр, тэтгэмжээ ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан үйлдэл гэж заажээ. Үүнээс харахад гэр бүлийн хүчирхийллийн объектив шинжийг Зөрчлийн тухай хууль бүрэн хуульчилж чадсан эсэх нь эргэлзээтэй (Open Society Forum, 2022), учир дутагдалтай (IDLO, 2021) байгааг өмнөх судалгаануудад онцолсон байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг тодорхойлохтой холбоотой асуудал: Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг “гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн” гэж тодорхойлсон байдаг. Гэтэл холбогдох хуулиуд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн гэдгийг доор харуулсанчлан ялгаатай байдлаар тодорхойлсноор аль хуулийн нэр томъёог үндэслэж хохирогчийг тодорхойлох нь эргэлзээтэй болж, хуулиудын уялдааг хангаж чадахгүй байна (Open Society Forum, 2022).

Хүснэгт 28. “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаа” нэр томъёоны хуулийн тодорхойлолт

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.4-р зүйл	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3-р зүйл
Тайлбар: Энэ хуульд заасан “гэр бүлийн хамаарал бүхий харилцаа” гэж гэр бүлийн гишүүд, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа, гэрлэлт нь цуцлагдсан, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн, тэдгээрийн асрамжид байгаа хүмүүсийн хоорондын харилцааг ойлгоно.	3.1.Энэ хуулийн үйлчлэлд дараахь этгээд хамаарна: 3.1.1.эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд; 3.1.2.тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү. 3.2.Энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нэгэн адил хамаарна.

Түүнчлэн цагдаа, шүүх, прокурорын байгууллага гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийг шалган шийдвэрлэхдээ гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн гэсэн ойлголтыг ялгаатай ойлгосноос болж гэмт хэрэг, зөрчлийн хэргийн зүйлчлэл хийхэд бэрхшээл тулгарч, зүйлчлэлийг өөрчлүүлэх, хэргийн нөхцөл байдлыг шинээр судлах зэргээр процессыг даамжруулах асуудал гардаг болохыг бусад судалгаануудад өгүүлж байв (The National Legal Institute of Mongolia, 2021).

“Байнга” гэдэг ойлголттой холбоотой зөрчил, гэмт хэргийн уялдаа холбооны асуудал: Эрүүгийн хуулийн 11.7-р зүйлд заасан гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг гэж үзэх нэг гол шалгуур нь тухайн үйлдлийг “байнга” үйлдсэн байх нөхцөлийг тавьдаг. Гэтэл хуульд “байнга” гэсэн ойлголтыг тодорхойлсон тайлбар байхгүй байгаагаас цагдаа, прокурор, шүүхийн байгууллагууд өөр өөрөөр ойлгож, ял шийтгэл оногдуулахад зөрүү гарч байгаа талаар олон судалгаанд онцолсон байна. Монгол Улсын Дээд шүүхээс гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн хэд хэдэн тохиолдолд “байнга” гэх шинжийг тайлбарласан байдаг. Тухайлбал, 2020 оны 334 дүгээр тогтоолд “Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан “байнга” гэх шинж нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирлаж тарчлаасан зэрэг үйлдлийг тооны хувьд 3 ба түүнээс дээш удаа үйлдсэнийг ойлгох бөгөөд энэхүү үйлдэл нь зөрчлийн болон гэмт хэргийн шинжтэй эсэх нь хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй болно” гэж тайлбарласан нь Улсын дээд шүүхийн бусад тайлбаруудтай зөрчилдөж байна (Open Society Forum and NCAV, 2021). Тиймээс одоог хүртэл “байнга” гэсэн нөхцөлийг хэрхэн ойлгох нэгдсэн ойлголт байхгүй байна. Үүнээс болж дараах асуудлууд гарч буйг судалгаануудад дурджээ. Үүнд:

- Хуульч, хууль сахиулагчид Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан байнга гэх нэр томъёог өөр өөрөөр тайлбарлаж, ашиглаж байна (IDLO, 2021).
- Гурван удаагийн хүчирхийллийн хэрэг нь адил хэлбэрийнх байх ёстой эсэх, эсвэл өөр шинжтэй байж болох эсэх, хэрэв тийм бол Эрүүгийн хуульд тусгайлан зааснаас гадна ГБХТХ болон Зөрчлийн тухай хуульд тусгагдсан хэлбэрүүдийг нь тооцож үзэх эсэх нь тодорхойгүй (IDLO, 2021).

- Гурван тохиолдол нь тодорхой хугацааны дотор үйлдэгдсэн байх ёстой эсэх, гурваас хойших тохиолдлыг цагдаад дахин мэдэгдэх, эсвэл шүүхийн шийдвэр гаргах шаардлагатай эсэх нь тодорхойгүй (IDLO, 2021).
- Зөрчлийн тухай хуульд ГБХ үйлдэх зөрчил нь дотроо 5 шинжтэйгээр хуульчлагдсан ба 2 нь Эрүүгийн хуульд хуульчлагдаагүй. Зөрчлийн тухай хуулиар уг Эрүүгийн хуульд тусгагдаагүй зөрчлөөр 2-3 удаа баривчлах шийтгэл ногдуулаад дараагийн удаад нь эрүүгийн хэрэг үүсгэх гэхээр уг зөрчлийн шинж нь гэмт хэрэгт тооцогддоггүй асуудал бий болсон (The National Legal Institute of Mongolia, 2021).
- Шүүх гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээд тухайн үйлдэлдээ Зөрчлийн тухай хуулиар шийтгэгдсэн бол Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3-р зүйлийн 5-д заасан “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах” шударга ёсны зарчмын дагуу тэрхүү үйлдэлдээ дахин эрүүгийн хариуцлага хүлээхгүй байхаар шийдвэрлэх тохиолдлууд байна (Open Society Forum, 2022).
- Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан үйлдлүүдийн давтамжийн хоорондох хөөн хэлэлцэх хугацаа нь ямар байх талаар тогтсон нэг ойлголт байхгүй байна. Зөрчлийн тухай хуулийн 6 сарын хөөн хэлэлцэх хугацааг мөрдөх үү, эсхүл Эрүүгийн хуулийн 1 жилийн хөөн хэлэлцэх хугацааг мөрдөх үү гэдэг нь эргэлзээтэй (Open Society Forum and NCAV, 2021).

Энэ бүхэн нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах, дахин давтагдах үйлдлийг таслан зогсоох эрх зүйн зохицуулалтад тодорхой бус байдал үүсгэж, улмаар хүчирхийлэл үйлдэгчдийг гэмт хэрэгт татахгүй байх эрсдэлийг дагуулж байна. Иймд “байнга” гэсэн ойлголтыг Эрүүгийн хуулиас хасаж, үйлдлийн давтамж бус шинжээр хуульчлах хэрэгтэйг судалгаануудад дүгнэжээ.

Зөрчилд оногдуулж буй албадан сургалтад хамруулах, баривчлах шийтгэл нь үр дүн муутай байна:

Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчилд албадан сургалтад хамруулж, 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулахаар заасан нь шийтгэлийн хувилбаргүй, үр нөлөө муутай зохицуулалт болжээ (IDLO, 2021). Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн байвал цагдаагийн байгууллага эрүүлжүүлэх үйл ажиллагааг явуулж, эрүүл болсны дараа гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж байна. Гэтэл 7-30 хоногийн хугацаатай баривчлах шийтгэл оногдуулж байгаа нь гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоож чадахгүй байгааг судалгаануудад дурдсан байна (IDLO, 2021). Тухайлбал, 2020 оны судалгаагаар баривчлах шийтгэл эдэлсэн 452 хүнээс баривчлах шийтгэлийн үр дүнг тодруулахад 54.6% нь ямар ч үр нөлөөгүй, 31.8% нь дунд зэрэг, 13.4% нь сайн нөлөөтэй гэж хариулжээ. Мөн баривчлах төвд ажиллаж буй 40 алба хаагчаас уг асуултыг асуухад нэг ч албан хаагч сайн үр нөлөөтэй гэж хариулаагүй ба 22.5% нь ямар ч үр нөлөөгүй, 77.5% нь холбогдох хууль тогтоомж, үйл ажиллагааг нь сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна (GEACD, 2020).

Цаашилбал, судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын төлөөллүүдийн хэлж буйгаар тухайн этгээдийн эрүүлжүүлэгдсэн болон баривчлуулсантай холбоотой төлбөрийг хохирогч өөрөөсөө эсвэл өрхийн дундын хөрөнгөөс төлөх нь түгээмэл байдаг байна. Энэ нь хохирогчид болон тухайн гэр бүлд санхүүгийн дарамт учруулах, шийтгэл хүлээснийхээ төлөө өсөрхөн ялархаж дахин хүчирхийлэл үйлдэгдэх шалтгаан болж байгаа (ILEPHS, URIUIAM, 2021) ба хохирогчийг хүчирхийлэл үйлдэгч, түүний эцэг эх, ах дүү нь дарамталж, хонзогносон үйлдэл гаргаж, нөхцөл байдал улам дорддог талаар судалгаануудад өгүүлжээ (IDLO, 2021). Мөн судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын төлөөллийн мэдэгдэж буйгаар хүчирхийлэл үйлдсэн этгээд баривчлах байранд байхдаа бусад адил зөрчил гаргасан этгээдүүдтэй танилцаж, хоорондоо хүчирхийлэл үйлдсэн аргаа хуваалцан, илүү төгөлдөршүүлээд гарч ирж байж болзошгүй байна. Эдгээр шалтгаануудаас болж хохирогч мэдүүлгээсээ буцах, торгуулийн дүн бага зөрчлөөр шийдүүлэх, улмаар цагдаагийн байгууллагад гомдол мэдүүлэхээ болих шийдэлд хүрч байгаа нь хүчирхийллийг даамжруулах эрсдэл дагуулж байна (Saruul.J, Oyuntsetseg.L, & Tsetsegmaa.J, 2021).

Зөрчил үйлдсэн этгээдийг 7-30 хоног баривчлах хугацаанд зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулдаг ч ихэвчлэн хууль, дүрмийн талаарх мэдлэг, архи тамхины хэрэглээ буюу хорт зуршлын сөрөг үр дагаврын талаар агуулгын хүрээнд явагдаж буй нь үр дүнтэй биш байна (Saruul.J, Oyuntsetseg.L, & Tsetsegmaa.J, 2021). Тухайлбал, 2020 оны судалгаагаар зан үйлд нөлөөлөх сургалтыг хэрэгжүүлж буй 61 алба хаагчийн 80 орчим хувь нь сургалтын хэрэгжилт учир дутагдалтай гэж үзсэн бол албадан сургалтад хамрагдсан 452 этгээдийн 72.6 хувь нь сургалт үр нөлөөгүй гэж хариулсан байв (GEACD, 2020). Үүнээс гадна сургагч багшийн хүрэлцээ, чадавх муу, ажлын ачааллаас шалтгаалж хүн

нэг бүртэй ажиллах, мэргэшэх цаг хомс, баривчлах байрны орчин нөхцөл хүнд, сургалт явуулахад тохиромжгүй, сургалтын хэрэглэгдэхүүн хангалтгүй (ХЭҮТ, 2019), санхүүгийн асуудал шийдэгдээгүй талаар судалгаануудад дурджээ (Open Society Forum, 2020). Ийнхүү зан үйлд нөлөөлөх сургалт үр дүнгүй зохион байгуулагдаж байгаа нь хүчирхийлэл дахин давтагдах эрсдлийг бууруулахад бодитой нөлөөлж чадахгүй байна (NCAV, 2018).

Хэл ярианы бэрхшээлтэй иргэнээс мэдүүлэг авахтай холбоотой санхүүгийн бэрхшээл тулгардаг: Хэл ярианы бэрхшээлтэй иргэдээс мэдүүлэг авах нь тусгай ур чадвар шаарддаг бөгөөд энэ үйл ажиллагаанд мэргэшсэн хэлмэрчийн оролцоо зайлшгүй шаардлагатай. Гэсэн хэдий ч Монгол Улсад албан ёсны дохионы хэлмэрч цөөн, тус бүрийн үнэлгээ өндөр байдаг нь хуулийн байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн хүндрэл үүсгэж байна. Ганцаарчилсан ярилцлагад оролцсон төрийн байгууллагын төлөөллүүдийн мэдээлж буйгаар хэлмэрч хөлслөхтэй холбоотой зардлыг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлж чаддаггүй тул хэрэг мөрдөн шалгах явц удаашрах, хэлмэрчдийн төлбөр шийдвэрлэгдэхгүй байх асуудал үүсдэг байна. Түүнчлэн, нэг цагийн ярилцлага хэлмэрчийн оролцоотойгоор 2-3 цаг үргэлжлэх тохиолдол түгээмэл бөгөөд энэ нь хэлмэрч болон хохирогчийг ядаргаанд оруулах, хэлмэрчийн хомсдолыг улам хүндрүүлэх нөхцөл болж байна.

Нөгөөтээгүүр, нэг хохирогчийн хэрэг дээр олон хэлмэрч шаардлагатай болдог. Тухайлбал, нэг хохирогчийн мэдүүлгийг бүрэн авахын тулд хэл ярианы бэрхшээлтэй 5 гэрчтэй бол 5 өөр хэлмэрч шаардлагатай болдог. Гэтэл хэлмэрчдийн цалин, төлбөр хэрэг шийдэгдсэний дараа олгогдоно гэх шалтгаанаар саатах, бүрэн олгогдохгүй байх асуудал үүсэж, зарим хэрэг мөрдөн шалгах шатандаа гацахад хүрч байна. Хэлмэрчдийн хөлсийг ХНХЯ болон цагдаагийн байгууллагын төсөвт тусгадаг гэх боловч хүрэлцээ муу, санхүүжилтийн тодорхойгүй байдал нь хэлмэрчид ажиллахгүй байх, хэрэг шийдвэрлэх явц удаашрах шалтгаан болж байна. Энэ асуудал нь зөвхөн хуулийн байгууллагын санхүүжилтийн асуудал төдийгүй гэмт хэргийн оролцогчидтой хэрхэн ажиллах бодлогын нэг хэсэг юм. Иймд хэлмэрчийн төсөв, цалин, санхүүжилтийн механизмыг тодорхой болгож, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр бий болгох шаардлагатай байна.

Хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийг барагдуулахтай холбоотой асуудал: Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/268, А/275 дугаартай хамтарсан тушаалаар “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох, дүгнэх журам” батлагдсан бөгөөд үүний дагуу хохирогчдод учирсан сэтгэцийн гэмтэлд нөхөн төлбөр олгох механизм үйлчилж эхэлсэн. Гэсэн хэдий ч мөнгөн нөхөн төлбөр нь сэтгэцийн гэмтлийг бодитоор эмчлэх үр дүнтэй арга зам болж чадахгүй байгаа талаар ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан төрийн байгууллагын төлөөллүүд шүүмжлэлтэй хандаж байна. Учир нь хохирогч нөхөн төлбөр авсан ч сэтгэл зүйн эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээ авахгүйгээр ахуйн хэрэгцээнд зарцуулж байгаа нь тухайн гэмтлийн үр дагаврыг бууруулах бодитой нөлөө үзүүлэхгүй байна.

Энэ нь сэтгэцийн гэмтлийн нөхөн төлбөрийг зөвхөн мөнгөн дүнгээр үнэлж шийдэх тогтолцооны сул талыг харуулж байна. Хохирогчийн сэтгэл санааны байдал мөнгөөр эдгэхгүй, харин сэтгэц заслын эмчилгээ, мэргэжлийн тусламжийг тогтвортой, хүртээмжтэй байдлаар үзүүлэх тогтолцоо шаардлагатай байна. Одоогийн байдлаар, сэтгэл зүйн зөвлөгөө, эмчилгээ хохирогчийн сайн дурын үндсэн дээр хийгдэж байгаа нь нэг хэсэг хүмүүсийг энэ үйлчилгээнд хамрагдахгүй үлдээх шалтгаан болж байна. Түүнчлэн, мэдлэг, мэдээлэл дутмаг байдал нь хохирогчдыг сэтгэл зүйн тусламж авах боломжийг бүрэн ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Гэр бүл, хүүхдийн шүүх байгуулахтай холбоотойгоор шүүхийн байр болон шүүгчдийг мэргэшүүлэх шаардлагатай: 2024 оны Шүүх байгуулах тухай хуульд Монгол улсад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх, Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх байгуулахаар зааж, 2026 оны 1 сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр болсон. Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх бүхий албан тушаалтны өгсөн мэдээллээр гэр бүлийн шүүх байгуулагдсанаар гэр бүлийн болон насанд хүрээгүй хүний нас, бие, сэтгэл зүйн онцлогт тохирсон шүүхийн тусгай үйл явц, орчин бүрдэж, гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг буурахад нөлөөлнө гэжээ (The Judicial General Council of Mongolia, 2023). Харин олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдэд Дээд шүүхийн шүүгч болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний өгсөн ярианаас харахад Гэр бүл, хүүхдийн шүүхийн байрны асуудал шийдэгдээгүй буюу шийдэх хэрэгцээ зайлшгүй байгаа аж (Gogo News, 2024; Montsame Agency, 2024). Үүнээс гадна Монгол улсад гэр бүл, хүүхдийн маргааны хэргийг

тусгайлан шийдэж байгаагүй учир энэ чиглэлийн нарийн мэргэшсэн шүүгч байхгүй, тиймээс Гэр бүл, хүүхдийн шүүхэд ажиллах 44 шүүгчийг нарийн мэргэшүүлж сургах хэрэгцээтэй байгааг дурдсан байна.

Цагдаагийн албан хаагчдын хандлага, ажиллах арга барилтай холбоотой асуудлууд: Судалгаанд хамрагдсан хохирогчдын өгсөн мэдээллээс авч үзэхэд цагдаагийн байгууллагын албан хаагчдын уламжлалт, хохирогчийг гэм бурууг тогтоох хэрэгсэл мэт үзэх хандлага (ILEPHS, URIUIAM, 2021) хэвээр байгаа нь хохирогчийн аюулгүй байдал, эрхийг хамгаалах тогтолцоонд томоохон бэрхшээл үүсгэж байна. Зарим хохирогчид цагдаа нарын харилцаа хүчирхийлэгчийг өмөөрсөн, хохирогчийг үл ойшоосон, түрэмгий, үл итгэсэн байдалтай байдаг гэсэн ба энэ нь хохирогчдын цагдаагийн байгууллагад итгэх итгэлийг сулруулдаг байна. Мөн хохирогчид удаа дараа мэдүүлэг өгөх шаардлага тулгарч, шинэ байцаагч томилогдсон тохиолдолд хэргийн явцыг дахин эхнээс нь тайлбарлах шаардлага үүсдэг. Энэ нь хохирогчийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж, даван туулагч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад бэрхшээл болж байна. Цаашилбал, нэг хохирогчийн мэдээлснээр цагдаагийн албан хаагч хохирогчийн өгсөн мэдүүлгийг хүчирхийлэл үйлдэгчид задруулсан тохиолдол гарсан нь асуудлыг улам хүндрүүлж, дахин хүчирхийлэл гарах эрсдэлийг үүсгэсэн байна.

Шүүх хурлын үеэр талуудын хувийн мэдээлэл задардаг нь үйлчилгээ үзүүлэгч ажилтнуудад бэрхшээл болж байна: Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 11.1-д "...гэрч, хохирогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, ... зэрэг мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авна" гэж заасан байдаг. Гэвч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцож буй үйлчилгээ үзүүлэгчид, тухайлбал эмнэлгийн ажилтан, нийгмийн ажилтан, түр хамгаалах байрны ажилтнуудын аюулгүй байдал хангалтгүй байгаа талаар ярилцлагад хамрагдсан талууд онцолж байв. Тухайлбал, шүүх хурлын үеэр хүчирхийлэл үйлдэгч болон бусад талуудын дунд тэдний нэр, ажлын байр, гэрийн хаяг зэрэг хувийн мэдээллийг ил болгож, тэдний мэдүүлгийг хэт дэлгэрэнгүй мэдээлдэг байна. Энэ нь тухайн ажилтнуудыг хүчирхийлэгчдийн заналхийлэл, дарамтад өртөх эрсдэл үүсгэж, улмаар үйлчилгээ үзүүлэгчид айдастай ажиллах, хэргийг шийдвэрлэхэд идэвхтэй оролцохоос зайлсхийх нөхцөл бүрдэж буйг онцолж байсан.

Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд

ХХГХ-ийг хянан шийдвэрлэхэд Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн зүйлчлэлийн давхардал сөргөөр нөлөөлж байна: 2015 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд ХХГХ-ийг Палермогийн протоколын агуулгад тулгуурлан тодорхойлсон байдаг. Гэвч тус хуульд ХХГХ-ийн хэлбэрүүдийг бие даасан гэмт хэрэг болгон давхар хуульчилсан байна (IRIM and IOM, 2022). Тухайлбал, Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд ХХГХ-ийг хуульчлахдаа бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих, эд эрхтнийг авах зэрэг үйлдлийг ХХГХ-т тооцох, хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход ямар аргаар үйлдсэн байх нь хамааралгүй байхаар зохицуулсан. Гэвч ХХГХ-ийн хэлбэр бүрийг тусгайлан бие даасан гэмт хэрэг болгож зохицуулсан нь хуулийн зүйл, заалтын давхардал үүсгэж, энэ нь хуулийн заалтыг нэг мөр ойлгож хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхойгүй байдал үүсгэж байна. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд ХХГХ-ийг зүйлчилсэн хэдий ч мөн хуулийн дараах зүйл заалтын агуулга, шинж нь ХХГХ-ийн шинжийг агуулсан байна (TAF & IRIM, 2022). Үүнд:

- 12.3 дугаар зүйлд Бэлгийн мөлжлөг,
- 12.6 дугаар зүйлд Биеэ үнэлэхийг зохион байгуулах,
- 13.13 дугаар зүйлд Албадан хөдөлмөрлүүлэх,
- 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах,
- 16.4 дүгээр зүйлд Хүүхдээр гуйлга гуйлгах,
- 16.6 дугаар зүйлд Хүүхэд худалдах,
- 16.8 дугаар зүйлд Хүүхэд садар самууныг сурталчлах, уруу татах,
- 16.9 дугаар зүйлд Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах,
- 16.10 дугаар зүйлд Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх.

Эрүүгийн хуульд заасан дээрх гэмт хэргүүдэд оногдуулах эрүүгийн хариуцлагыг харьцуулж үзвэл ХХГХ т оногдуулах ял нь бусад хэргээс илүү өндөр байна. Гэтэл Эрүүгийн хуульд ХХГХ-ийн төрлүүдтэй төстэй гэмт хэргийн шинжийг хуульчлахдаа хэргүүдийн ялгааг сайн гаргаагүй, энэ талаар албан ёсны тайлбарыг Улсын дээд шүүхээс гаргаагүй зэрэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхойгүй байдал үүсгэж байна. Гэтэл хэрэг хянан шийдвэрлэх явцад нийтлэг тохиолдолд гэмт хэрэг үйлдэгчийн субъектив санаа, сэдлийг тодорхойлох боломжгүй нөхцөлд түүний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийн заалтаар буюу бага ялтай зүйл ангиар шийдвэрлэх зарчим үйлчилдэг. Тиймээс ХХГХ-ийн

төрөл хэлбэр тус бүрийг бие даасан гэмт хэрэг гэж тооцох нь энэ төрлийн гэмт хэргийг бусад гэмт хэргээр зүйлчилж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завшуулах нөхцөлийг бүрдүүлж байна (IRIM and IOM, 2022).

Хүн худалдаалах гэмт хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжүүлэгч талуудын боловсон хүчний асуудал: 2017 онд Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийг байгуулсан нь дэвшилтэй алхам боловч орон тооны хүрэлцээгүй байдал томоохон асуудал болж буйг судалгаанд оролцсон төрийн байгууллагын төлөөлөл онцолж байсан. Улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах үндсэн чиг үүргийг ердөө 6 албан хаагч²⁰ хариуцаж байгаа нь хүн хүчний дутагдалтай байгааг харуулж байна. Түүнчлэн, анхны дуудлага, мэдээллийг ихэвчлэн тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагууд хүлээн авч, анхан шатны ажиллагаа явуулдаг. Гэвч анхан шатны нэгжийн алба хаагчдын хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй (U.S. Department of State, 2024) байгаа тул тэдгээрийг тогтмол сургах (СССР & SICA LLC), мөн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад энэ төрлийн гэмт хэргийн дагнасан мөрдөгчийг ажиллуулах шаардлагатай (MGEC, 2022) талаар өмнөх судалгаануудад дурдаж байв.

Түүнчлэн, Монгол Улсад ХХГХ-ийг дагнан шийдвэрлэх шүүгч байхгүй (IRIM and IOM, 2022), шүүгчид одоогоор энэ төрлийн гэмт хэргийг дагнасан шүүгчийн шаардлага байхгүй гэж үзсэн байна (MGEC, 2022). Үүний оронд, ХХГХ-ийн хэргийг бусад гэмт хэргээс ялган таних, зүйлчлэл тодорхойлох, хохирогч-төвтэй чиг хандлагыг ашиглах асуудалд анхаарах шаардлагатай тул шүүгчдийг энэ чиглэлээр тасралтгүй сургах, эрх зүйн ойлголтыг нэг мөр болгох нь чухал талаар өмнөх судалгаануудад онцолж байв (СССР & IOM, 2023). Энэ шалтгаанаар олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хууль сахиулах байгууллагын ажилтнуудад сургалтуудыг зохион байгуулж байгаа ч бодит үр нөлөө нь тодорхой бус хэвээр байна. Тухайлбал, АНУ-ын Төрийн Департаментын 2024 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайланд шүүх эрх мэдлийнхний Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн мэдлэг ерөнхийдөө тааруу байгааг дахин онцолсон (U.S. Department of State, 2024) нь системтэй сургалтыг тогтвортой зохион байгуулах хэрэгцээ хэвээр байгааг харуулж байна.

Хохирогчийг таньж тогтоохтой холбоотой асуудал: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/57 дугаар тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх заавар” батлагдсан боловч энэ нь зөвхөн нийгмийн хамгааллын салбарын мэргэжилтнүүдэд ашиглагдах юм. Харин хууль сахиулах салбарын албан хаагчид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг байгууллагын хуулиар хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд тус тус арга зүйгээр илрүүлж байгаа байдал нь (СССР & IOM, 2023) энэ төрлийн хэргийг эрт илрүүлэх, хохирогчийг хамгаалахад хүндрэл учирч байна. Тухайлбал, цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчид, хилийн шалган нэвтрүүлэх алба хаагчид хүн худалдаалах эрсдэлийн хяналтын хуудас ашигладаг боловч энэ хуудас нь бүх шатны хууль сахиулах байгууллагын алба хаагчдад тогтмол ашиглагддаггүй, мөн түүнийг хэрхэн ашиглах талаар хангалттай сургалт явагдаагүй байна (U.S. Department of State, 2024). Түүнчлэн, хууль сахиулах байгууллагуудаас бусад салбарын албан хаагчид хохирогчтой тааралдсан ч таньж мэдэх, тогтоох мэдлэг, мэдээлэлгүй байгааг судалгаануудад дурдсан байна (СССР & IOM, 2023). Эдгээр шалтгаануудаас болж хүн худалдаалах гэмт хэргийн зарим хохирогчдыг, онцгойлон бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогч охидыг хүний наймаанд өртсөнөөс шууд шалтгаалсан хэргийн төлөө холбогдох албаныхан баривчлан саатуулдаг талаар АНУ-ын Төрийн Департаментын 2024 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайланд дурджээ (U.S. Department of State, 2024).

Насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчтэй холбоотой асуудал: ЭХХШТХ-ийн 9.5 дугаар зүйлд арван найман насанд хүрээгүй хохирогчийн тухайд түүний төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг; хэрэв ийм хүн байхгүй эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоохоор заасан. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг сайтар судлан зөв сонгож оролцуулах шаардлагатай ба ингээгүйгээс үйлдэгч нарын нөлөөнд автах, нэгэнт хохирсон хохирогчийг өөрийг нь буруутгах, хайхрахгүй орхих зэрэг асуудал гардаг (MGEC, 2022).

²⁰ 2025 оны 2 сараас тус нэгжийг бүтцийг дахин 6 орон тоогоор нэмж, 12 орон тоотой болгосон. Гэвч судалгааны мэдээлэл цуглуулалтын үед 6 албан хаагч ажиллаж байв.

Гэтэл хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын албан хаагчид үндсэн ажлынхаа хажуугаар энэ үүргийг гүйцэтгэдэг тул мөрдөн шалгах ажиллагаанд идэвхтэй, мэдлэг бүхий байдлаар оролцож чадахгүй байгааг (MGEC, 2022) судалгаануудад дурджээ. Үүн дээр нэмээд, хууль ёсны төлөөлөгч ажлаасаа гарсан тохиолдолд түүнийг шууд дахин томилдоггүйгээс хэрэг шийдвэрлэх үйл явц удаашрах, зарим тохиолдолд хэрэг хэрэгсэхгүй болох эрсдэлтэй байна (IRIM and IOM, 2022). Тиймээс хууль ёсны төлөөлөгчийг мэргэшүүлэх, тодорхой эрх, үүрэгтэй болгох, хариуцлагын механизмыг тодорхойлох зайлшгүй шаардлага тулгарч байна.

Бэлгийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд

Гэр бүлийн хүчирхийлэл, ХХГХ зэрэг ЖСХ-ийн бусад төрлүүдтэй харьцуулахад бэлгийн хүчирхийллийн талаарх цогц судалгааны ажил сүүлийн жилүүдэд тун бага хийгдсэн байна. Харин 2023 онд “Хүйсийн тэгш эрх төв”-өөс гүйцэтгэсэн “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ” судалгааны ажилд энэ төрлийн зөрчил, гэмт хэргийн нөхцөл байдал, эрх зүйн зохицуулалтыг дэлгэрэнгүй авч үзжээ. Тиймээс энэхүү хэсгийн үндсэн мэдээллийг тус судалгааны мэдээлэл болон ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан төлөөллүүдийн өгсөн мэдээлэлд үндэслэн бэлтгэлээ.

ДНХ-н шинжилгээний лабораторийн хүртээмжийн асуудал: Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт шүүхийн шинжилгээний төв болон харъяа байгууллагад явуулж буй шүүх эмнэлгийн шинжээчийн дүгнэлт, тэр дундаа тусгай шинжилгээний нэг төрөл болох ДНХ-н шинжилгээний дүгнэлт хамгийн чухал байр суурийг эзэлдэг (MGEC, 2023). Гэвч шүүхийн шинжилгээний хүртээмж тааруу байгаа нь тулгамдсан асуудал болж байна. “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ”-нд дурдсанаар (2023) орон нутагт ДНХ-н шинжилгээ авах лаборатори байдаггүй ба Шүүхийн шинжилгээний байгууллагын Тусгай шинжилгээний газарт ажиллаж буй цөөн тооны (2025 оны байдлаар 8) шинжээчид олон тооны шинжилгээ хариуцдаг аж. 2021 оны байдлаар л гэхэд нэг шинжээчид жилд дунджаар 361 шинжилгээ ногдож байжээ. Үүнээс шалтгаалж шинжилгээний хугацаа сунжрах, гэмт хэргийн нотлох баримт нотолгооны ач холбогдлоо алдах, гэмт хэргийн илрүүлэлт, нотолгооны үр дүнд доголдол үүсэх эрсдэл бий болдог байна. Тиймээс Шүүхийн шинжилгээний байгууллагын Тусгай шинжилгээний газарт харъяалагдах ДНХ-н лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар 5 бүс нутагт байгуулах асуудлыг нэн яаралтай судалж, шийдвэрлүүлэх шаардлагатайг тус судалгаанд дурджээ.

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчид дунд хүүхдийн эзлэх хувь өндөр хэвээр байгаа нь ноцтой асуудал болж байна: Судалгаануудаас үзэхэд энэ төрлийн гэмт хэргийн гаралт жил ирэх тусам өсөх хандлагатай бөгөөд хүүхэд, ялангуяа бага насны хүүхэд хохирогч болох нь түгээмэл байна. Үндэсний статистикийн хорооны тоон мэдээллээс үзвэл 2019-2023 оны хугацаанд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нийт хохирогчдын тоо 3,060 байснаас 17 хүртэлх насны насанд хүрээгүй хүний тоо 2,053 буюу 67.1 хувь нь байжээ. Үүнээс хүчиндэх гэмт хэргийн нийт хохирогчийн тоо 2,473 байснаас 17 хүртэлх насанд хүрээгүй хүний тоо 1,536 буюу 62.1 хувийг нь эзэлж байна (NSO, 2024).

Хүүхэд хохирсон энэ төрлийн гэмт хэрэг ихэвчлэн гэр бүлийн хүрээнд буюу хохирогчийн амьдарч буй орчинд үйлдэгддэг нь илрүүлэхэд хүндрэлтэй, мэдээлэх явдлыг хязгаарласан хэвээр байна. Хүүхэд насны онцлогоос шалтгаалан өөрийгөө хамгаалах чадваргүй, хүчирхийллийг эсэргүүцэх боломжгүй байдаг тул гэмт хэрэгтнүүдийн хувьд илүү хялбар бай болдог байна.

Өмнө нь дурдсанчлан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас томилогдсон насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчид хохирогчид учирсан хохирлыг нотлох баримтаар тогтоох, бүрдүүлж өгөх явдал зарим тохиолдолд хангалтгүй байгаа нь шүүхийн шийдвэрүүдэд бичигдсэн байна (MGEC, 2023). Тиймээс тэднийг чадавхжуулснаар энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдийн эрх ашгийг бүрэн хамгаалах, хэргийг нотлох баримтаар хангах, шүүхийн шийдвэр гаргахад бодитой нөлөө үзүүлэх боломжтой юм.

Бэлгийн хүчирхийллийн үргэлжлэх шинж, илрэх хугацаа болон хохирогчийг хамгаалахтай холбоотой асуудал: Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргүүд ихэвчлэн удаан хугацаанд үргэлжилж, олон удаагийн давтамжтайгаар үйлдэгддэг бөгөөд илрэх хүртлээ нууцлаг, далд хэлбэртэй байсаар байна. Өмнөх судалгаанаас (MGEC, 2023) харахад эдгээр хэргийн талаас илүү хувь нь цаг хугацааны хувьд үргэлжилсэн шинжтэй, зарим тохиолдолд долоон жил хүртэлх хугацаанд үйлдэгдсэн нь тогтоогдсон байна. Энэ нь хохирогчид гэмт хэргийн тухай мэдээлэх боломж хязгаарлагдмал, хүчирхийллийг таслан

зогсоох тогтолцоо сул байгааг харуулж байна. Түүнчлэн, гэмт хэргийн талаар хамгийн анх мэдээлэл авах боломжтой хүмүүс нь хохирогчийн эх, эмнэлгийн мэргэжилтнүүд, сургууль, найз нөхөд, багш, нийгмийн ажилтнууд байдаг нь анхаарал татаж байна.

Нөгөө талаас, биеэ үнэлэх болон түүнийг зохион байгуулахтай холбоотой зөрчлүүдийн тухайд өмнө нь биеэ үнэлж байсан эмэгтэйчүүд хэсэг хугацааны дараа биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг үйлдэж буй хандлага ажиглагдаж байна. Энэ нь тэднийг гэмт хэргийн орчинд удаан хугацаанд байлгахгүй, дахин гэмт хэрэгт холбогдохоос сэргийлэх бодлого, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Тиймээс зөвхөн хуулийн хариуцлага ногдуулах бус, хохирогчдын нийгэмшлийг дэмжих, тэдэнд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Бүлэг 4. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж

Энэ хэсэгт ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах цаашдын чиг хандлагыг судалгааны үр дүн болон оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх уулзалтын үндсэн дээр тодорхойлон гаргалаа. Зөвлөмжүүд нь ЖСХ-ийн өнөөгийн нөхцөл байдал, одоо хэрэгжиж буй арга хэмжээний үр нөлөөг гол оролцогч талууд хэрхэн үнэлж буйд суурилсан дүн шинжилгээнд үндэслэсэн болно. Ялангуяа, олон улсын байгууллагын дэмжлэгтэй хэрэгжүүлэх боломжтой санаачилгуудад онцгойлон анхаарч, эдгээрийн дотроос оролцогч талуудын хэлэлцүүлгийн үеэр тэргүүлэх ач холбогдол өгсөн зөвлөмжүүдийг танилцуулж байна.

ЖСХ-ээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой зөвлөмжүүд:

Асуудлын тодорхойлолт	Өнөөгийн зөрүү	Олон улсын байгууллагуудын боломжит дэмжлэгүүд
ЖСХ-тэй холбоотой бүртгэгдсэн хэргүүдийг ангилан ялгах тогтолцоо хангалтгүй бөгөөд гэмт хэрэг үйлдэгч болон хохирогчдын талаарх нарийвчилсан хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн мэдээлэл дутмаг байна	Энэхүү мэдээллийн зөрүүтэй байдал нь ЖСХ-ийн хандлага, шалтгаан, үр дагаврын талаар гүнзгий судалгаа, шинжилгээ хийх боломжийг хязгаарлаж, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, болон зорилтот бүлгийг тодорхойлох үйл явцыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.	#1. ЖСХ-ийн тохиолдлуудын бүртгэл, ангиллын зөрүүтэй байдал болон хохирогч, үйлдэгчийн нарийвчилсан мэдээллийн дутагдалтай байдлыг шийдвэрлэх үндэсний хэлэлцүүлэг өрнүүлэх, хэлэлцүүлгийг зохион байгуулах. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл (ГХУЗ) болон ЦЕГ-тай хамтран хэрэгцээг тодорхойлох, зөрүүг илрүүлэх цогц үнэлгээг гүйцэтгэж болно. #2. ЖСХ-ийн тоон мэдээлэл цуглуулах, шинжлэх үр дүнтэй хэрэгсэл, аргачлалыг боловсруулж, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, ЖСХ-ийг урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахтай холбоотой хөтөлбөр боловсруулалт, төлөвлөлт, төсөвлөлтөд тусгах арга замыг турших, нэвтрүүлэх
ЖСХ болон хүчирхийллийн бусад хэлбэрийн хохирогч, даван туулагчид хүчирхийлэлд өртсөн ч хууль хяналтын байгууллагад хандахгүй байх нэг шалтгаан нь хүчирхийллийг хүлцэн тэвчих хандлага юм. Өмнөх судалгаануудын үр дүнгээс харахад хүчирхийлэлтэй орчинд өссөн хүмүүс, ялангуяа эмэгтэйчүүд, хүчирхийллийг “энгийн үзэгдэл” мэтээр хүлээн зөвшөөрч, тэвчих ёстой зүйл хэмээн үзэх хандлагатай байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн өөр нэг шалтгаан нь хохирогч болон хүчирхийлэл үйлдэгч талуудын аль	- Оролцогч талуудын зүгээс гэрлэхийн өмнөх эрүүл мэндийн үзлэгийн нэгэн адил “гэр бүлийн боловсрол”-ыг гэрлэлтээс өмнөх заавал судлах хөтөлбөр болгон нэвтрүүлэхийг санал болгож байна. Ингэснээр хосууд гэрлэлтээс өмнө болон дараа тулгарах боломжтой зөрчлийг зохицуулах арга барил, гэр бүлийн үүрэг, хариуцлагын талаар мэдлэг, ур чадвар эзэмших боломжтой болж, хүчирхийлэл үүсэхээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэх юм. - Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг захиргааны болон эрүүгийн хариуцлагын хүрээнд шийдвэрлэгдсэний	Шинээр гэр бүл болсон хосуудад зориулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх боломж, хэрэгцээ шаардлагын талаар судалгаа хийх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Монгол Улсын Улсын бүртгэлийн ерөнхий газар-тай хамтран ажиллах. Ийм хөтөлбөр нь гэр бүлийн зөрчлийг шийдвэрлэх арга барил, хүчирхийллийн хор уршиг, гэр бүлийн үүрэг, хариуцлагын талаар хосуудад боловсрол олгоход чиглэнэ. - Цагдаагийн ерөнхий газартай зөвлөлдөж, гэр бүлийн хүчирхийллийн кейсүүд дээр хохирогч болон

IRIM судалгааны хүрээлэн

алинд нь зөрчлийг зөв байдлаар шийдвэрлэх ур чадвар дутмаг байгаатай холбоотой. Мөн хүчирхийлэл үйлдэгчдийн дийлэнх нь хүүхэд ахуйдаа хүчирхийлэлд өртсөн түүхтэй байдаг ба энэ нь хүчирхийллийг “хэвийн” хандлага гэж үзэх сэтгэлгээ төлөвшихөд нөлөөлдөг.	дараа хохирогч болон хүчирхийлэл үйлдэгч талуудад зориулсан сургалт, мэдлэг олгох үйлчилгээ дутмаг байна. Хэрэв талууд хамт амьдрах шийдвэр гаргасан тохиолдолд аль аль талд заавал хамрагдвал зохих сургалтыг тогтолцооны хувьд бүрдүүлэх шаардлагатай. Гэвч одоогийн байдлаар хэрэгжиж буй сургалтын агуулга нь эерэг зан үйлийг төлөвшүүлэх, гэр бүлд аюулгүйгээр эргэн нэгдэхэд чиглэсэн биш, харин ерөнхий мэдээлэл олгох түвшинд л одоо хязгаарлагдаж байна.	хүчирхийлэл үйлдэгч дахин хамтран амьдрах болсон тохиолдолд эргэн нэгтгэх явцад заавал хамрагдвал зохих зан үйлийн өөрчлөлтийн сургалтын хүрээнд гэр бүлийн боловсрол олгох боломжийг судалж, хамтран хэрэгжүүлэх. Эдгээр хөтөлбөр нь гэр бүлийн харилцааг сайжруулах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, урт хугацаанд зан үйлийн эерэг өөрчлөлт авчрах тогтвортой оролцоонд суурилсан байх шаардлагатай.
ЖСХ болон гэр бүлийн хүчирхийллийг (ГБХ) багтаасан хүчирхийллийн асуудал Монгол Улсад тулгамдсан асуудал хэвээр байна. Одоогийн хэрэгжиж буй арга хэмжээнүүд нь голчлон насанд хүрэгчдийн зан үйлд өөрчлөлт оруулахад чиглэж байгаа нь урьдчилан сэргийлэх эрт үеийн арга хэмжээнээс харьцангуй үр нөлөө багатай байдаг. Харилцан хүндлэл, тэгш байдал, хүчирхийлэл үл тэвчих хандлагыг хүүхдийн боловсролын тогтолцоонд бага наснаас нь төлөвшүүлэх нь урт хугацааны тогтвортой өөрчлөлтөд чухал ач холбогдолтой. Хүний эрхийн үнэт зүйлс болон хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэхэд эрт үеийн боловсрол хамгийн үр дүнтэй боломжийг олгодог.	- Одоогийн байдлаар хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, мэдлэг олгох үйл ажиллагаа нь ихэвчлэн Цагдаагийн ерөнхий газрын зүгээс эсвэл зарим төслийн хүрээнд сургуулийн орчинд хэрэгжиж буй кампанит ажлын хэлбэрээр хязгаарлагдан явагдаж байна. Үүнд сургалтын хөтөлбөрийн хүртээмж, бэлтгэгдсэн мэргэжилтнүүдийн тоо, сургуулийн багш, ажилтнууд болон орон нутгийн цагдаагийн байгууллагуудын нөөц, ажлын ачаалал зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. - Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь цар хүрээний хувьд хязгаарлагдмал бөгөөд ихэвчлэн түр хугацааны кампанит ажил, төслийн хүрээнд хэрэгждэг. - Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон хүний эрхийн боловсролыг ердийн сургалтын хөтөлбөрт системтэй, тогтвортой байдлаар нэгдүүлсэн бүтэц одоогоор байхгүй байна.	#3. Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын асуудал хариуцсан байгууллагуудтай хамтран ажиллах замаар ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэвшмэл ойлголтуудыг халах, хүний эрх, хүн хоорондын харилцааны асуудлыг боловсролын хөтөлбөрт нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Энэхүү дэмжлэг нь тухайн хүмүүсийн насны онцлогт тохирсон мэдлэг нэмэгдүүлэх материал боловсруулах, сургагч багш нарыг мэргэшүүлэх хөтөлбөр гаргах, мөн эдгээр сэдвийг цэцэрлэг, сургуулийн сургалтын хөтөлбөрт үр дүнтэйгээр тусгах, хяналт-шинжилгээний тогтолцоог бий болгох зэрэг үйл ажиллагааг багтааж болно. Түүнчлэн олон улсын байгууллагууд ЖСХ-ээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой шилдэг туршлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг уялдуулах, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, хэлэлцүүлэг, семинар зохион байгуулахад дэмжлэг үзүүлж чадна.
ЖСХ-тэй тэмцэх, тэр дундаа хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хянах, хувийн хэвшлийн оролцоог үнэлэх тогтсон механизм Монгол Улсад одоогоор байхгүй байна. Үүний улмаас аж ахуйн нэгжүүдийн дунд хууль,	Аж ахуйн нэгжүүд нь хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл болон бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг үл тэвчих орчныг бүрдүүлэх, мөн энэ чиглэлээр сургалт болон дахин сургалтын хөтөлбөр боловсруулах үүрэгтэй. Түүнчлэн, хөдөлмөрийн дотоод журамдаа гомдол шийдвэрлэх журмыг тусгах шаардлагатай. Гэсэн хэдий ч эдгээр хууль, журам нь практикт бүрэн хэрэгжихгүй байгаа нь	Хувийн хэвшлийг дарамт, хүчирхийллээс ангид ажлын байр, хөдөлмөрийн харилцааг төлөвшүүлэх хуулийн үүргээ биелүүлж, ажлын байранд урьдчилан сэргийлэх сургалт, зан үйлийг өөрчлөх хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Ажлын байр нь харьцангуй тогтвортой орчин учраас, хуулийн дагуу заавал зохион байгуулагдах ёстой сургалтын хүрээнд ажил олгогчдын зүгээс ажилтнуудынхаа зан үйлийн эерэг өөрчлөлтийг бий

IRIM судалгааны хүрээлэн

журмын дагуу хэрэгжилт, мөрдөлтийн тогтвортой байдал хангагдахгүй байна.	жендэрийн асуудлаар мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай байдал, мөн ЖСХ-ийн талаарх ажлын байрны сургалт, давтан сургалтад ашиглахуйц бодит, хэрэглэхүйц сургалтын хөтөлбөр, мэдлэгийн бүтээгдэхүүн хомс байгаатай холбоотой байна.	болгох системтэй сургалтыг байнга хэрэгжүүлэх боломжтой. Энэхүү системтэй арга нь олон нийтийн дунд нэг удаагийн мэдлэг олгох сургалтаас илүү үр дүнтэй байж болзошгүй бөгөөд оролцоог тасралтгүй хангаж, мэдлэгийг бататган хэвшүүлэх давуу талтай. Ажлын байранд заавал хамрагдах сургалтын хөтөлбөрийг зөвхөн ажлын байраар хязгаарлалгүйгээр ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, ажил болон гэр бүлийн орчинд хүчирхийлэлгүй зан үйлийг төлөвшүүлэх өргөн хүрээний боловсрол олгох агуулгаар өргөжүүлэх боломжтой. Мөн энэ чиглэлээр мэргэшсэн ТББ-уудыг хамруулж, хууль эрх зүйн мэдлэг олгох, зан үйлийг өөрчлөх дахин сургалтыг зохион байгуулах боломжтой. Энэ нь илүү өргөн хүрээтэй, үр дүнтэй байдлаар хүрэх боломжийг бүрдүүлэх юм.
---	---	---

ЖСХ-ийн хохирогч хамгаалалтай холбоотой зөвлөмжүүд:

Асуудлын тодорхойлолт	Өнөөгийн зөрүү	Шаардлагатай дэмжлэг, шийдэл
- ХГБХХЕГ-ын харьяа түр хамгаалах байрнууд үйлчилгээ үзүүлсэн насанд хүрэгчдийн тоогоор маш бага хэмжээний санхүүжилттэй ажилладгаас насанд хүрсэн хохирогчийг хүлээж авахтай холбоотой ойлголтын зөрүү үүсэх нөхцөл үүсэж байна. - ЦЕГ-ын харьяа хамгаалах байрнууд жилд үйлчлүүлж буй насанд хүрсэн хохирогчдын дийлэнхийг хүлээн авч, үйлчилгээ үзүүлдэг ч хувьсах зардлын санхүүжилтгүй, дотоод нөөцөөр үйл ажиллагаагаа явуулж байна. - Эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ-ийн эрүүл мэндийн салбарын төсвөөс санхүүжихээр заасан ч, өнөөг хүртэл үйл ажиллагааны төсөвгүй үйл ажиллагаа явуулж байна.	- Түр хамгаалах байр болон НЦҮТ-ийг ажиллуулж буй бүх байгууллага өөрийн харьяа салбар (жишээлбэл, цагдаа, эрүүл мэнд)-ын хүрээнд үйлчилгээний төсвөө тусдаа төлөвлөж, батлуулдаг. Энэ салангид зохион байгуулалт нь байгууллагын харьяалал, санхүүгийн чадамжид үндэслэн зарим үйлчилгээний байгууллага огт санхүүжилтгүй эсвэл хангалтгүй төсөвтэй байх нөхцөл бүрдүүлж, үйлчилгээний тогтолцооны уялдаа холбоог алдагдуулж байна. - Үүний үр дүнд орон нутгийн төсвийн нөөц боломж, шийдвэр гаргагчдын мэдлэг, хандлага, тэргүүлэх чиглэл зэргээс хамааран хамгаалах үйлчилгээний санхүүжилт бүс нутгуудад харилцан адилгүй, тогтворгүй байх эрсдэл үүсэж байна.	#1. ЖСХ-ийн хохирогчийг хамгаалах үйлчилгээний зардлыг холбогдох байгууллагуудын төсөвт тусгуулах чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах: Нэн тэргүүнд, олон улсын байгууллагууд (АХБ, НҮБХАС, ЖАЙКА...) ГХУСЗ-тэй хамтран орон нутгийн хүн амын тоог харгалзан хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд жилд шаардлагатай төсвийг тодорхойлох судалгаа хийж гүйцэтгэх. Зорилтот түр хамгаалах байр, НЦҮТ-ийг байршил, үйлчилгээний төрөл, чиглэлийн дагуу ангилан, хариуцсан олон улсын байгууллагууд нөлөөллийн ажлыг хуваарилан хэрэгжүүлэх. Судалгааны үр дүнд үндэслэн үйлчилгээний төсвийг орон нутгийн болон харьяа салбарын (эрүүл мэнд, цагдаа гэх мэт) санхүүжилтэд уялдуулан тусгуулах, засаг дарга нарын “Үр дүнгийн гэрээ”-нд тусгаж албажуулах чиглэлд нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх боломжтой. #2. Санхүүжилтийн салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, олон талын оролцоонд суурилсан аргаар санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох: Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ), Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ), Эрүүл мэндийн яам (ЭМЯ) зэрэг холбогдох талуудын оролцоотой олон талт хэлэлцүүлэг зохион байгуулж, ЖСХ-д өртсөн хохирогчдод үзүүлэх хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгох асуудлыг хэлэлцэх. ГБХ, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийн дэмжлэгтэйгээр ажлын хэсэг байгуулах замаар одоогийн санхүүжилтийн механизмд үнэлгээ хийж, тулгамдсан асуудлуудыг тодорхойлон, сайжруулах бодлогын санал боловсруулах. Энэхүү үйл явцад Сангийн яамны идэвхтэй оролцоог хангах нь чухал. Санхүүжилтийн механизмыг сайжруулах чиглэлээр олон улсын байгууллагууд судалгаа, арга зүйн дэмжлэг үзүүлэх, боломжит шийдлүүдийг хэлэлцэх, тогтвортой санхүүжилтийн талаарх олон улсын туршлагаас суралцах зэргээр техникийн туслалцаа үзүүлэх боломжтой.

- Халаалт, дулаан, ариун цэврийн байгууламж, засвар үйлчилгээ зэрэгтэй холбоотой хамгаалах байрнуудын тав тухыг сайжруулах шаардлагатай. - Хохирогчдыг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээхэд шаардлагатай техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, орон зай (жишээлбэл, компьютер, цахим номын сан...) дутмаг. - Хамгаалах байрны тав тух, хөгжлийн, боловсролын, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйл ажиллагаа дутмаг байгаатай холбоотойгоор хамгаалах байранд удах тусам эргээд сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж эхэлдэг.	- Олон хамгаалах байр нь дулаан, бохирын шугам, анхан шатны дэд бүтэц хангалтгүй, эвдрэлд орсон барилга байгууламжид байрладаг бөгөөд энэ нь хохирогчдод тав тухтай, чанартай үйлчилгээ үзүүлэх боломжийг хязгаарлаж байна. - Мөн хамгаалах байрнуудад нөхөн сэргээх үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай сэтгэл зүйн дэмжлэг болон хувь хүний хөгжлийн олон төрлийн арга хэмжээг зохион байгуулах хэрэгцээ өндөр байгаа ч эдгээр үйл ажиллагаа дутмаг байна. Энэ нь 2 ба түүнээс дээш долоо хоног байрлаж буй үйлчлүүлэгчдийн хувьд хийх зүйлгүй байх, удах тусам сэтгэл зүйн хувьд хямрал үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг. Дасгал хөдөлгөөн, байгальд суурилсан, амьтанд суурилсан, урлаг, хөгжимд суурилсан гэх мэт олон талт сэтгэл заслын үйлчилгээ, хохирогчдыг чадавхжуулах хөдөлмөр эрхлэх мэдлэг, ур чадвар олгох сургалт, боловсролын үйл ажиллагааг хамгаалах байранд зохион байгуулж чадвал хохирогчдыг нөхөн сэргээх үйлчилгээнд чухал нөлөө үзүүлэх боломжтой юм.	#3: Хамгаалах байрнуудын орчин, нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх: Хамгаалах байр болон НЦҮТ-ийн хүртээмж, дэд бүтэц, тохижилт, орчныг сайжруулахад техникийн тусалцаа үзүүлж, аюулгүй, тав тухтай орчинг бүрдүүлэхэд хөрөнгө оруулалт хийх. Ялангуяа ариун цэврийн өрөө, угаалгын, хатаах өрөөнүүдийн тохижилт, ашиглалтыг сайжруулах. Мөн хамгаалах байрны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх нь хохирогчдод үндсэн үйлчилгээ рүү аюулгүй хүрэх боломжийг бүрдүүлж, тэдний нөхөн сэргээх үйл явцад дэмжлэг үзүүлэх орчныг бий болгоход хувь нэмэртэй байна. Хувь хүний хөгжлийг дэмжих сэтгэл зүйн, боловсролын олон талт үйл ажиллагааг хамгаалах байрнуудад хэрэгжүүлэх: Хамгаалах байрнууд дахь сэтгэл зүйн дэмжлэгийн олон төрлийн хөтөлбөр болон үйл ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих. Үүнд технологийн хэрэгслүүд, цахим номын сан, сэтгэл заслын үйлчилгээний орчин (урлагийн эмчилгээ, хөгжмийн эмчилгээ, байгаль/есо эмчилгээ, амьтанд суурилсан эмчилгээ) гэх мэт. Мөн хохирогчдын эдийн засгийн бие даасан байдлыг дэмжих хөтөлбөрүүд (мэргэжлийн боловсролын хөтөлбөрүүд, цахим боловсрол, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрүүд) нь хохирогчдод итгэл найдвар сэргээж, бие даасан байдлыг олгох боломжийг бүрдүүлнэ.
Хохирогчийг өртсөн гэмт хэргийн төрөл, сэтгэлзүйн нөлөө, гэмтлийн зэргээс хамааран төрөлжүүлэн	Хүчирхийллийн хохирогчдыг гэмт хэргийн төрөл, сэтгэцэд үзүүлэх нөлөө, бие махбодод учруулсан гэмтлийн байдлаас шалтгаалан төрөлжүүлэн байрлуулах хэрэгцээ байсаар байгаа бөгөөд хүйс болон тусгай хэрэгцээгээр нь ангилах шаардлага ч үүсдэг. Одоогоор хамгаалах байрны төрөлжсөн үйлчилгээ зөвхөн бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд зориулсан түр хамгаалах байр болон хүний наймааны хохирогчдод тусламж үзүүлдэг ТББ-уудын цөөн тооны байраар хязгаарлагдаж байна.	Хамгаалах байрны үйлчилгээний стандартыг шинэчлэхэд техникийн тусалцаа үзүүлэх: ГБХ, Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан MNS 6040:2019 стандартыг шинэчлэх ажилд арга зүйн болон техникийн дэмжлэг үзүүлэх. Энэхүү шинэчлэл нь хамгаалах байруудыг ЛГБТИК+ болон бусад жендэрийн ялгаатай бүлгүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бэрхшээлийн төрөл тус бүрийн ялгаатай хэрэгцээг харгалзан бүх хүн амын бүлэгт хүртээмжтэй, аюулгүй, тэгш орчин бүрдүүлэхэд чиглүүлэх нь чухал юм. Үүний тулд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ЛГБТИК+ бүлгийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг ТББ-тай нягт хамтран ажиллах шаардлагатай. Шинэчилсэн удирдамжид олон улсын стандартад

IRIM судалгааны хүрээлэн

байршуулах боломж хязгаарлагдмал. Хөгжлийн бэрхшээлтэй болон ЛГБТК+ зэрэг тусгай хэрэгцээ бүхий иргэдийг хүлээж авахтай холбоотой заавар, чиглүүлэг дутмаг, хүртээмж хязгаарлагдмал.	- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээн авах хамгаалах байрны хүртээмжийг үргэлжлүүлэн сайжруулах хэрэгцээ байсаар байна. - ЛГБТИК+ хүмүүс, ялангуяа трансжендэр иргэдийг хэрхэн хүлээн авч, ялгаварлан гадуурхлаас хамгаалах талаар тодорхой зааварчилгаа, чиглэл байхгүй тул үйлчилгээний хүртээмж нь тодорхойгүй, тэгш бус байдал үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна. - Барилга байгууламж, зай талбай, тохижилтын хувьд шаардлага хангахуйц хамгаалах байр цөөн байгаа бөгөөд урсгал засвар удаан хийгдээгүйгээс барилгын нөхцөл муудаж, эвдрэл гэмтэл, ажиллагаагүй болсон зүйлс нэмэгдсэн нь үйлчлүүлэгчдийн тав тух, сэтгэл зүйн тогтвортой байдалд нөлөөтэй байна.	нийцсэн, хохирогч-төвтэй, цогц хамгаалалт, урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээний зарчмуудыг тусгах. Мөн ТХБ-ны дотоод тохижилт, дэд бүтцийн хувьд тавигдах шаардлагуудыг нарийвчлан тусгаж өгөх. Сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах: Хамгаалах байрны ажилтнууд, хууль сахиулах байгууллагын алба хаагчид, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдийг хамруулсан тогтмол сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах. Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ЛГБТИК+ хүмүүсийг ялгаварлан гадуурхалгүйгээр, хохирогч-төвтэй, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх мэдлэг, хандлага, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарах. Хамгаалах байрны хүртээмж, төрөлжилтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх: ОУБ-ууд нь ГХУСЗ болон ХГБХХЕГ-тай хамтран бэлгийн хүчирхийлэл болон хүний наймааны хохирогчдыг хүлээн авах боломжтой төрөлжсөн хамгаалах байруудыг бий болгох, өргөтгөх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.
- ТХБ, НЦҮТ-ийн үйлчилгээний талаарх олон нийтийн ойлголт сул хэвээр. - Судалгаанд оролцсон хохирогчдын ердөө 18% нь өмнө нь үйлчилгээний талаар мэдээлэлтэй байсан бөгөөд ихэнх нь зөвхөн цагдаагийн байгууллагад хандсаны дараа л мэддэг болсон. - Түр хамгаалах байраар үйлчлүүлж буй иргэдийн дунд ч ямар үйлчилгээнүүдийг авах боломжтой талаар нэгдсэн ойлголт сул хэвээр байна.	- Хамгаалах байр болон НЦҮТ-ийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг сүүлийн жилүүдэд бага багаар нэмэгдэж байгаа хэдий ч, хүн амын томоохон хэсэг, ялангуяа хөдөө орон нутгийн иргэд эдгээр үйлчилгээний талаарх мэдээлэлгүй хэвээр байна. Хамгаалах байраар үйлчлүүлээд гарсан иргэдийн дунд ч ямар үйлчилгээг авах боломжтой байсан талаар бүрэн дүүрэн ойлголт сул байгаа нь судалгааны үр дүнгээс ажиглагдсан. - Мөн даван туулагчдыг өөрсдийг нь чадавхжуулах, эргээд нийгэмд өөрчлөлтийн дуу хоолой болоход нь чиглэсэн санаачилгууд Монголд маш бага байна.	Тодорхой бүлэгт чиглэсэн зорилтот кампанит ажлуудыг зохион байгуулах: Хөдөө орон нутаг болон хотын оршин суугчид, нийгмийн зорилтот бүлэг (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ЛГБТ хүмүүс гэх мэт) тус бүрийн онцлогийг харгалзан хамгаалах байр болон НЦҮТ-ийн тухай мэдээлэл олгох, үйлчилгээг танилцуулах олон нийтийн мэдээллийн кампанит ажлуудыг хэрэгжүүлэх. ЖСХ-ийн даван туулагчдыг чадавхжуулах, нэгтгэх санаачилгуудыг дэмжих: Хүчирхийлэлд өртсөн, даван туулсан хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх замаар хамгааллын үйлчилгээ болон урьдчилан сэргийлэх мэдлэгийг түгээх, хүмүүсийн ойлголтыг нэмэгдүүлэх, сэргийлэх арга хэмжээний хүртээмжийг сайжруулах. Энэ нь даван туулагчдыг өөрсдийг нь чадавхжуулах, тэдний нөхөн сэргээх үйл явцад ч чухал үүрэг гүйцэтгэх боломжтой.

Хохирогчийг нөхөн сэргээх үйлчилгээг сайжруулахтай холбоотой саналууд:

Асуудлын тодорхойлолт	Өнөөгийн зөрүү	Шаардлагатай дэмжлэг, шийдэл
ЖСХ-ийн хохирогчид олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэхээр хуулинд заасан хэдий ч бодит байдал дээр үйлчилгээний хүртээмж маш хязгаарлагдмал байна. 2024 онд түр хамгаалах байр, НЦҮТ-д хандсан иргэдийн зөвхөн 16% нь халамжийн үйлчилгээ, 1.6% нь хөдөлмөр эрхлэлтэд холбон зуучлуулсан байна. Хохирогчдын бие даан амьдрах чадавхыг дэмжихийн тулд урт хугацааны нөхөн сэргээх, чадавхжуулах үйл ажиллагаанууд шаардлагатай байна.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд ЖСХ-ийн хохирогчдод бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох (18.1.1) болон орлогын эх үүсвэртэй болгох (18.1.9) үйлчилгээнүүд тусгагдсан байдаг ч хамгаалах байранд байрлаж буй хохирогчид эдгээр үйлчилгээнд хамрагдах нь тун ховор байна. 2024 онд ТХБ, НЦҮТ-өөс үйлчилгээ авсан нийт 1809 насанд хүрэгчдээс халамжийн үйлчилгээг 289 буюу 16%, хөдөлмөр эрхлэлтэд холбон зуучлуулсан иргэдийн тоо 30 буюу нийт үйлчилгээ авсан иргэдийн 1,6%-ийг эзэлж байна. Түүнчлэн ЖСХ-ийн хохирогчдын онцлог хэрэгцээ, нөхцөл байдалд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд хангалтгүй байна. Хүчирхийллийн нөлөөгөөр өөртөө итгэх итгэл бага байх, олон хүүхэд асрах хариуцлага хүлээх зэрэг нь хохирогчдыг сургалт, хөдөлмөр эрхлэлтийн боломжид хамрагдахад саад болж байдаг.	Хамгаалах байр/НЦҮТ-дэд боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нэгтгэх үйл явцыг бэхжүүлэх: ХХҮГ, ХГБХХЕГ-тай хамтран төрөөс хэрэгжүүлж буй чадавхжуулах болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хамгаалах байр болон НЦҮТ-д нэвтрүүлэх нэгдсэн төлөвлөгөө боловсруулах ажлыг дэмжих. Эхний ээлжид хэрэгжилтийн боломж, бэрхшээлийг тодорхойлох судалгаа явуулж, улмаар амьдрах ур чадвар, санхүүгийн боловсрол, мэргэжлийн сургалт зэрэг тусгайлан боловсруулсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар эхлүүлэх боломжтой. Сонгогдсон байршлуудад туршилтын хөтөлбөр хэрэгжүүлснээр хамгааллын үйлчилгээ авч буй иргэдийг бие даан амьдрах ур чадвараар хангах нөхцөл бүрдэх бөгөөд амжилттай туршлагад үндэслэн энэхүү загварыг өргөжүүлэн хэрэгжүүлэх боломжтой. Нийгмийн энтерпрайз загварыг хөгжүүлж, хамгаалах байрны дэргэдэх ЖДҮ-д байгуулахад дэмжлэг үзүүлэх: Энэ санаачилга нь хохирогчдод ажлын дадлага олгох, ур чадварыг нь хөгжүүлэх, улмаар эдийн засгийн хувьд бие даах боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэлтийн сүлжээнд нэгтгэх цогц загварыг боловсруулах бөгөөд үүнд, жишээлбэл, төрийн байгууллагуудын худалдан авалттай холбох боломжийг судалж хэрэгжүүлнэ. Уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хохирогчдын сэтгэлзүйн нөхцөл байдлыг харгалзан, сайн дурын үндсэн дээр оролцох боломжийг хангах нь чухал. Мөн бичил санхүүжилт, хоршооны загвар, бизнесийн инкубац зэрэг нэмэлт дэмжлэг үзүүлэх замаар хохирогчдыг дадлагажигчаас хувиараа бизнес эрхлэгч болоход нь чиглэсэн цогц орчинг бүрдүүлэх боломжтой.
Хохирогчид НЦҮТ-өөс 24–72 цаг, түр хамгаалах байранд дунджаар 7–14 хоног байрладаг. Түр байраас гарсны дараа очих газаргүйгээс ихэнх тохиолдолд буцаад хүчирхийлэлтэй орчин уруу эргэж очихоос өөр аргагүйд хүрч байна. Даван туулагчдын бие даан амьдрах чадавхыг дэмжихэд орон сууцны хөтөлбөрийн дэмжлэг хамгийн	Хохирогч гэр бүлээ цуцлуулахаар шийдсэн тохиолдолд хамгаалах байрнаас гарсны дараах орон сууцны асуудал хамгийн тулгамдсан асуудлын нэг болдог. Ихэнх хохирогч түр хугацаанд эцэг эх, хамаатан садныдаа байрлаж байгаа ч энэ нь тэдний	ЖСХ-ийн хохирогчдыг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх сууцны дэмжлэгийн хөтөлбөрийг турших. Хөтөлбөрийн загварыг боловсруулахын тулд зах зээлийн судалгаа, хэрэгцээ болон хэрэгжилтийн боломжийн үнэлгээг (feasibility study) хийх шаардлагатай. Энэхүү загвар нь түрээсийн төлбөрийг бууруулах, түрээсийн татаас олгох, хамгаалалт бүхий хамтын орон сууцны

IRIM судалгааны хүрээлэн

чухал хэрэгцээнүүдийн нэг болохыг судалгаанд хамрагдсан даван туулагчид онцолж байв.	эмзэг байдлыг нэмэгдүүлж, бие даасан байдлыг хязгаарлаж байдаг. Хамгаалах байрнаас гарч, бие даасан амьдралд шилжих шилжилтийн үеийн орон сууцны дэмжлэгийн хөтөлбөрийн дутмаг байгаа нь хохирогчдыг хүчирхийлэгчтэй эргэн нэгдэх эсвэл орон гэргүй болох эрсдэлтэй тулгарахад хүргэж байна.	хэлбэрээр хохирогчдыг байрлуулах зэрэг олон хувилбарт шийдлүүдийг агуулж болно. Монгол Улсад энэ төрлийн үйлчилгээ хараахан хөгжөөгүй тул Япон, Пакистан зэрэг шилжилтийн үеийн орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлж буй орнуудын туршлагыг судлан, гүнзгийрүүлсэн судалгаа, шинжилгээ хийх шаардлагатай. Мөн үл хөдлөх хөрөнгийн компаниуд, үл хөдлөх хөрөнгө удирдлагын байгууллагууд, банк, санхүүгийн байгууллагууд, ажлын байранд зуучлах агентлаг зэрэг хувийн хэвшлийн түншүүдтэй хамтран ажиллах нь хөтөлбөрийн амжилтыг нэмэгдүүлэх чухал нөхцөл болно.
---	---	--

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сайжруулахтай холбоотой саналууд:

	Тулгамдаж буй асуудлууд/Судалгааны үр дүн	Шаардлагатай дэмжлэг, шийдэл
Challenges related to the capacity of the parties involved in the adjudication process of GBV cases have been identified.	Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийллийн бүх хэлбэрийг бүрэн тусгаагүй, Эрүүгийн хууль дахь “байнга” гэх ойлголтын тайлбарыг нэг мөр болгоогүй, “гэр бүлийн хамаарал бүхий харилцаа” гэх ойлголт Эрүүгийн, Зөрчлийн тухай болон ГБХТТХ-д ялгаатай байдлаар орсон зэрэг нь эргэлзээтэй, уялдаагүй байдлыг бий болгож байна. Мөн ХХГХ-тэй төстэй зарим үйлдлийг Эрүүгийн хуульд тусад нь зүйлчилж, давхардал бий болгосон байна.	• ЖСХ-тэй холбоотой хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах: Техникийн туслалцаа үзүүлж хууль тогтоох, хэрэгжүүлэх байгууллагууд (УИХ, ХЗДХЯ гэх мэт), олон улсын болон үндэсний экспертүүдтэй хамтран олон улсын сайн туршлага, тулгамдсан асуудлууд дээр үндэслэн ЖСХ-тэй холбоотой хуулиудад шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийх. • Талуудын дунд холбогдох хуулийн заалтуудын хэрэглээ, тайлбарыг нэг мөр болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах: Хэлэлцүүлэг өрнүүлэх, тайлбар боловсруулах зэргээр одоогийн хуулийн заалтуудын хэрэглээ, тайлбарыг нэг мөр болгоход дэмжлэг үзүүлэх. Ингэснээр хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийх хүртэл талуудыг нэгдсэн ойлголттой болгох, уялдаатай байдлыг сайжруулахад богино хугацааны дэмжлэг болно.
The penalty mechanism for domestic violence infringements is ineffective in addressing the issue adequately.	Гэр бүлийн хүчирхийллийн зөрчилд оногдуулж буй 7-30 хоног баривчлах, албан сургалтад хамруулах шийтгэлийн механизм нь үр дүн муутай байна. Богино хугацааны баривчилгаа нь хүчирхийллийг түр зуур тасалдуулж болох ч урт хугацааны хамгаалалт болж чаддаггүй. Эсрэгээрээ гэр бүлийн санхүүд хүндрэл учруулж, хохирогчдыг гэмт хэрэг, зөрчлийг мэдээлэхгүй байх, нуун дарагдуулах, хүчирхийлэл дахин үйлдэгдэх эрсдэлийг бий болгож байна. Түүнчлэн, албадан сургалтын агуулга нь ихэвчлэн хууль, дүрэм ойлгуулахад чиглэсэн бөгөөд санхүүжилт хүрэлцээгүй, баривчлах байрны орчин нөхцөл, сургагч багш нарын хүрэлцээ, чадавх тааруу зэрэг нь зан үйлд эерэг өөрчлөлт авчрахад бэрхшээл болж байна.	• Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн шийтгэлийн механизмыг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлэх: Хууль тогтоох, хэрэгжүүлэх байгууллагуудтай хамтран (ХЗДХЯ гэх мэт) гэр бүлийн зөрчилд ноогдуулах шийтгэлийн механизмийг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой. Жишээлбэл, уур бухимдлаа удирдах чадвар, мансууруулах бодис, согтууруулах ундааны хэрэглээ, сэтгэл санааны шарх зэрэг хүчирхийлэл үйлдэх зан үйлийн уг шалтгаанууд руу чиглэсэн, мөн жендэрийн тэгш байдал, хүчирхийлэлгүй харилцааны талаарх сургалт бүхий урт хугацааны нөхөн сэргээх хөтөлбөрийг шийтгэлтэй уялдуулж болно. Үүнээс гадна олон нийтэд тустай хөдөлмөр эрхлүүлэх, хяналт бүхий тусгаарлах арга хэмжээ авах, хохирогч, үйлдэгч хоёрыг цугт нь сургалт хамруулах зэрэг арга хэрэгслүүд байж болно. • Албадан сургалтын үр нөлөөг сайжруулахад дэмжлэг үзүүлэх: ШШГЕГ-тай хамтран баривчлах байруудын орчин нөхцлийг сайжруулах, сургагч багш нарын чадавхыг нэмэгдүүлэх, сургалтын хөтөлбөр, агуулгыг төрөлжүүлж, сайжруулах, сургалын цогц гарын авлага боловсруулах, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх байдлаар одоогийн албадан сургалтын үр дүнтэй байдлыг сайжруулах боломжтой.
The unclear legal provisions in the legal environment hinder the effectiveness of the adjudication process.	Судалгааны үр дүнгээс харахад цагдаагийн зарим ажилтны хандлага, харилцаа нь уламжлалт байдлаараа буюу хохирогчийг үл тоомсорлосон шинжтэй байна. Хохирогчид удаа дараа мэдүүлэг өгөх шаардлагатай тулгарч, мөрдөгч солигдох бүрд эхнээс нь бүхнийг ярих хэрэгтэй болдог нь	• Шүүгчдийн чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх: Гэр бүл, хүүхдийн шүүх байгуулагдаж буйтай холбоотойгоор тухайн шүүхүүдэд ажиллах 44 шүүгчийг гэр бүл, хүүхдийн хэргийг шийдэх чиглэлээр мэргэшүүлэхийн тулд системтэй сургалт, хэлэлцүүлгүүд зохион байгуулах боломжтой. Мөн Монгол улсад ХХГХ-ийг тусгайлан хариуцсан шүүгч байхгүй тул энэ

IRIM судалгааны хүрээлэн

	сэтгэл санаанд сөргөөр нөлөөлдөг байна. Судалгаануудад хөдөө, орон нутгийн цагдаагийн албан хаагчдын ХХТТХ-ийн талаарх мэдлэг ойлголт хангалтгүй байгааг дурдсан байна. Түүнчлэн, насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчид давхар үндсэн ажил үүрэгтэй, мэдлэг мэдээлэл хангалтгүй байх зэрэг шалтгаанаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд идэвхтэй, үр дүнтэй оролцож чадахгүй байх тохиолдол байдаг байна.	чиглэлээр шүүгчдийн дунд нэгдсэн ойлголтыг бий болгож, тасралтгүй сургалтын үйл ажиллагаа явуулах хэрэгцээтэй. • Цагдаагийн албан хаагчдын чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх: Нэгдүгээрт, ЖСХ-ийн хохирогчидтой ажиллаж буй цагдаагийн албан хаагчдын арга барилыг сайжруулах, даван туулагч төвтэй хандлагыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалт болон чадавх бэхжүүлэх үйл ажиллагаануудыг тогтмол, системтэйгээр зохион байгуулах шаардлагатай. Хоёрдугаарт, орон нутгийн цагдаагийн албан хаагчдын хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг таньж, илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах чадавхыг сайжруулж, энэ төрлийн гэмт хэргийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх хэрэгцээтэй. • Насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчдийн чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх: Насанд хүрээгүй хүний хууль ёсоор томилогддог, ялангуяа хүүхдийн асуудал хариуцсан төв байгууллагын мэргэжилтнүүдийн ЖСХ, гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, хохирогчидтой ажиллах ур чадварыг сайжруулах чадавх бэхжүүлэх үйл ажиллагаануд зохион байгуулах боломжтой. Нэг удаагийн шинжтэй бус тогтмол сургах аргачлалыг баримтлан, сургагч багш бэлтгэх, цахим сургалтын материал бий болгох, одоогийн сургалтын системийг сайжруулах зэргээр урт хугацааны үр нөлөө бүхий санаачлагуудыг хэрэгжүүлэх боломжтой юм. Мөн судалгаанд оролцогчдын саналын дагуу сургалтын хөтөлбөрт практик ур чадвар сайжруулах, орчин үеийн арга техникийг ашиглахтай холбоотой агуулгыг багтааж, бодит кэйстэй ажиллаж, туршлага судлах хэлэлцүүлэг, аялал зохион байгуулах нь зүйтэй.
The establishment of Family and Child courts requires appropriate court facilities.	Хөдөө орон нутагт ДНХ-ын шинжилгээний лаборатори байхгүйн улмаас бүх сорьцийг Улаанбаатар дахь лаборатори руу явуулдаг. Одоогоор тус лабораторид 8 шинжээч ажиллаж буй нь ажлын хэт ачаалал, шинжилгээний хариу удаж гарах нөхцлийг бүрдүүлж байна. Судалгаануудад шинжилгээний үйл явц удааширснаар нотлох баримт нотолгооны ач холбогдлоо алдах, гэмт хэргийн илрүүлэлт, нотолгооны үр дүнд доголдол үүсэх эрсдэлтэйг дурдсан байна.	• ДНХ-ын шинжилгээний лабораторын хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх: ШШЕГ-тай хамтран бүсийн хэмжээнд ДНХ-ын шинжилгээний лаборатори байгуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой. Үүний тулд судалгаануудад дурдсанчлан 5 бүсэд лаборатори байгуулах ТЭЗҮ хийх, турших боломжтой. Мөн лабораториудыг тоног төхөөрөмжөөр хангах, дэд бүтцийг сайжруулах, орон нутгийн шинжээчдийг чадавхжуулах ажлуудыг дурдаж болно. Явуулын ДНХ-ын шинжилгээний баг, лаборатори ажиллуулах, их сургуулиудын лабораториудтай хамтран ажиллах зэрэг жижиг мэт боловч үр дүнтэй аргуудыг ашиглан нотлох баримтыг хурдан хугацаанд шинжлэх боломжийг нэмэгдүүлж болох юм.
Challenges related to DNA testing laboratories cause	2024 оны Шүүх байгуулах тухай хуульд Монгол улсад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх, Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах	• Гэр бүл, хүүхдийн шүүхийн байр бий болгоход дэмжлэг үзүүлэх: Гэр бүл, хүүхдийн шүүхүүдийн байр бий болгох, мөн гэр бүл, хүүхдийн хэргийн онцлогт тохируулан хүүхдэд ээлтэй, аюулгүй, хувийн орон зайг хангасан байдлаар тохижуулахад дэмжлэг үзүүлэх боломжтой. Түүнчлэн, барилгын

IRIM судалгааны хүрээлэн

delays in forensic processing	шатны шүүх байгуулахаар зааж, 2026 оны 1 сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр болсон. Холбогдох талуудын мэдээллээс харахад Гэр бүл, хүүхдийн шүүхийн байрны асуудал шийдэгдээгүй буюу шийдэх хэрэгцээ зайлшгүй байна.	зураг төсөл, инженерийн тусламж үзүүлэх, барилга байгуулалтын санхүүжилтийг дэмжих, шүүхийн өрөөнүүдийг шаардлагатай тоног төхөөрөмж, тавилгаар хангах (цахим хурлын төхөрөөмжүүд, хүүхдэд ээлтэй хүлээлгийн өрөө, хувийн уулзалтын өрөө гэх мэт) зэрэг тусалцаанууд байж болно.
There is no unified system among law enforcement agencies.	Уялдаа холбоо сайтай шударга ёсны тогтолцоо нь хүчирхийлэл үйлдэгчдэд хурдан хугацаанд хариуцлага хүлээлгэх, хохирогчдод шаардлагатай дэмжлэг үзүүлэхэд нэн чухал. Гэвч, цагдаа, прокурор, шүүхийн байгууллагууд хэрэгтэй холбоотой мэдээллийг шууд хуваалцах нэгдсэн систем одоогоор байхгүй байна. Үүний улмаас эдгээр байгууллагуудын мэдээлэл хоорондоо зөрүүтэй, тодорхой хэрэг хэрхэн шийдэгдэж байгааг төвлөрсөн байдлаар хянах боломжгүй байна. Мөн ийм системийг хариуцан ажиллуулах тодорхой байгууллага, зохицуулалт, төсөв байхгүй байна.	• Кэйс менежментийн нэгдсэн систем бий болгоход дэмжлэг үзүүлэх: ХЗДХ, ШЕЗ, ПЕГ-тай хамтран цагдаа, прокурор, шүүхийн хооронд мэдээлэл солилцох, кэйс менежментийн нэгдсэн систем нэвтрүүлэх, бүтээхэд дэмжлэг үзүүлэх боломжтой. Ингэснээр хамтын ажиллагааг сайжруулж, шийдвэр гаргалтыг дэмжин, уялдаа холбоо бүхий дата мэдээллийг бүх талуудад хүртээмжтэй болгох нөхцөл бүрдэнэ. Үүний тулд шаардлагатай програм хангамж, дэд бүтэц, хууль сахиулах байгууллагын албан хаагчдын сургалт зэргийн хангах боломжтой.

Дүгнэлт

Монгол Улс дахь жендэрийн нөхцөл байдал: Монгол Улсын хувьд БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуульд эмэгтэй, эрэгтэй хүмүүс ялгаварлалгүй адил эрхийг эдлүүлэх тухай зааж, үүнээс хойш бүхий л хуулиадад эрх тэгш байх тухай агуулга гүн туссан байдаг. Үүний хүрээнд үндсэн суурь эрхүүдийн хүрээнд ялангуяа боловсрол, эрүүл мэндийн хувьд эрх тэгш байдал нь бусад улсуудтай харьцуулахад мэдэгдэхүйц дээгүүр байгаа нь 2024 оны Жендэрийн зөрүүтэй байдлын индексийн боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлт дээр 146 улсаас 1-рт эрэмбэлэгдэж байгаагаас харагдаж байна. Харин уг индексийн эрэмбээр эдийн засаг (43-рт) болон улс төрийн оролцооны (120-рт) үзүүлэлт мэдэгдэхүйц доогуур байгаа нь иргэдийн дунд тогтсон жендэрийн хэвшмэл хандлага, ойлголт байгааг үндэсний хэмжээний олон судалгаа харуулж байна. Тиймээс, жендэрийн эрхт байгш байдлын хувьд эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломж болон улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, эрэгтэйчүүдийн боловсрол болон эрүүл мэнд, ялангуяа дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлийг тэргүүлэх чиглэл болгож, энэ чиглэлд үндэсний хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж байгаа нь харагдаж байна.

ЖСХ-ийн нөхцөл байдал: ЖСХ-ийн нөхцөл байдлын хувьд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд тодорхойлсноор "жендэрт суурилсан хүчирхийлэл"-ийг тодорхойлсон боловч, түүнийг ангилал хэлбэрээр ангилсан, бүртгэл мэдээлэл дутмаг байна. Харин түүнийг илрэх хэлбэр, байршлаас нь хамааран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийн нийт 5 бүлэг гэмт хэргийн хүрээнд тодорхойлж болохоор байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зөрчил 2020 оны мөн үетэй харьцуулахад 2024 онд 12932 зөрчлийн тохиолдол бүртгэгдэж, сүүлийн 5 жилийн хугацаанд 20 гаран пунктээр өссөн байна. Харин гэмт хэргийн зүйл заалтуудын дагуу ЖСХ-д хамаарах бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2024 онд мөн адил үндэсний хэмжээнд 2020 онтой харьцуулахад даруй 42 пунктээр, Улаанбаатарт хотод 30 пунктээр, хөдөө орон нутагт (21 аймгийн нэгдсэн дүнгээр) 55 пунктээр тус тус өсчээ. Ялангуяа, хүний эрүүл мэндэд хөнгөн болон хүндэвтэр хохирол санаатай учруулах, хүчиндэх, гэсэн хэргүүдийн нийт холбогдох гэмт хэргүүдийн олонхыг эзэлж байгаа бөгөөд хүндэвтэр гэмт хэргүүд 2020 онтай харьцуулахад тоо мэдэгдэхүйц өсчээ. Бүртгэгдсэн гэмт хэргүүдийг ЖСХ-ийн хэлбэрээр ялган ангилахгүй, гэмт хэрэгт холбогдох талуудын хүн ам зүй, нийгмийн байдлыг харуулах нарийвчилсан мэдээлэл тусгагдахгүй байгаа нь ЖСХ-ийн нөхцөл байдал, шалтгаан, үр дагаварт нарийвчлан дүн шинжилгээ хийх боломжийг хязгаарлаж улмаар урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах нөлөөллийн ажлын зорилтот бүлгийг оновчтой тодорхойлох, үр дүнтэйгээр хүргэхэд сорилт болж байна. Үүнтэй холбоотойгоор ЖСХ-ээс үүдэлтэй сэтгэл зүй, нийгмийн үр дагавраас гадна эдийн засгийн үр дагаврууд ихээхэн бий болж байгаа бөгөөд ЖСХ-ийг бууруулах ажлын зардал болон ЖСХ-ийн хохирогч болон үйлдэгчээс гарж буй зардал болон алдагдсан боломжийн зардал гэх мэт эдийн засгийн хувьд ихээхэн хохирол дагуулж байна. Ялангуяа, Дотно хамтрагчийн зүгээс үйлдэж буй хүчирхийллийн үр дагавраас өрхөд үүссэн эдийн засгийн хохирол нь ЖСХ-ийн хариу арга хэмжээний зардлаас 24 дахин их байна. Эдгээр сорилтуудыг даван туулахын тулд ЖҮХ болон дэд зөвлөлүүд зэрэг олон талууд үүрэг хүлээн ажиллаж байна.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний нөхцөл байдал: ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх ажил нь төрийн байгууллагуудын хувьд тогтмол хийгддэг ажил болж байгаа хэдий ч нөөцөөс хамааран зөвхөн сургалт, сурталчилгааны хэлбэрээр хүрэхийн сацуу давтамж, цар хүрээ, арга хэлбэр, нийгмийн бүхий л бүлгүүдэд хүрэх хүртээмжийн хувьд хязгаарлагдмал байна. Төслийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлууд нь цар хүрээний хувьд мөн харьцангуй хязгаарлагдмал ч, сургуулийн орчинд болон олон нийтэд түшиглэсэн зан үйлийг өөрчлөх, 'Sasa together', 'Respect framework' гэх мэт шинэлэг стратги, арга аргачлал нэвтрүүлэх, санаачилгуудыг гаргах дээр эерэг өөрчлөлтийг бий болгож байна. Гэхдээ эдгээр сайн туршлагуудыг нэвтрүүлэх, өргөжүүлэх, үндэсний тогтолцоонд суулгах ажлууд дутмаг байна. Хууль сахиулах байгууллагууд болон ТББ-уудын хувьд насанд хүрсэн иргэдийн жендэрийн талаарх хэвшил ойлголтыг өөрчлөх эсхүл хүчирхийлэл үйлдэх хандлага бүхий зан үйлийг өөрчлөх нь үр дүнгийн хувьд ахиц гаргах магадлал маш бага тул гэр бүл төвтэй, сургуулийн өмнөх боловсролоос эхлэн бага наснаас нь сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хүний иргэний хүний эрхийн мэдрэмжтэй, хүчирхийллийг хүлцэн тэвчих хандлагад сургахын ач холбогдлыг онцлон дурдаж байлаа. Мөн Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн тухай хуулиар шийтгүүлсэн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх цогц үрт

хугацааны хөтөлбөрүүдийг хүргэх хүний нөөцийг бэлтгэх, төслийн хүрээнд хэрэгжсэн зан үйлийг өөрчлөх сургалтын сайн туршлагыг бүхий л аймаг, түвшинд нэвтрүүлэх ажлууд дутагдалтай байна.

Хохирогч хамгааллын үйлчилгээний нөхцөл байдал: Монгол Улсад ЖСХ-ийн хохирогчдод хамгааллын үйлчилгээ үзүүлэх бүтэц, тогтолцоо бүрдсэн бөгөөд төрийн болон ТББ-уудын нийт 40 ТХБ, НЦҮТ хохирогчдод хамгааллын болон нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлж байна. Судалгаанд хамрагдсан оролцогч талуудын үнэлгээгээр хохирогч хамгааллын болон нөхөн сэргээх үйлчилгээний эрх зүйн зохицуулалт харьцангуй сайн, 1-5 хүртэлх үнэлгээгээр 4 оноо авсан. Ерөнхийдөө тогтолцоо бүрдэж, талуудын чиг үүрэг тодорхой болж, механизм ажиллаж байгаа ч эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, уялдаа холбоог нэмэгдүүлэх шаардлага бас байна.

Олон асуудлын зангилаа болж буй хамгийн тулгамдсан асуудал нь дээр дурдсан 40 ТХБ, НЦҮТ-ийн санхүүжилтийн нэгдсэн тогтолцооны дутагдал юм. Эдгээр төвүүд ХГБХХЕГ, эмнэлэг, шүүх, цагдаа, ТББ гэсэн таван төрлийн байгууллагын харьяалалд байдаг бөгөөд ижил төрлийн үйлчилгээ үзүүлж, нэг стандарт, журмыг мөрдөж байгаа хэдий ч санхүүжилтийн эх үүсвэр нь харьяа байгууллага бүрээс хамаардаг тул тогтвортой, хүрэлцээтэй санхүүжилтээр үйл ажиллагаа явуулах боломж харилцан адилгүй байна.

Үйлчилгээний чанарын хувьд, хамгааллын үйлчилгээ авсан иргэдийн 98% нь ТХБ-нд өөрсдийн аюулгүй байдалд бүрэн итгэлтэй байгаагаа илэрхийлж, сэтгэл ханамж өндөртэй байгааг дурдсан. Гэвч хамгааллын үйлчилгээг илүү стандартын шаардлагад нийцүүлэх хэрэгцээ байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй, ЛГБТ зэрэг тусгай хэрэгцээтэй үйлчлүүлэгчдэд зориулсан үйлчилгээний аргачлалыг тодорхой болгох, хүний наймаа, бэлгийн хүчирхийллийн хохирогчдыг ангилан байрлуулж, аюулгүй байдлыг хангах, холбогдох заавар, журмыг үйлчилгээний нийтлэг шаардлагад тусгах шаардлагатай байна. Мөн хохирогчдын сэтгэл зүйн аюулгүй, тайван мэдрэмжийг хангахын тулд олон талт сургалт, хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь өндөр ач холбогдолтой байна.

Нөхөн сэргээх үйлчилгээний нөхцөл байдал: Монгол Улсад ЖСХ-ийн хохирогчдод үзүүлж буй нөхөн сэргээх үйлчилгээ нь эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн халамжийн үйлчилгээ гэсэн үндсэн чиглэлүүдийг хамарч байгаа боловч судалгааны үр дүнгээс харахад эдгээр үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүн харилцан адилгүй байна.

Нөхөн сэргээх үйлчилгээнүүдээс хамгийн өргөн хүрээнд хүрч буй нь сэтгэл зүйн зөвлөгөө, харин хамгийн бага хүртээмжтэй нь нийгмийн халамжийн дэмжлэг байна. Одоогийн **нөхөн сэргээх үйлчилгээ нь богино хугацааны анхан шатны дэмжлэгт төвлөрч, хамгаалах байрнаас гарсны дараах урт хугацааны нийгмийн амьдралд эргэн нэгтгэх үйлчилгээг хангалтгүй** байгааг судалгааны үр дүн харууллаа.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл байдал: Монгол Улсад ЖСХ-ийн (гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах зэрэг) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулах хууль эрх зүйн орчин бүрдсэн, чиг үүрэг бүхий байгууллагууд хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа ч зарим тодорхой асуудлууд тулгамдаж байна. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийллийн зарим хэлбэрийг Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд тусгаагүй, мөн холбогдох хууль тогтоомж дахь нэр томъёоны уялдаа муу нь гэмт хэрэг, зөрчлийг зөв зүйлчилж ялгах, тохирсон ял шийтгэл оногдуулахад хүндрэл учруулдаг. Мөн гэр бүлийн хүчирхийллийн зөрчилд одоогийн мөрдөж буй 7–30 хоног баривчлах, зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах арга хэмжээ нь үр дүн муутай байна. Цаашилбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч төвтэй хандлага төлөвшөөгүй нь хохирогчийн эрх ашгийг хамгаалахад саад болж байна. Тухайлбал, цагдаагийн зарим ажилтны хандлага, харилцаа нь уламжлалт байдлаараа байгаа, гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад асуудал тулгарч байгаа зэргийг судалгаанд оролцогчид дурдсан. Мэргэжлийн хэлмэрчийн хүрэлцээ сул, ДНХ-ын шинжилгээний лаборатор дутмаг, тодорхой албан тушаалд мэргэшсэн нөөц дутмаг зэрэг талуудын чадавх, нөөцтэй холбоотой бэрхшээлүүд мөн тулгарсаар байна. Эдгээр асуудлаас харахад хууль эрх зүйн орчин, хэрэг хянан шийдвэрлэх механизм, хохирогч төвтэй хандлага, талуудын чадавхыг сайжруулах хэрэгцээ байсаар байна.

Ашигласан материалууд

- UNFPA. (2020). *Achievement Book: Combating Gender-based Violence in Mongolia, Project Phase 1*.
- CPC. (2024). *Төслийн тайлан мэдээ*, .
- Shelter Head, N. (2024 оны Feb).
- ADB. (2024). *Mongolia: Combating Domestic Violence Against: Completion Report*.
- NSO. (2023). *НЦҮТ/Түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгаа*.
- MLSP. (2020). *Regulation on Calculating the Variable Cost per Person for Temporary Shelter Services, Order #A/150*.
- MLSP&MoF. (2022). *Methodology for Financing Child Protection Services and Service Cost Norms, Order #A/23, 27*.
- SCJ. (2022). *Research Report on the Evaluation of Standards for Temporary Shelters and One-Stop Service Centers Providing Services to Victims of Gender-Based Violence*.
- ADB. (2020). *Qualitative Research on Domestic Violence among People with Disabilities*.
- GoM. (2022). *Хууль зүйн туслалцааны хууль*.
- (2023). *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ*. Улаанбаатар: Монгол Улсад Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Зөвлөл.
- UNFPA. (2023). *ASSESSMENT REPORT ON HEALTH SECTOR READINESS TO GENDER-BASED VIOLENCE RESPONSE IN MONGOLIA*.
- Pawlak, P., Batmunkh, T., & Magsar, N. (2023). *Evaluation report: Combating gender-based violence in Mongolia project phase 2*. UNFPA.
- Lang, J., Munkh-Achit, M., & Gerelt-od, S. (2024 оны November 22). Promoting Healthy Masculinities to End Gender-Based Violence. <https://blogs.adb.org/blog/promoting-healthy-masculinities-end-gender-based-violence#:~:text=A%20recent%20study%20by%20ADB%20on%20men%E2%80%99s%20health,perpetrating%20violence%20against%20women%2C%20children%2C%20and%20other%20men.-ээс Гаргасан>
- UN. (2022). *UN Committee against Torture's General Comment No. 3 (2012): Implementation of article 14 by States parties, p.11*.
- Specialist, G. (2025 оны Mar).
- UNDP. (2023). *Evaluation of the Content and Outcomes of Employment Support Programs*.
- MLSP. (2024). *Танилцуулга: Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар*.
- WHO, Н. ү. (2013). *Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх дэлхий дахины болон бүс нутгийн тооцоолол: Дотно хамтрагчийн хүчирхийлэл, хамтрагч бус*.
- NSO. (2017). *Report on Gender-Based Violence Research: Naked Truth on Violence*.
- MLSP, MoJHA, MoH. (2017). *Procedure for Providing and Financing One-Stop Services*.
- TAF, MGEC. (2021). *Service mapping of the National Mechanism for Assisting Victims of Human Trafficking*.

- GoM. (2018). *Regulation of the Assistance Fund for Mongolian Citizens Abroad*.
- MFA. (2024). *Procedure for Providing Services to Victims of Human Trafficking*.
- GEACD. (2020). *Analysis of the Effectiveness of Mandatory Corrective Training*. Ulaanbaatar: General Executive Agency of Court Decision. <https://sudalгаа.gov.mn/pdf/zan-yld-noloolokh-albadan-surgaltyn-r-noloond-khiysen-shinzhilgee-bor-ээс> Гаргасан
- The National Legal Institute of Mongolia. (2021). *Studying the implementation of legal regulations on domestic violence infringement cases*. Ulaanbaatar: The National Legal Institute of Mongolia. <https://nli.gov.mn/wp-content/uploads/2023/05/12-1-ger-buliin-huchirhiilel.pdf-ээс> Гаргасан
- Save the Children Mongolia. (2024). *Annual Report 2023*. Ulaanbaatar: Save the Children Mongolia. https://savethechildren.mn/wp-content/uploads/2024/06/annual_report_mn.pdf-ээс Гаргасан
- ADB. (2024). *Combating Domestic Violence Against Women and Children: Completion Report*. Ulaanbaatar: ADB. <https://www.adb.org/sites/default/files/project-documents/51217/51217-001-pcr-en.pdf-ээс> Гаргасан
- IDLO. (2023). *Strengthening the Response to Gender-based Violence in Mongolia: Summary of Project Achievements*. Ulaanbaatar: IDLO.
- IDLO. (2021). *"Assessment of Mongolia's Legislation on the Adjudication of Domestic Violence Crimes and Infringements and Their Implementation from a Victim-Centered Approach"*. Ulaanbaatar: IDLO. <https://familycenter.mn/img/files/brochure/22e9536c6c75346a141ec53dbfeccd8e.pdf-ээс> Гаргасан
- ILEPHS, URIUIAM. (2021). *Criminological Research Report on Domestic Violence Crimes*. Ulaanbaatar: CCCP and NPA. <https://cccp.gov.mn/images/content/213f8649631806fb91cd0c6b00dd5978.pdf-ээс> Гаргасан
- Open Society Forum. (2022). *Overlap of domestic violence crimes and infringements*. Ulaanbaatar: Open Society Forum. https://forum.mn/uploads/users/3093/files/Domestic%20Violence%20Crime_Web.pdf-ээс Гаргасан
- Open Society Forum and NCAV. (2021). *The Status of New Types of Crime Adjudication*. Ulaanbaatar: Open Society Forum. https://cdn.greensoft.mn/uploads/users/88/files/New%20Crimes_For%20Web.pdf-ээс Гаргасан
- Saruul.J, Oyuntsetseg.L, & Tsetsegmaa.J. (2021). *Domestic Violence Infringements, Crime Adjudication, and Penalties Being Imposed in the Provinces*. Ulaanbaatar: Open Society Forum. https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2021/RS_19_Domestic%20Violence.pdf-ээс Гаргасан
- Open Society Forum. (2020). *Implementation of Mandatory Corrective Training*. Ulaanbaatar: Open Society Forum. https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2020/OSF_monitoring_21.pdf-ээс Гаргасан
- NCAV. (2018). *Evaluation Report on the Implementation of the Responsibilities Assigned to Police Officers by the Law on Combating Domestic Violence*. Ulaanbaatar: National Center Against Violence. <https://safefuture.mn/post/69563-ээс> Гаргасан
- ХЭҮТ. (2019). *Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт*. Улаанбаатар: ХЭҮТ. <https://safefuture.mn/post/69564-ээс> Гаргасан

- The Judicial General Council of Mongolia. (2023 оны October 25). *R. Ononchimeg: New courts specializing in simplified procedures and family and child cases will be established*. The Judicial General Council of Mongolia: https://www.judcouncil.mn/site/news_full/13424-ээс Гаргасан
- Gogo News. (2024 оны November 28). *A decision has been made to establish courts specializing in children and family cases, but there is no building available*. Gogo News: <https://gogo.mn/r/7l0lv>-ээс Гаргасан
- Montsame Agency. (2024 оны December 27). *Preparations are underway to establish a family and children's court*. Montsame Agency: <https://montsame.mn/mn/read/358474>-ээс Гаргасан
- IRIM and IOM. (2022). *Baseline assessment into the causes, dynamics, vulnerability and resilience levels to trafficking in Mongolia*. Ulaanbaatar: IOM. <https://cccp.gov.mn/newsm/200/252>-ээс Гаргасан
- TAF & IRIM. (2022). *A Data-driven Report on Combating Trafficking in Persons in Mongolia*. Ulaanbaatar: The Asia Foundation. <https://cccp.gov.mn/newsm/251/252>-ээс Гаргасан
- U.S. Department of State. (2024). *2024 Trafficking in Persons Report*. Ulaanbaatar: U. S. Embassy Ulaanbaatar. <https://mn.usembassy.gov/2024-trafficking-in-persons-report/>-ээс Гаргасан
- CCCP & SICA LLC. (n.d.). *Evaluation of the implementation of the National Program to Combat Human Trafficking*. Ulaanbaatar: CCCP. <https://cccp.gov.mn/newsm/204/252>-ээс Гаргасан
- MGEC. (2022). *Analysis of the investigation and adjudication of human trafficking and related cases*. Ulaanbaatar: TAF. <https://cccp.gov.mn/images/content/4dc9bfc593402af7a5a21708ed53bdf.pdf>-ээс Гаргасан
- CCCP & IOM. (2023). *Literature Review of Human Trafficking Crime Cases 2017-2022*. Ulaanbaatar: CCCP. <https://cccp.gov.mn/newsm/297/252>-ээс Гаргасан
- MGEC. (2023). *Analysis of the Situation of Crimes Against Human Sexual Freedom and Inviolability*. Ulaanbaatar: Mongolian Gender Equality Center. <https://cccp.gov.mn/newsm/202/252>-ээс Гаргасан
- НҮБХАС. (2020). *Дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн эдийн засгийн өртөг, зардлын тооцоо*. НҮБХАС.
- SCJ. (2023). *Trauma-informed, victim/survivor-centered services, Module 9*.
- Department, U. S. (2024). *Trafficking in Persons Report*.
- NSO. (2024 оны September 23). *Number of Victims, by Gender, Age Group, and Type of Crime*. National Statistics Office: https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2300_035V201&13999001_select_all=0&13999001SingleSelect=_T3_T4_T5_T1&CR035_select_all=0&CR035SingleSelect=_4_41_0&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2023_2022_2021_2020_2019&viewtype=table-ээс Гаргасан
- Specialist, G. (2025 оны 03). (J. Ganzorig, Ярилцагч)
- UNFPA. (2020). *Economic Costs and Estimates of Domestic Violence Perpetrated by Intimate Partners*.
- CPC. (2024). *Project report*.
- GoM. (2022). *Law on Legal Aid*.
- MLSP. (2024). *Presentation: Draft Revised Version of the Law on Child Protection*.
- NSO. (2023). *Assessment of Client Satisfaction with OSSC/Temporary Shelter Services and Public Knowledge, Attitudes, and Perceptions*.

UNFPA. (2017). *The Naked Truth of Violence: Gender-Based Violence Research Report*.

WHO. (2024 оны March 25). World Health Organization: <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/violence-against-women#:~:text=Estimates%20published%20by%20WHO%20indicate%20that%20globally%20about,Most%20of%20this%20violence%20is%20intimate%20partner%20violence.->ээс Гаргасан

UNFPA. (2023). *Assessment Report on Health Sector Readiness to GBV in Mongolia*.

Хавсралт

Хавсралт 1. ЖСХ-ийн даван туулагчдад үйлчилгээ үзүүлж буй ТББ-ын мэдээлэл



National Center Against Violence

ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ТӨВ (ХЭҮТ)

нь 1995 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улсад анх эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг үйлдэгддэг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор үйл ажиллагаагаа

эхлүүлсэн ашгийн төлөө бус, нам, улс төрөөс хараат бус, нийгэмд үйлчилдэг ТББ юм.

ХЭҮТ нь **шууд үйлчилгээ болон бодлогын нөлөөллийн ажлыг хослуулан, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг**. Тус төвийн онцлог нь **кейст суурилсан бодлогын нөлөөлөл** үзүүлэх арга барил бөгөөд бодит нөхцөл байдалд тулгуурлан хуулийн өөрчлөлтөд нөлөөлөх жишээтэй. Тухайлбал, бэлгийн хүчирхийллийн хохирогчдод Шүүх шинжилгээний хүрээлэнд төлбөр төлдөг байсан асуудлыг хөндөж, хуулийн зохицуулалтад өөрчлөлт оруулахад амжилттай нөлөөлсөн.

Үндсэн үйл ажиллагаа, үйлчилгээ: ХЭҮТ нь хуульд заасан 7 төрлийн цогц үйлчилгээг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлдэг. Үүнд:

- Сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг
- Хууль, эрх зүйн туслалцаа
- Амь нас, аюулгүй байдлын хамгаалалт
- Түр хамгаалах байр
- Нийгмийн ажлын үйлчилгээ
- Холбон зуучлах үйлчилгээ
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Түүнчлэн дараах дэд бүтэц, нэмэлт үйлчилгээг ажиллуулж байна:

- Сургалт, зөвлөх үйлчилгээний 1 төв
- Түр хамгаалах 3 байр
- “Итгэлтэй утас” зөвлөгөөний үйлчилгээ болон онлайн чатбот, өдөр тутмын ээлжээр ажилладаг зөвлөгчидтэй (*Өмнө нь 24 цагийн турш ажилладаг байсан ч санхүүжилтийн хүндрэлээс үүдэн зөвхөн өдрийн цагаар үйл ажиллагаа явуулж байна*).

ХЭҮТ нь “**хохирогч-төвтэй, даван туулагчийг дэмжих арга зүй**”-г баримтлан ажилладаг бөгөөд төрийн байгууллагуудад энэ чиглэлийн сургалт зохион байгуулдаг.

Онцлох хөтөлбөр, нөлөөлөл:

- Түр хамгаалах байруудын сүлжээг санаачлан бий болгож, чиглүүлэн хөгжүүлдэг нь тус төвийн онцлог юм.
- “Итгэлтэй утас” хөтөлбөр нь зөвхөн ХЭҮТ-д байдаг тусгай үйлчилгээний нэг юм.
- Өмнө нь орон нутагт салбар зөвлөлүүдтэй байсан боловч санхүүжилтгүйн улмаас үйл ажиллагаа нь зогссон.

Хүртээмж, үр дүн: Жил бүр дунджаар 3,000 гаруй хүн ХЭҮТ-д ханддаг бөгөөд үүнд “Итгэлтэй утас”, онлайн чатбот зэрэг зөвлөгөө, дэмжлэгийн бүх үйлчилгээ багтдаг. Зөвхөн төвийн шууд үйлчилгээнд жилдээ 200 орчим хүн ханддаг. Үүнээс эрсдэл өндөртэй хохирогчдыг түр хамгаалах байранд илгээж, тодорхой хугацаанд байрлуулан хамгаалах үйлчилгээ үзүүлдэг.

Байгууллагын веб хуудас: www.safefuture.mn



ХҮЙСИЙН ТЭГШ ЭРХИЙН ТӨВ (MGECS) нь 2002 оноос эхлэн жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй, ашгийн төлөө бус байгууллага юм. ХТЭТ нь хохирогч хамгаалал болон Урьдчилан сэргийлэх гэсэн 2 үндсэн хөтөлбөр хэрэгжүүлдэг.

1. Хохирогч хамгааллын хөтөлбөр: Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа хүний наймаа, бие махбодын болон

бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод дараах шууд болон нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлдэг:
Хүснэгт 29. ХТЭТ-ийн хохирогчид үзүүлж буй үйлчилгээ

Анхан шатны үйлчилгээ	Нөхөн сэргээх үйлчилгээ
- Сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө - Эрүүл мэндийн анхан тусламж - Хоол хүнс, ахуйн хэрэглээ, нэг удаагийн хувцас - Эх оронд нь эргүүлэн авчрах зохицуулалт	- Сэтгэл заслын үйлчилгээ - Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт - Ажилд зуучлах, өмгөөлөл - Гэр худалдан авч өгөх - Гэр бүл, өрхийг дэмжих үйлчилгээ - Бичил бизнес, өрхийн үйлдвэрлэл - Дэмжих бүлгийн хичээл, нийгэмшүүлэх үйл ажиллагаа

Хохирогчийн аюулгүй байдлын хангах үүднээс 2 хамгаалах байр ажиллуулдаг:

Хүснэгт 30. ХТЭТ-ийн түр хамгаалах байрны мэдээлэл

Үзүүлэлт	Улаанбаатар хот	Замын-Үүд сум
Үйл ажиллагаа эхэлсэн он	2008 он	2009 он
Нэг ээлжинд хүлээн авах хүчин чадал	6 хүн	4 хүн
Байрлах хугацаа	Хувь хүний нөхцөлөөс хамаарч 1–90 хоног (дундаж ор хоног 24)	1–7 хоног
Хамрах хүрээ	Дотоодын болон гадаадын хохирогчид	Хилийн чанадаас буцаж ирсэн хохирогчид
Үзүүлэх үйлчилгээ	Анхан шатны тусламж, сэтгэл зүй, хууль эрх зүй, сургалт	Анхан шатны тусламж, сэтгэл зүй, хууль эрх зүй, дараагийн шатны байранд шилжүүлэлт



2. Урьдчилан сэргийлэх хөтөлбөр: MGEC нь жендэрт суурилсан хүчирхийлэл, хүний наймааны гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийт болон мэргэжлийн бүлгүүдэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, судалгааны ажлуудыг тогтмол зохион байгуулдаг.

Хүснэгт 31. ХТЭТ-ийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн үйл ажиллагаа

Сургалт	Сурталчилгаа	Судалгаа
- Жендэр ба жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх нэгдсэн ойлголт өгөх - Хүний наймааны гэмт хэргийн талаарх анхан болон нарийвчилсан мэдээлэл - Мэргэжлийн болон зорилтот бүлгийн мэргэшүүлэх сургалтууд	- Телевизийн шторк, баримтат кино - Брошюр, зурагт хуудас, тараах материал - Хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлэг	- Хүний наймааны эрсдэл, шалтгаан, хор уршиг, олон нийтийн ойлголт, хандлагын судалгаа - Хохирогчдын талаарх нарийвчилсан судалгаа

Байгууллагын веб хуудас: www.stoptrafficking.mn



ТАЛИТА АЗИ ТББ нь бэлгийн мөлжлөг болон ХХГХ-ийн хохирогч болсон охид, эмэгтэйчүүдэд зориулсан нийгэм, сэтгэл зүйн нөхөн сэргээх цогц үйлчилгээг үзүүлдэг ТББ юм. Байгууллага 2013 оны есдүгээр сараас эхлэн үйл ажиллагаагаа эхлүүлж, хүний наймаа, бэлгийн мөлжлөгийн хохирогчдод урт хугацааны сэтгэл заслын болон нийгмийн дэмжлэг үзүүлэх, аюулгүй орчныг бүрдүүлэн хамгаалах байранд байрлуулах хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн.

Талита Ази нь улсын хэмжээнд бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон хүүхдүүдтэй ажиллах анхны тусгай зөвшөөрөлтэй байгууллага бөгөөд Швед улсын Талита олон улсын байгууллагын дэмжлэгээр санхүүжиж, Талитагийн аргачлалыг Монголын нөхцөлд нутагшуулан хэрэгжүүлдэг. Байгууллага хүүхдийг хамгаалах, хүчирхийллээс тусгаарлах, хохирогчийн сайн дураар нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах эрхийг хүндэтгэх зарчимд тулгуурлан ажилладаг. Талита Ази нь хохирогч хамгаалал болон Урьдчилан сэргийлэх гэсэн 2 үндсэн хөтөлбөр хэрэгжүүлдэг.

1. Хохирогч хамгааллын хөтөлбөр:

- Богино болон урт хугацааны хамгаалах байрууд (эмэгтэй болон эрэгтэй хохирогчдод зориулсан, нийт 4 ортой).
- 24/7 ажиллагаатай тусламжийн утас.
- Сэтгэл заслын эмчилгээний хөтөлбөр (27 долоо хоногийн хичээлтэй).
- Сэтгэл зүйн боловсрол (The Mind сургалтын хөтөлбөр).
- Эрүүл мэндийн тусламж – үзлэг, эмчилгээ, БЗХӨ оношилгоо.
- Хууль зүйн тусалцаа – цагдаа, прокурор, шүүхийн шатанд хамт байх, мэдүүлэг өгөхөд дэмжлэг үзүүлэх.
- Хувь хүний хөгжлийн сургалтууд – амьдралын дасгалжуулалт, санхүүгийн боловсрол, ажилд зуучлах дэмжлэг.
- Нийгэмшүүлэх дамжих байрны хөтөлбөр – бие даах чадварыг хөгжүүлэх.
- Гэр бүлээс тусгаарлан үйлчилгээ үзүүлэх шаардлагатай кейсүүд-д бодит тусламж үзүүлэх.

2. Урьдчилан сэргийлэх хөтөлбөр:

- Нийгмийн ойлголт, хандлагыг өөрчлөх мэдээлэл, сургалтын ажил.
- Бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй хүүхдүүдийг урьдчилан илрүүлэх, хамгаалах.
- Төрийн болон бусад байгууллагуудтай хамтын ажиллагаа, бодлогын зөвлөмж боловсруулах.
- Сургуулийн өмнөх боловсролын дутагдал, гэр бүлийн дэмжлэггүй байдал зэрэг эрсдэлт хүчин зүйлсийг таних, ажиллах аргачлал.

Хүснэгт 32. Талита Ази ТББ-ын хамгаалах байрнуудын мэдээлэл

Хамгаалах байр	Хүлээн авах бүлэг	Үйлчилгээний онцлог
Эмэгтэйчүүдийн хамгаалах байр	Хүүхэдгүй өсвөр насны болон насанд хүрсэн эмэгтэйчүүд	Удаан хугацааны сэтгэл заслын эмчилгээ, хувь хүний хөгжил, нийгэмшүүлэлт
Эрэгтэйчүүдийн хамгаалах байр	Хөдөлмөрийн мөлжлөгийн хохирогч эрэгтэй хүүхэд, залуус	Хувийн орон зай, нөхөн сэргээх үйлчилгээнд дасан зохицох тусгай аргачлал

Байгууллагын веб хуудас: [Talita Asia – Exit program for women leaving prostitution – Ulaanbaatar, Mongolia](#)

Хавсралт 2. ТХБ, НЦҮТ-ийн жагсаалт

	ТХБ-ын байршил	Харьяалал	Багтаамж (орны тоо)
1.	Архангай	ХГБХХЕГ	8
2.	Булган	ХГБХХЕГ	12
3.	Говьсүмбэр	ХГБХХЕГ	5
4.	Дундговь	ХГБХХЕГ	12
5.	Дорноговь	ХГБХХЕГ	7
6.	Дорноговь	ХГБХХЕГ	4
7.	Орхон	ХГБХХЕГ	5
8.	Сэлэнгэ	ХГБХХЕГ	10
9.	Сэлэнгэ	ХГБХХЕГ	4
10.	Сүхбаатар	Цагдаа	8
11.	Төв	Цагдаа	5
12.	Увс	ХГБХХЕГ	13
13.	Ховд	ХГБХХЕГ	12
14.	Баянзүрх дүүрэг	ХГБХХЕГ	18
15.	Баянзүрх дүүрэг (бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд хүлээж авдаг төрөлжсөн байр)	ХГБХХЕГ	8
16.	Чингэлтэй дүүрэг	ХТЭТ ТББ	6
17.	Баянгол дүүрэг	ХГБХХЕГ	16
18.	Баянгол дүүрэг	ХЭҮТ ТББ	20
19.	Хан-Уул дүүрэг	Цагдаа	30
20.	Налайх дүүрэг	ХГБХХЕГ	15
21.	Сонгинохайрхан дүүрэг	ХГБХХЕГ	19
22.	Хан-Уул дүүрэг	Талита Ази	6
23.	Багахангай	ХГБХХЕГ	8
Total			255

	НЦҮТ-ийн байршил	Харьяалал	Багтаамж (орны тоо)
1.	Баян-Өлгий	Цагдаа	12
2.	Баянхонгор	ХЭҮТ ТББ	8
3.	Говь-Алтай	Эмнэлэг	2
4.	Дархан-Уул	ХГБХХЕГ	24
5.	Дорнод	ХГБХХЕГ	6
6.	Завхан	Цагдаа	8
7.	Өвөрхангай	ХГБХХЕГ	12
8.	Өмнөговь	ХГБХХЕГ	15
9.	Хөвсгөл	ХГБХХЕГ	8
10.	Хэнтий	ХГБХХЕГ	4
11.	Баянзүрх дүүрэг	Цагдаа	4
12.	Чингэлтэй дүүрэг	ХГБХХЕГ	20
13.	Сүхбаатар дүүрэг	ХГБХХЕГ	8
14.	Сүхбаатар дүүрэг	Шүүх эмнэлэг	2
15.	Сүхбаатар дүүрэг	ЭМНТ	2
16.	Баянгол дүүрэг	ГССҮТ	4
17.	Хан-Уул дүүрэг	ХГБХХЕГ	6
Нийт			145

Хавсралт 3. ГБХ, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Нэг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр	
1	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн санал боловсруулах
2	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандартыг шинэчлэн боловсруулах
3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх дунд хугацааны төлөвлөгөөг батлуулах
4	Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэхэд салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах нь: Олон талт зөвлөлдөх уулзалт зохион байгуулах
5	Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэгдсэн этгээдийн хувийн мэдээллийг иргэд, олон нийтэд ил болгохтой холбоотой хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг ХЗДХЯ-нд хүргүүлэх
6	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх
Хоёр. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд	
7	Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын хэрэгжилтийн судалгаа хийх
8	Зөрчлийн хуулийн дагуу хариуцлага хүлээсэн өсвөр насны хүний нийгэмшихүйг дэмжих ажил, үйлчилгээний байдалд хүүхдийн оролцоотой хөндлөнгийн үнэлгээ хийж, үр дүнг хэлэлцүүлэх
9	“Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр сэтгүүлчдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулах
10	Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, танилцуулах
11	Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хамтарсан багийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах
12	“Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх” сургалтыг зохион байгуулах
13	Хууль сахиулах, нийгмийн хамгааллын салбарын сургагч багшаар бэлтгэгдсэн алба хаагчдаар дамжуулан салбарын албан хаагчдын хөгжлийн бэрхшээлтэй хүний болон бэлгийн цөөнхийн эрхийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах
14	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах
15	Дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч нарт бага насны охидын үзлэгийн талаар сургалт зохион байгуулах
16	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, мэдлэг олгох сургалт зохион байгуулах.
17	Өсвөр насны хүүхдийн нийгэмшихүйг дэмжих гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчид зориулсан гарын авлага боловсруулах
18	“Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” теле хичээл бэлтгэж, түгээх
19	Өсвөрийн сэргийлэгч-2025 уралдааныг зохион байгуулах
20	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг зохион байгуулах
21	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хийж буй ажил, арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг www.familycenter.mn цахим хуудаст тогтмол оруулж, иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх
22	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль зүйн мэдээ мэдээлийн рийл, контент бэлтгэж олон нийтэд түгээх

23	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэж буй аливаа контент, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байдлаар бэлтгэж, түгээх
24	Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, зохистой хэрэглээний талаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах
Гурав. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, үнэлэх ажлын хүрээнд	
25	ДХИС-ийг түшиглэн байгуулсан “Хууль зүйн зөвлөгөө өгөх төв”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хууль зүйн зөвлөгөө өгөх ажлыг хэвшүүлэх
26	Хорих ял шийтгүүлсэн, хорихоос суллагдсан, ХӨТЯШ хүүхэд болон тэдний гэр бүлд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх
27	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг дэмжих, туслалцаа үзүүлэх
28	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр иргэдэд сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө өгөх